



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



2017-2018 оны хичээлийн ЖИЛИЙН ТАЙЛАН

Ангийн тэмдэгт дүрсний тусламжтай



УЛААНБААТАР ХОТ
2018 ОН



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ



Хөдөлмөрийн гавьяаны
Улаан тугийн одонт
шинжлэх ухаан,
технологийн их сургууль

2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2018 он

Хянасан:

Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Н.Ганзориг

Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газрын дарга Ж.Арслан

Эмхэтгэсэн:

ЗХНГ-ын мэргэжилтэн

Ш.Доржсүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Ч.Болорчимэг

Үсгийн гагнитур: Mogul Centurion

Хэвлэлийн хэмжээ: B5 /176x250/

Хэвлэлийн хуудас: 15.3хх

Хэвлэсэн тоо: 200ш

ШУТИС, Хэвлэлийн газарт хэвлэв

2018 он

ГАРЧИГ

Өмнөх үг.....	5
НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	8
1.1 Удирдах зөвлөл	8
1.2 Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа	11
1.3 ШУТИС-ийн захирлын зөвлөл.....	14
1.4 Хөгжлийн үзүүлэлт, төлөвлөлт хөгжлийн хөтөлбөр төлөвлөлтийн зорилго нь.....	19
ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	28
2.1. Бакалаврын сургалт.....	28
2.1.1 Элсэлт.....	28
2.1.2 Суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн (гра)	31
2.1.3 Улирлын шалгалт	34
2.1.4 Шилжилт хөдөлгөөн, кредит дүйцүүлэлт.....	34
2.1.5 Байгууллагын магадлан итгэмжлэл	36
2.1.1 Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	38
2.1.2 Сургалтын үйл ажиллагааны хяналт, шалгалт	39
2.1.3 Төгсөлт	41
2.1.4 Судалгаа.....	43
2.2 Магистрын сургалт	47
2.2.1. 2017/2018 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилт	47
2.2.2 Магистрантурын элсэлт.....	48
2.2.3 Магистрантурын сургалтын төгсөлт.....	48
2.3 Докторын сургалт	50
2.3.1 Докторантурын сургалтын элсэлт.....	51
2.3.2 Докторантурын сургалтын төгсөлт	52
2.3.3 Докторын зэрэг хамгаалж төгссөн эрдэмтдийн мэдээлэл	53
2.3.4. Докторантур төгсөгчдийн голч дүнгийн үнэлгээ.....	55
2.4 Профессор багш нарын кредитийн судалгаа	58
2.5 Инженер, технологийн дээд боловсрол” төсөл	62
2.6 Шутис-коосон технологийн коллеж	65
2.7 Шутис-ийн харьяа ебс-ийн ахлах сургууль.....	67
2.8. Багшийн хөгжил	68
2.8.1 Үйл ажиллагаа.....	70
2.8.2 Сурган, заах арга зүйн сургалт	73
2.8.3 Хувь хүний хөгжил	74
ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ.....	78
3.1. 2017-2018 оны эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зорилт	78
3.2. Эрдэм шинжилгээний бүтээлийн хэвлэн нийтлэл	78
3.3. Эрдэм шинжилгээний арга хэмжээ.....	84
3.4. Технологийн сан, төсөл, гэрээт ажил.....	89
3.5. Оюуны өмч	96
3.6. Эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лабораторийн үйл ажиллагаа	97
3.7. Бусад.....	103
ДӨРӨВ. ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	106
4.1. Шутис-ийн багш, ажилтны гадаад томилолт, мэргэжил дээшлүүлэлт	106
4.2. Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг	107
4.3. Гадаадын мэргэжилтэн, багш зочин профессор.....	109
4.4. Оюутан солилцоо, гадаад оюутан, гадаадын тэтгэлэг.....	110
4.4.1. оюутан солилцоо.....	110

4.4.2. Гадаад оюутан.....	110
4.5. Гадаадын тэтгэлгүүд.....	111
4.6. Дотоод хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа.....	114
4.6.1. Маркетингийн бодлого боловсруулах ажлын хүрээнд.....	114
4.6.2. Хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажил.....	115
4.6.3. Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа.....	116

ТАВ. ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ..... 128

5.1. Хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа.....	128
5.2. Оюутны эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн.....	132
5.3. Оюутны санаачилгыг дэмжих төсөл.....	135
5.4. Оюутны клуб.....	136
5.5. Оюутны тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлт.....	140
5.6. Оюутны хөгжлийн зээл.....	141
5.7. Гадаад, дотоодын байгууллагын тэтгэлэг.....	144
5.8. Кредитийн урамшуулал.....	145
5.9. Оюутны үйлчилгээ.....	147
5.10. Оюутны байрны үйлчилгээ.....	149
5.11. Нэгдсэн арга хэмжээ.....	150
5.12. Олон нийт, нийгэмд чиглэсэн ажил.....	157
5.13. Хөдөлмөр эрхлэлт.....	158
5.14. Бусад.....	159
5.15. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлд.....	160

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ..... 168

6.1. Шинжлэх ухаан, технологийн номын сан.....	168
6.2. Номын сангийн үйлчилгээ, фонд бүрдүүлэлт.....	170
6.3. Сангийн автоматжуулалт, цахим үйлчилгээ.....	175
6.4. Соёлын хөтөлбөрт ажлууд.....	177
6.5. Шутис-ийн хэвлэлийн газар, хэвлэн нийтэлсэн байдал.....	178

ДОЛОО. САНХҮҮ, БҮРТГЭЛ..... 184

7.1. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба.....	184
7.2. Балансын бүтэц.....	184
7.3. Орлого үр дүн.....	189
7.4. Зарлага үр дүн.....	195
7.5. Нэг оюутанд ногдож буй зардал.....	204
7.6. Оюутны байрны орлого, зардал.....	205
7.7. Төвлөрсөн арга хэмжээний орлого, зардал.....	206
7.8. Санхүүгийн харьцаа.....	212
7.9. Санхүү тайлангийн аудит, зөвлөмж.....	213
7.10. Төсөв, төлөвлөлт, санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн талаар.....	215
7.11. Хөрөнгө оруулалт, хангамж.....	219
7.12. Байр ашиглалт.....	222

НАЙМ. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ..... 228

8.1. Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ.....	228
8.2. Албаны ажиллагсад мэргэжил мэдлэгээ дээшлүүлсэн.....	231
8.3. Дотоод аудит.....	232
Хавсралт 1-3.....	236

ӨМНӨХ ҮГ

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрхэм хүндэт профессор багш, ажилтан ажиллагсад, оюутан залуучууд бид ололт амжилтаар дүүрэн нэгэн хичээлийн жилийг үдэж, шинэ хичээлийн жилтэй учран золгож байна.

ШУТИС-ийн хамт олон өнгөрсөн хичээлийн жилд өмнөө тавьсан зорилго зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж, Монгол Улсад тэргүүлэх их сургуулийн нэг болон хүлээн зөвшөөрөгдөж байна. Тухайлбал ШУТИС 3 дахь шатны байгууллагын магадлан итгэмжлэлд орж магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргасны дагуу энэ оны 4 дүгээр сард Дээд боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээч нар ажиллаж “ХАНГАЛТТАЙ САЙН” үнэлгээ өгч, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 20 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэв. Мөн тус их сургуулийн “Архитектур”, “Үйлдвэрийн экологи”, “Шим тэжээл судлал”, “Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт” хөтөлбөрүүд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлж өнгөрсөн 6 сард гэрчилгээ гардан авлаа.

“ШУТИС-2021” Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэн, дунд хугацааны стратегийн зорилт, үндсэн чиглэл, шалгуур үзүүлэлтийг тодорхойлон нэр хүндээ тогтвортой өсгөж Азийн шилдэг их сургуулиудын нэг болох зорилт тавин ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд Ази тивийн их сургуулиудын үнэлгээ тогтоож ранкинг хийлгэдэг “QS ASIA” байгууллагаар ШУТИС-ийг үнэлүүлэх ажлыг зохион байгуулж 400+ ангилалд багтсаныг мэдэгдсэн бөгөөд бид Азийн шилдэг 250 их дээд сургуулиудын тоонд багтах зорилгодоо ойртож байна.

Их сургуулийн үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг туршин нэвтрүүлж, чанарын баталгаажуулалт хийлгэхээр бүтцийн өөрчлөлтийг хийж, их сургуулийн үйл ажиллагааг илүү үр ашигтай зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд их сургуулийн бүхий л үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлж, олон улсын шалгуураар үнэлж дүгнэдэг боллоо.

Манай их сургууль өнгөрсөн хичээлийн жилд санхүү хөрөнгө оруулалтын хүндрэлтэй байсан ч санхүүгийн хариуцлага, сахилга батыг сайжруулах, үргүй зардлаа бууруулах, сайжруулах замаар их сургуулийнхаа хөгжлийн асуудлуудыг амжилттай шийдвэрлэж хичээл сургалтын ажил хэвийн явагдах, зуны засвар тохижилтын ажил бүрэн хийгдлээ. Түүнчлэн ШУТИС-ийн захирлын тушаалаар 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/34 тоот тушаалаар ШУТИС-ийн цалингийн сүлжээгээр цалинждаг алба тушаалтнуудын албан тушаалын сарын үндсэн цалинг 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 10 хувиар нэмэгдүүлэв. Өнгөрсөн хичээлийн жилд шинэ хичээлийн VIII байрны барилгын ажлыг амжилттай эхлүүлж одоо барилга 50 хувийн гүйцэтгэлтэй баригдаад байна.


Үр дүнд суурилсан сургалтын тогтолцоог нэвтрүүлж, CDIO-гийн стандарт, арга зүйг ашиглан инженерийн боловсролын 26 хөтөлбөрт CDIO санаачлагыг хэрэгжүүлэхээр баталжээ. “Судалгаанд суурилсан их сургууль” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ахисан түвшний инженерийн сургууль байгуулах, судалгааны лабораториудыг төрөлжүүлэх, олон улсын болон үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх ажлуудыг хийж байна. Цахилгаан холбоо мэргэжлийн хөтөлбөрийг АНУ-д төвлөрч үйл ажиллагаа явуулдаг “ABET” байгууллагаар магадлан итгэмжлүүлэхээр шинжээчид ажиллажээ.

Монгол улсын дээд боловсролын салбарын орчин үеийн өөрчлөлт, шинэчлэлийг ШУТИС манлайлж, их сургуулийн удирдлагын мэдээллийн нэгдсэн систем, нээлттэй их сургууль болох электрон сургалтын систем, инженерийн боловсролд олон улсын шинэ стандарт нэвтрүүлэх, байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэх зэрэг олон шинэчлэлтийн анхдагч боллоо.

Энэ хичээлийн жил манай их сургуулийн хувьд ихээхэн онцлог түүхэн гэж хэлж болохоор байна. ШУТИС Монгол Улсад үндэсний инженер технологийн дээд боловсролтой мэргэжилтнүүдийг бэлтгэж ирсэн цагаас эхлээд 60 дахь хичээлийн жилтэй золгож байна. 2019 онд манай их сургууль үүсч байгуулагдсаны 60 жилийн түүхт ойг албан ёсоор тэмдэглэх гэж байгаа. Ийм учраас энэ хичээлийн жил бол түүхт 60 жилийн ойгоо угтсан их бүтээн байгуулалт, их бүтээлч ажлын өрнүүн жил болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Манай их сургуулийн профессор багш нар өнгөрөгч хичээлийн жилд өөрийн эрхэлсэн үйл ажиллагаандаа амжилттай ажиллаж, их сургуулийн 60 үндсэн сурах бичгийг бичиж хэвлүүлэх ажлыг эхлүүлэн, эхний сурах бичиг хэвлэгдэн гарч байна. Их сургуулийн хамт олон өнгөрсөн онд ололт, амжилт, үр дүнд тулгуурлан шинэ хичээлийн жилийн зорилго, зорилтоо тодорхойлон ажиллаж байна. Тухайлбал бид 2017/2018 оны хичээлийн жилд их сургуулийн чанарын удирдлагын тогтолцоог үе шаттай бүрдүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Манай их сургуулийн олон улсад үнэлгээ хийлгэх, Азийн их сургуулиудын хэмжээнд ранкинг хийлгэх үйл ажиллагаа энэ хичээлийн жилд жинхэнэ утгаараа хэрэгжих гэж байна. Түүхт 60 жилийн ойгоо угтаж их бүтээн байгуулалт бүтээлч ажлыг өрнүүлэн ажиллах зорилттой. Их сургуулийн түүхийн 6 боть номыг дэлгэж олон нийтийн хүртээл болгоно. Манай их сургуулийн оюутан, суралцагчид өөрийн эзэмшсэн мэргэжил, ур чадвараа улам хөгжүүлж их сургуулийн инженерийн боловсролын тогтолцоог өөрчлөн шинэчлэн буй энэ цаг үед CDIO-гийн аргачлал, стандартын дагуу шинэ сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа. Судалгааны их сургууль болон хөгжих, инноваци гарааны компаниудаа өнгөрсөн онд баталсан дүрэм журмын хүрээнд шинэчлэн зохион байгуулж хөгжүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг шинэ хичээлийн жилд дэвшүүлэн ажиллах болно. ШУТИС-ийн эрхэм хүндэт профессор багш, оюутан, суралцагчид та бүхэнд шинэ хичээлийн жилдээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

РЕКТОР



Б.ОЧИРБАТ



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ШУТИС бүрэлдэхүүн болон харьяа сургууль, институт, ахисан түвшний сургууль, ШУТИС-Коосэн технологийн коллеж, ахлах сургууль, МСҮТ, сургалт, судалгаа, инновацийн хүрээлэн, төв зэрэг зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажиллав.

Улаанбаатар хотод 8, орон нутагт 1, нийт 9 бүрэлдэхүүн сургууль, 1 харьяа сургууль, 2 институт, Бизнесийн ахисан түвшний сургууль, ШУТИС-Коосэн технологийн коллеж, ШУТИС-ийн харьяа ЕБС-ийн ахлах сургуультайгаар үйл ажиллагаа явууллаа.

ШУТИС-ийн Захиргаа нь:

ШУТИС-ийн захирал

Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал,

Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал,

Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал,

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал,

5 газар: Захиргаа, хүний нөөцийн газар,

Сургалтын бодлого зохицуулалтын газар,

Эрдэм шинжилгээ, инновацийн газар,

Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газар,

Хөрөнгө оруулалт, хангамжийн газар,

9 алба: Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба,

Оюутны соёл, үйлчилгээний алба,

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба,

Дотоод аудитын алба,

Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба,

Хөгжлийн үзүүлэлт, статистикийн алба,

Маркетинг, олон нийттэй харилцах алба,

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба,

Байр ашиглалтын нэгдсэн алба,

Мөн Шинжлэх ухаан технологийн төв номын сан, Багшийн хөгжлийн төв, Эрүүл мэнд, спортын төв, ОУДБС-ын төв, ШУТИС-Хэвлэлийн газар, Горхи дахь оюутны дадлагын полигон гэсэн нэгжүүд захиргааны бүтцэд үйл ажиллагаа явуулав.

Бүрэлдэхүүн сургууль, институтийн салбар, тэнхим

Хүснэгт 1.1

№	Бүрэлдэхүүн сургууль	№	Тэнхим (салбар)
1	Барилга, архитектурын сургууль	1	Барилгын инженерийн салбар
		2	Хүрээлэн буй орчны инженерийн салбар
		3	Архитектурын салбар
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	4	Бизнесийн удирдлагын салбар
		5	Технологийн менежментийн салбар
		6	Нийгмийн ухааны салбар
		7	Хүмүүнлэгийн ухааны салбар
3	Геологи, уул уурхайн сургууль	8	Геологи, гидрогеологийн салбар
		9	Газрын тос, өрөмдлөгийн салбар
		10	Уул уурхайн салбар
		11	Геодезийн салбар
4	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	12	Инженерчлэлийн салбар
		13	Технологийн салбар

		14	Суурь шинжлэх ухааны салбар
5	Механик, тээврийн сургууль	15	Механик, мехатроникийн салбар
		16	Тээврийн салбар
		17	Машин үйлдвэрлэлийн салбар
		18	Техникийн механикийн салбар
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	19	Холбооны салбар
		20	Электроникийн салбар
		21	Мэдээллийн технологийн салбар
		22	Компьютерийн ухааны салбар
		23	Мэдээллийн сүлжээ, аюулгүй байдлын салбар
7	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	24	Хүнсний инженерчлэлийн салбар
		25	Биотехнологи, шим тэжээлийн салбар
		26	Ой модны үйлдвэрлэлийн технологийн салбар
		27	Текстил судлалын салбар
		28	Дизайны салбар
8	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	29	Математикийн тэнхим
		30	Химийн инженерчлэлийн тэнхим
		31	Физикын тэнхим
		32	Биеийн тамир, спортын тэнхим
9	Эрчим хүчний сургууль	33	Цахилгааны инженер салбар
		34	Цахилгаан техникийн салбар
		35	Дулааны инженерийн салбар
10	Е – Нээлттэй институт	36	Виртуал технологийн тэнхим
11	Гадаад хэлний институт	37	Европ судлалын тэнхим
		38	Англи хэл судлалын тэнхим
		39	Ази судлалын тэнхим
		40	Монгол судлалын тэнхим
		41	Хэрэглээний хэл шинжлэлийн тэнхим

1.1. УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн А/205 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар томиллоо. Хамт олны төлөөлөл, багш, оюутны төлөөлөл, төгсөгчийн төлөөллийг хамт олны хурлаас ШУТИС-ийн удирдах зөвлөлд нэр дэвшүүлэн сонгов.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд

Хүснэгт 1.2.а

Д/д	Албан тушаал	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
I. Төрийн төлөөлөл			
1	Дарга	Т.Амаржаргалан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
2	Дэд дарга	Н.Отгонбаяр	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хэлтсийн дарга
3	Гишүүн	У.Отгонбаяр	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
4		Н.Болдхүү	Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
5		Ж.Гантөмөр	Зам тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

6		Д.Батжаргал	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
7		С.Наранцогт	Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга
8		Т.Гантогтох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
9		А.Халиунаа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсролын хэлтсийн дарга
II.Хамт олны төлөөлөл			
10	Гишүүн	Л.Оюунцэцэг	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн салбарын эрхлэгч
11		Д.Оюун	Геологи, уул уурхайн сургуулийн профессор
12		И.Базаррагчаа	Механик, тээврийн сургуулийн ахлах багш
13		Д.Болор	Скаймедиа ХХК-д гүйцэтгэх захирал
14		Б.Ганбаатар	“ДЦС-3-ийн түлш дамжуулах цехийн шинэчлэл” төслийн удирдагч
15		С.Болд-Эрдэнэ	Геологи, уул уурхайн сургуулийн оюутан

Мөн тухайн хичээлийн жилд Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг өөрчлөх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/272 дугаар тушаал гарч ШУТИС-ийн удирдах зөвлөл дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэгдэв.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.2.6

Д/д	Албан тушаал	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
I.Төрийн төлөөлөл			
1	Дарга	Б.Ганбат	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын зөвлөх
2	Дэд дарга	Т.Амаржаргалан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
3	Гишүүн	С.Магнайсүрэн	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга
4		Ж.Ганбат	Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга
5		Т.Гантогтох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
6		С.Цэрэнжамц	Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга
7		Н.Бат-Эрдэнэ	Зам тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
8		А.Халиунаа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсролын хэлтсийн дарга
9		Б.Энхтуяа	Нийгэм, эдийн засгийн судалгаа сан төрийн бус байгууллагын тэргүүн
II.Хамт олны төлөөлөл			

10	Гишүүн	Л.Оюунцэцэг	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн салбарын эрхлэгч
11		Д.Оюун	Геологи, уул уурхайн сургуулийн профессор
12		И.Базаррагчаа	Механик, тээврийн сургуулийн ахлах багш
13		Д.Болор	Скаймедиа ХХК-д гүйцэтгэх захирал
14		Б.Ганбаатар	“ДЦС-3-ийн түлш дамжуулах цехийн шинэчлэл” төслийн удирдагч
15		С.Болд-Эрдэнэ	Геологи, уул уурхайн сургуулийн оюутан

ШУТИС-ийн Удирдах зөвлөл өнгөрсөн хичээлийн жилийн хугацаанд 4 удаа хуралдаж ШУТИС-ийн 2017 оны төсвийн төсөл, найдваргүй авлага, өр төлбөрийг хүчингүй болгох, ШУТИС-ийн 2018 оны орлого, зарлагын төсөв, ШУТИС-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит Эрдэнэтийн технологийн сургуулийн статусын асуудал, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, “МГТ-Монгол улс санаачлага” төслийн үр дүнгийн танилцуулга, МСҮТ, коллежээс шилжин ирсэн багш нарын тэтгэмжийн асуудал, ШУТИС-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, 2018 оны үйл ажиллагааны зорилт, Захиргааны бүтэц, 2018/2019 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоо, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Аудитын дүгнэлт зөвлөмж, 1 кредитийн үнэлгээ, Нанотехнологийн үйлдвэр байгуулах зэрэг асуудлуудыг хэлэлцэж, тодорхой шийдвэрүүд гаргажээ.

Хичээлийн жилийн хугацаанд ШУТИС-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, уулзалт семинар бусад арга хэмжээнд Удирдах зөвлөлийн гишүүд оролцож, их сургуулийг хөгжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулахад анхаарч, дэмжлэг үзүүлэн ажиллаа.

1.2. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрдэм шинжилгээ, инновацийн газар нь үйл ажиллагааныхаа чиг үүргийн дагуу ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаан болон түүний байнгын ажиллагаатай Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл, Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллаганы дэд зөвлөлийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн захирлын А/240 тоот тушаалаар шинэчлэгдэн 55 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан ба гадаадад докторын зэрэг хамгаалсан залуу эрдэмтдийн төлөөллийг оролцуулах бодлого барьж бүрэлдэхүүнийг байгуулсан нь ШУТИС-ийн залуу эрдэмтдийн оролцоог дэмжсэн үйл ажиллагаа болсон юм.

Тайлант онд Эрдмийн зөвлөл 3 удаа хуралдаж, чиг үүргийнхээ дагуу дүрэм, журам батлах, эрдмийн ба хүндэт цол олгох асуудлыг хэлэлцэх, зарим нэгж салбарын зохион байгуулалтыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал

Хүснэгт 1.2

Д/Д	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
1	ШУТИС-ийн Хүндэт профессор /3/, Профессор /3/, дэд профессор /5/ цол олгох тухай	2017.10.02	°07, 08, 09
2	“ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-д өөрчлөлт оруулах тухай, ШУТИС-ийн зарим салбаруудыг өөрчлөн зохион байгуулах тухай	2018.01.11	°01, 02
3	ШУТИС-ийн Хүндэт профессор /8/ цол олгох тухай; ШУТИС-ийн Дэд профессор /11/ цол олгох тухай; ШУТИС-ийн профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай; Инженерийн ахисан түвшний сургууль байгуулах тухай; Хөтөлбөрт мэргэжлийн чиглэл нэмэх, мэргэжил нээх тухай.	2018.06.28	°03,04,05,06,07,08,09

Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг ШУТИС-ийн захирлын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/13 тоот тушаалаар дараах бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Үүнд:

1. Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл /гишүүн-12/
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дэд зөвлөл /гишүүн-11/
3. Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл /гишүүн-12/
4. Сургалт, оюутны хөгжлийн дэд зөвлөл /гишүүн-12/
5. Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын дэд зөвлөл /гишүүн-12/

Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал

Хүснэгт 1.3

Д/Д	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
1.Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл			
1	Хүндэт доктор, хүндэт профессор цол олгох тухай	2017.09.26	°03
2	ШУТИС-ийн Хүндэт профессор /8/, дэд профессор /11/ цол олгох тухай	2018.06.14	°01
2.Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл			
1	Улсын захиалгат төслүүдийн хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	2017.12.14-15	-
2	“ШУТИС-ийн дэргэд гарааны компани байгуулах, хөгжүүлэх журам”-ын төсөл, ИТДБ төслийн хамтарсан судалгааны төслүүдийн явц, үр дүнг хэлэлцэх, МХТС-ийн гарааны компани байгуулах санал хэлэлцэх тухай	2018.03.02	°01
3	ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төв, хүрээлэнгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцүүлэх тухай	2018.04.11-12	°02
4	ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй төслүүдийн тайлан хэлэлцүүлэх тухай	2018.06.07	°03
3.Сургалт, оюутны хөгжлийн дэд зөвлөл			
1	Хөтөлбөрт мэргэжлийн чиглэл нэмэх, мэргэжил нээх тухай	2018.06.27	°01

ШУТИС-ийн “Хүндэт профессор” цол хүртэгсэд

Хүснэгт 1.4

Д/Д	Овог нэр	Сургууль, байгууллага	Тушаалын дугаар	Огноо
1	Р.ГАНБОЛД	Юнител группын захирлуудын зөвлөлийн дарга /МХТС/	°А/174 /тушаал/	2017.10.03
2	Д.БАЯР	“Хасу Мегаватт” ХХК /МХТС/	°А/175	2017.10.03
3	Ө.ГҮРЖАВ	“Түмэн анд” ХХК-ийн ерөнхий захирал /ЭХС/	°А/173	2017.10.03
4	Пүрэвжав ОЮУНСҮРЭН	ОрТС-ийн УУ-ийн тэнхимийн гэрээт багш	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28
5	Дэндэв НЯМДОРЖ	ОрТС-ийн УУ-ийн тэнхимийн зөвлөх профессор	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28
6	Должин ЦОГТХАНГАЙ	ОрТС-ийн УУ-ийн тэнхимийн гэрээт багш	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28
7	Жамба ГАН-ОЧИР	“Цардуултайн ундарга” ХХК, “Голден алып” группын зөвлөх /ГУУС/	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28
8	Алмалик ТЛЕЙХАН	Эрчим хүчний зохицуулах хорооны дарга /ЭХС/	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28
9	Орос ПҮРЭВЖАЛ	ЭХС-ийн ахлах багш	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28
10	Лувсандорж ДАРАМБАЗАР	Эрчим хүчний зураг төслийн пугам ХХК-д зөвлөх инженер /ЭХС/	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28
11	Шарав БҮРЭН	ХБНГУ-ын Фраунхофер институтийн усны системийн цогц менежментийн хэлтсийн дарга /ДаТС/	Эрдмийн зөвлөлийн тогтоол °03	2018.06.28

ШУТИС-ийн профессор, дэд профессор цол хүртэгсэд

Хүснэгт 1.5

Профессор			
1	С.Байгалтөгс	БуХС	П20170147
2	Л.Отгонцэцэг	БуХС	П20170148
3	С.Чулуунхуяг	БАС	П20170149
Дэд профессор			
1	Баасан БАТ-УНДРАЛ	ЭХС	ДП20170282
2	Содов ЭРДЭНЭТУЯА	ЭХС	ДП20170283
3	Дорж-Юндэн АЛТАНХУЯГ	ГУУС	ДП20170284
4	Батсүх САРАНТУЯА	БУХС	ДП20170285
5	Цолмон СОНИНХИШИГ	ҮТС	ДП20170286
6	Содномтүвшрэв БАРХАС	ГХИ	ДП20180287
7	Жаргалсайхан АЛИМАА	ЕНИ	ДП20180288
8	Пүрэвжав НАРАНТУЯА	ГУУС	ДП20180289
9	Пүрэвээ АРИУНБОЛОР	ГУУС	ДП20180290
10	Содном ХИШИГСҮРЭН	ГУУС	ДП20180291
11	Сийнхой ЦЭЦГЭЭ	ҮТС	ДП20180292


12	Чойрог ДОРЛИГСҮРЭН	БАС	ДП20180293
13	Янжив ТӨГӨЛЦӨР	БүХС	ДП20180294
14	Найдан АРИУНТУЯА	БАТС	ДП20180295
15	Айлиа ЦЭЦЭГМАА	ХШУС	ДП20180296
16	Цэрэндорж МӨНХТУЯА	МехТС	ДП20180297

2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөр хуралдсан Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн хурлаар Хүндэт профессор цолд 8, дэд профессор цолд 11 нэр дэвшигчийг гишүүдийн олонхийн санал хураалтаар шалгаруулж Эрдмийн зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, гишүүдийн 90-ээс дээш хувийн саналаар бүгд дэмжигдэв.

1.3. ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

2017/2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах санал бүрэлдэхүүн сургууль, институт, газар алба нэгжээс авч нэгтгэн батлуулав.

ШУТИС-ийн захирлын зөвлөл 2017/2018 хичээлийн жилд батлагдсан төлөвлөгөөний дагуу 22 удаа хуралдаж 102 асуудал хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд төсөв, төлөвлөгөө, тайлан баланс, цалин хөлс, элсэлт төгсөлт, сургалтын үйл ажиллагааны тухай, мэргэжил, сургалтын төлбөр, судалгааны төв, эрдэм шинжилгээний хурал үзэсгэлэн зохион байгуулах, дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, багш нарын нийгмийн асуудал, ой тэмдэглэх, уралдаан зарлах, гадаад харилцаа, гэрээ байгуулах, ахисан түвшний сургууль байгуулах тухай, аудит болон дотоод хяналт шалгалтын дүгнэлт, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл /хөтөлбөрүүдийн/-ийн явц, үр дүн, зуны засвар тохижилтын ажлын тухай, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, элсэлтийн хяналтын тоо, 2017/2018 оны хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанли, төсвийн тодотгол, цаг үеийн асуудлыг хэлэлцсэн.



Зураг 1.1. ШУТИС-ийн захирлын зөвлөлөөр хэлэлцсэн асуудлын тоо

Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын шийдвэрийг цаг тухайд нь их сургуулийн <http://www.must.edu.mn/mn/content/> вэб хуудаст оруулж байна.

ШУТИС-ийн захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.6

Д/Д	Овог нэр	Албан тушаал
1	Б.Очирбат	ШУТИС-ийн Захирал
2	Х.Энхжаргал	Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал
3	Т.Намнан	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал
4	Б.Сүхбат	Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал
5	Л.Баяр-Эрдэнэ	Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал
6	Ц.Баатархүү	Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал
7	Н.Ганзориг	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга
8	Э.Нинжгарав	БАС-ийн захирал
9	А.Энхбат	БуХС-ийн захирал
10	Л.Пүрэв	ГУУС-ийн захирал
11	Ц.Батбаатар	ДаТС-ийн захирал
12	Д.Цолмонбаатар	МехТС-ийн захирал
13	Н.Чулуунбанди	МХТС-ийн захирал
14	Ж.Туяацэцэг	ҮТС-ийн захирал
15	Д.Ганхуяг	ХШУС-ийн захирал
16	Ч.Мангалжалав	ЭХС-ийн захирал
17	Б.Соёлсүрэн	ГХИ-ийн захирал
18	Я.Наранцэцэг	Е-НИ-ийн захирал
19	С.Дэлгэрмаа	Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны дарга
20	С.Болд-Эрдэнэ	Оюутны холбоо

Шагнал, урамшуулал

Тайлангийн хугацаанд тэмдэглэлт ой, түүхэн үйл явдлыг тохиолдуулан ШУТИС-ийн багш, ажилтнууд Төрийн дээд одон, медаль, Засгийн газрын болон яам, их сургуулийн шагналаар шагнагдсан.

Төрийн одон, медаль, Засгийн газрын болон бусад шагналаар шагнагдагсад

Хүснэгт 1.7

Д/Д	Овог нэр	Албан тушаал
Монгол Улсын Гавьяат багш		
1	П.Болд	БАС-ийн ахмад багш
2	Х.Пүрэвдагва	БУХС-ийн ахмад профессор
3	Б.Сэрвүүд	МехТС-ийн ахмад багш
Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон		
4	П.Отгонбаяр	БАС-ийн профессор
5	Ч.Дагшигдорж	БАС-ийн профессор
6	Д.Нямсүрэн	ХШУС-ийн ахмад багш
Алтангадас одон		
7	Г.Баттүвшин	БАТС-ийн захирал
8	Н.Галиймаа	БуХС-ийн салбарын эрхлэгч
9	Б.Даваажав	БуХС-ийн ахмад багш
10	Ж.Гомбо	БАС-ийн ахмад багш
11	М.Оюунцэцэг	БуХС-ийн ахмад багш
12	Л.Баярхүү	БуХС-ийн ОБ-ын эрхлэгч
13	Б.Алтантуяа	ГУУС-ийн дэд профессор
14	Ү.Жамсран	МехТС-ийн багш
15	О.Баатарзоригт	ХШУС-ийн тэнхимийн эрхлэгч
16	Ч.Ням	ХШУС-ийн ахлах багш
17	С.Цэрэв	ХШУС-ийн ахмад багш
18	Ц.Сарантуяа	ХШУС-ийн ахмад багш

19	Б.Бадам-Очир	ХШУС-ийн багш
20	Б.Пүрэвсүрэн	БуХС-ийн профессор
21	Т.Амаржаргал	БуХС-ийн ахмад гэрээт багш
22	Б.Энхтуяа	ҮТС-ийн профессор
23	З.Баттогтох	ЭХС-ийн дэд профессор
24	С.Хүрэлчулуун	ДаТС-ийн ахлах багш
25	Г.Болд	ДаТС-ийн ахлах багш
26	С.Дугармаа	ГХИ-ийн дэд профессор
Хөдөлмөрийн хүндэт медаль		
27	Н.Нямдорж	БуХС-ийн ахлах багш
28	Д.Ганбат	МехТС-ийн профессор
29	Г.Төрмөнх	ҮТС-ийн ХСЭШТ-ийн захирал
30	Н.Нямдорж	БуХС-ийн ахлах багш
31	С.Сийглэгмаа	ГУУС-ийн ахлах багш
32	Д.Даш-Очир	ДаТС-ийн ахлах багш
Боловсролын тэргүүний ажилтан		
33	Д.Эрдэнэцэцэг	ГУУС-ийн сургалтын мастер
34	Ч.Болормаа	ГУУС-ийн багш
35	С.Жаргалан	ГУУС-ийн профессор
36	Д.Сарантуяа	ДаТС-ийн ахлах багш
37	У.Мөнхцэцэг	ДаТС-ийн тэнхимийн эрхлэгч
38	Ц.Оюунцэцэг	МехТС-ийн ахлах багш
39	Ц.Мөнхтуяа	МехТС-ийн ахлах багш
40	Т.Ганбат	МехТС-ийн ахлах багш
41	Б.Должинсүрэн	МехТС-ийн ахлах багш
42	М.Дэлгэрмаа	МехТС-ийн профессор
43	Д.Батсүх	МехТС-ийн ахлах багш
44	П.Өлзийсайхан	МехТС-ийн ахлах багш
45	С.Ариунбаяр	МехТС-ийн ахлах багш
46	С.Янжинлхам	МехТС-ийн багш
47	Я.Дашдорж	МХТС-ийн салбарын эрхлэгч
48	О.Цэцэгээ	МХТС-ийн ахмад багш
49	Н.Чулуунбанди	МХТС-Захирал
50	Б.Батзолбоо	МХТС-ийн дэд профессор
51	Б.Луубаатар	МХТС-ийн ахлах багш
52	Ц.Хүрэлбаатар	МХТС-ийн ахлах багш
53	Я.Алтанцэцэг	ҮТС-ийн профессор
54	Д.Бурмаа	ХШУС-ийн дэд профессор
55	Ц.Жаргалсайхан	ХШУС-ийн салбарын эрхлэгч
56	В.Чимэдлодой	ХШУС-ийн ахлах багш
57	Т.Баяртөгс	ХШУС-ийн ахлах багш
58	Г.Зоригт	ХШУС-ийн ахлах багш
59	Б.Пүрэвсүрэн	ЭХС-ийн дэд профессор
60	Д.Цэрэндолгор	ЭХС-ийн салбарын эрхлэгч
61	П.Эрхэмтөр	ЭХС-ийн багш
62	Ж.Алимаа	Е-НИ-ийн дэд профессор
63	И.Сарантуяа	ГХИ-ийн ахлах багш
64	Б.Байгалмаа	ГХИ-ийн ахлах багш
65	Д.Туяа	ГХИ-ийн багш
66	Б.Туяа	ГХИ-ийн ахлах багш
67	Ю.Болдбаатар	БуХС-ийн дэд профессор
68	Н.Ариунтуяа	БуХС, БАТС-ийн ахлах багш
69	Б.Бат-Өлзий	БуХС-ийн ахлах багш
70	Д.Ариунтогос	БуХС-ийн дадлагажигч багш
71	А.Болормаа	БуХС-ийн ахлах багш
72	Я.Оюунтунгалаг	БуХС-ийн профессор

73	Т.Оюунбилэг	БуХС-ийн ахлах багш
74	Ж.Баасангэрэл	БуХС-ийн багш
75	М.Заяа	БуХС-ийн салбарын эрхлэгч
76	Д.Содномзул	БуХС-ийн ахлах багш
77	М.Банзрагч	БуХС-ийн дэд профессор
78	Д.Ганбаатар	БуХС-ийн дэд захирал
79	М.Жавзансүрэн	БуХС-ийн ахлах багш
80	А.Уранчимэг	БуХС-ийн СХХА ажилтан
Шинжлэх ухааны тэргүүний ажилтан		
81	Б.Цэцгээ	БуХС-ийн профессор
82	П.Жаргалтуяа	БуХС-ийн салбарын эрхлэгч
83	Д.Ганбат	МехТС-ийн салбарын эрхлэгч
84	Д.Батмөнх	МехТС-ийн дэд профессор
85	Н.Нямцэрэн	МехТС-ийн ахмад багш
86	И.Цэрэн-Онолт	МХТС-ийн дэд профессор
87	Б.Батзолбоо	МХТС-ийн профессор
88	Ж.Оюунтүлхүүр	ҮТС-ийн профессор
89	Д.Нямсүрэн	ХШУС-ийн профессор
90	Ц.Цэцэгмаа	ГХИ-ийн тэнхимийн эрхлэгч
91	Д.Болд	ГХИ-ийн профессор
БСШУСЯ-ны Жуух бичиг		
92	Н.Чулуунбаатар	БАС-ийн ахлах багш
93	Ч.Натархорол	БАС-ийн эрхлэгчийн туслах
94	Ц.Уранцэцэг	БАС-ийн Ахлах багш
95	Д.Ганлхагва	ГУУС-ийн ахлах багш
96	Э.Ганзориг	ГУУС-ийн багш
97	С.Лхаахүү	ГУУС-ийн ахлах багш
98	Я.Рэнчинванжил	МехТС-ийн дэд профессор
99	И.Ууганцэцэг	МехТС-ийн МСҮТ-ийн багш
100	Т.Магсаржав	МХТС-ийн ахлах багш
101	Г.Саранцэцэг	МХТС-ийн ахлах нягтлан бодогч
102	П.Нямсүрэн	МХТС-ийн багш
103	Ч.Оюу	МХТС-ийн ахлах багш
104	Б.Энхтөгс	МХТС-ийн төвийн захирал
105	А.Хүдэр	МХТС-ийн ахлах багш
106	Г.Баяр	МХТС-ийн ахлах багш
107	Ч.Батчулуун	МХТС-ийн ахлах багш
108	Р.Мядагмаа	ҮТС-ийн дэд профессор
109	Д.Цэцэгмаа	ҮТС-ийн ахлах багш
110	Д.Оюунцэцэг	ҮТС-ийн ахлах багш
111	Н.Атарбаясгалан	ҮТС-ийн сургалтын мастер
112	Э.Энхцэцэг	ХШУС-ийн дэд профессор
113	Д.Илчгэрэл	ХШУС-ийн дэд профессор
114	Ч.Алдармаа	ХШУС-ийн тэнхимийн эрхлэгч
115	Д.Пүрэвдаш	ЭХС-ийн ахлах багш
116	П.Бямбацогт	ЭХС-ийн салбарын эрхлэгч
117	Х.Сарангэрэл	ЭХС-ийн ахлах багш
118	г.Эрдэнчимэг	Е-НИ-ийн ахлах багш
119	Г.Уранчимэг	ГХИ-ийн ахлах багш
120	Б.Бурмаа	ГХИ-ийн багш
121	Л.Алимаа	ШУТАС-ийн нярав
122	Э.Баярмаа	ОСҮА-ны мэргэжилтэн
123	С.Саруулболд	ДаТС-ийн ахлах багш
124	Р.Пүрэвсүрэн	ДаТС-ийн багш
125	С.Ариунцэцэг	БуХС-ийн ахлах багш
126	А.Нарангэрэл	БуХС-ийн ахлах багш

127	Т.Нямдулам	БуХС-ийн ахлах багш
128	Ч.Должинсүрэн	БуХС-ийн ахлах багш
129	Б.Болормаа	БуХС-ийн ахлах багш
130	Л.Амартүвшин	БуХС-ийн дэд профессор
131	Т.Сүмжидмаа	БуХС-ийн ахлах багш
132	Д.Төрмөнх	БуХС-ийн ахлах багш
133	Д.Алтанцэцэг	БуХС-ийн ахлах багш
134	Б.Алтанхуяг	БуХС-ийн ахлах багш
135	М.Бурмаа	БуХС-ийн ахлах багш
136	Б.Баттулга	БуХС-ийн багш
137	Г.Гантөгс	БуХС-ийн дэд профессор
138	Д.Ариунжаргал	БуХС-ийн ахлах багш
139	Г.Тунгалагтуяа	БуХС-ийн ахлах багш
140	Ч.Нямбаяр	БуХС-ийн ахлах багш
141	Д.Эрдэнэцэцэг	БуХС-ийн ЭШИХ-сан ажилтан
ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн шагнал		
142	Х.Отгон-Эрдэнэ	ЭША-ны дарга
143	П.Дамдин	ҮТС-ийн ахмад багш
144	О.Алтанзагас	БАС-ийн багш
145	Б.Цэцгээ	БуХС-ийн профессор
146	М.Оюунтөгс	ГУУС-ийн профессор
147	Х.Жанчивдорж	ДаТС-ийн дэд профессор
148	Ж.Мягмаржав	МехТС-ийн ахлах багш
149	Б.Отгонбаяр	МХТС-ийн профессор
150	Young Il Kim	МХТС-ийн төслийн удирдагч
151	Д.Батбаяр	ҮТС-ийн ахлах багш
152	Г.Бэхбат	ЭХС-ийн ахлах багш
153	Ч.Золзаяа	ГХИ-ийн тэнхимийн эрхлэгч
154	Б.Мөнхчимэг	Е-НИ-ийн ахлах багш
ШУТИС-ийн Захирлын нэрэмжит шагнал		
155	Д.Буянтогтох	ХШУС-ийн захирал
156	Д.Золзаяа	ШУТГНС-ийн номын санч
157	Д.Сүмжидмаа	БАС-ийн дэд профессор
158	О.Болормаа	БуХС-ийн ахлах багш
159	Б.Эрдэнэцэцэг	ГУУС-ийн профессор
160	С.Хишигсүрэн	ГУУС-ийн дэд профессор
161	Д.Чулуунтөмөр	ДаТС-ийн ГСАС сургалтын менежер
162	Н.Төмөрбаатар	МехТС-ийн ахмад профессор
163	Д.Дэлэг	МехТС-ийн ахмад профессор
164	Ц.Ариунаа	МХТС-ийн ахлах багш
165	А.Хүдэр	МХТС-ийн ахлах багш
166	П.Туул	ҮТС-ийн ахлах багш
167	С.Баярсайхан	ХШУС-ийн ахлах багш
168	Ч.Рэнчиндорж	ЭХС-ийн багш
169	М.Баттулга	ЭХС-ийн багш
170	Г.Ариунаа	ГХИ-ийн ахлах багш
171	Ц.Энхбаатар	ГХИ-ийн дэд захирал
172	Н.Дөлгөөн	Е-НИ-ийн багш
173	М.Булган	ХБКоллеж МУКонсерватор багш
174	Ц.Алтангэрэл	ХБКоллеж МУКонсерватор багш
175	Б.Сүхээ	ХБКоллеж МУКонсерватор багш
176	Л.Ганболд	ЭХС-ийн аж ахуйн нярав
177	Г.Ухнаа	ГУУС-ийн ахмад профессор
178	Л.Оюун	ЭМСТ-ийн их эмч
179	Ш.Доржсүрэн	ЗХНГ-ын мэргэжилтэн

1.4. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛГО НЬ:

ШУТИС-ийн хэтийн төлөвлөлт, хөгжлийн үзүүлэлтэд шаардлагатай тоон үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийж, их сургуулийн хэмжээнд үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлуулах, батлагдсан төсөвт хяналт тавих, маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжлийн үзүүлэлт, статистик мэдээ, мэдээллийг стандарт, арга зүйн дагуу боловсруулах, их сургуулийн удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

1.4.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

ШУТИС-ийн хэмжээнд 2017/2018 оны хичээлийн жилд дараах үндсэн ажлыг гүйцэтгэв. Үүнд:

1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институтийн 2017/2018 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, саналыг хүлээн авч ШУТИС-ийн хэмжээнд нэгтгэн батлуулав.
2. ШУТИС-ийн 2015-2016, 2016-2017 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны статистик үзүүлэлтүүдийн судалгааг ШУТИС-ийн Захирлын зөвлөлын хурлаар хянуулсан.
3. ШУТИС-ийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг байгуулан дараах чиглэлээр ажиллаж байна. (Сургалтын бодлогын баримт бичиг, Эрдэм шинжилгээ инновацын бодлогын баримт бичиг, Хүний нөөцийн баримтлах бодлогын баримт бичиг)
4. 2017/2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль хооронд мөрдөх коэффициентыг шинэчлэн батлуулав.
5. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, газар, алба, нэгжүүдээс 2018 оны төсвийн төслийг хүлээн авч ШУТИС-ийн хэмжээнд нэгтгэн боловсруулж, нэгдсэн төсөв, төлөвлөгөөг батлуулав (УЗ-ийн 2017 оны 12 сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоол).
6. ШУТИС-ийг гурав дахь шатны Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлд оруулах үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, өөрийн үнэлгээний тайланг боловсруулж, шинжилгээ хийв.
7. ШУТИС-ийн профессор, багш нарын 2015-2017 оны хичээлийн жилүүдийн кредитын бодит гүйцэтгэл, цалин хөлсний судалгааг боловсруулан Захирлын зөвлөлд танилцуулав.
8. ШУТИС-ийн багш, ажиллагчдын цалинг нэмэгдүүлэх тооцоо, судалгааг гарган, 2018 оны 03 сарын 01-нээс үндсэн цалинг нэмэгдүүлэх санал боловсруулан батлуулав.
9. ШУТИС-ийн ранкинг тогтоолгох ажлыг дэлхийн их, дээд сургуулиудын зэрэглэл /ранкинг/ тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар хийлгүүлэх бэлтгэл ажлыг хангах багийн бүрэлдэхүүнийг байгуулан ажиллаж байна.

1.4.2. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ


А. ТӨВЛӨРСӨН БУС МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИК ТАЙЛАН

ШУТИС-ийн захирал, дэд захирлууд, 21 газар, албадууд, 10 бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд шаардлагатай байгаа тоо мэдээ, мэдээллийг цаг алдалгүй гаргаж өгөх ажлыг хийж гүйцэтгэв.


БСШУС-ын Сайдын 2003 оны №221 тушаалын дагуу 2017/2018 оны хичээлийн жилийн Төвлөрсөн бус мэдээллийн маягт ДБ1-ДБ13 хүртэлх маягтуудыг нэгтгэн хянаж БСШУЯ-нд хүргүүлсэн.

Үүнд: ДБ-1 Суралцагчид /мэргэжил, анги, хүйсээр/, ДБ-2 Суралцагчдын сургалтын зардал, хангамж /ангиар/, ДБ-3 Суралцагчид /дотоод, гадаад, нас хүйсээр/, ДБ-5 Удирдах ажилтан багш, ДБ-7 Суралцагчдын орон нутгийн харьяалал, ДБ-8 Суралцагчдын шилжилт хөдөлгөөн /гадаад, дотоод, ангиар/, ДБ-9 Ажиллагсад, ДБ-10 Үндсэн багшийн хөдөлгөөн, ДБ-12 Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, ДБ-13 Гадаад суралцагсад

2015-2016 оны хичээлийн жилд нийтдээ 22506 оюутан, 2016-2017 оны хичээлийн жилд нийтдээ 19866 оюутан суралцан, 2017/2018 оны хичээлийн жилд оюутны тоо 11,7% -иар буурсан байна.



Зураг 1.2. ШУТИС-ийн суралцагчид
(сүүлийн 3 хичээлийн жилээр)




Зураг 1.3. Суралцагчид /2015-2016, 2016-2017, 2017/2018 хичээлийн жилд/

Суралцагчдыг курсээр нь авч үзвэл 2-р курст хамгийн өндөр буюу 3929 оюутан 2017/2018 оны хичээлийн жилд суралцаж байна.


Суралцагчдын тоо /орон нутгаар/

Хүснэгт 1.8

№	Орон нутгийн нэр	Бакалавр	Магистр	Доктор
1	Архангай	1332	171	23
2	Баян-Өлгий	257	9	0
3	Баянхонгор	358	24	8
4	Булган	355	27	7
5	Говь-Алтай	403	25	4
6	Дорноговь	255	19	3
7	Дорнод	389	32	1
8	Дундговь	290	17	3
9	Завхан	627	45	6
10	Өвөрхангай	810	48	6
11	Өмнөговь	256	34	1
12	Сүхбаатар	235	54	1
13	Сэлэнгэ	412	54	4
14	Төв	469	43	10
15	Увс	676	44	3
16	Ховд	561	22	9
17	Хөвсгөл	721	66	6
18	Хэнтий	407	23	4
19	Дархан-Уул	476	87	8
20	Улаанбаатар	5454	582	130
21	Орхон	523	128	19
22	Говь-Сүмбэр	93	11	0
23	Бусад	6	1	0
БҮГД		15365	1566	256




Зураг 1.4. Бакалавр, магистрын зэргээр суралцагчдын тоо /орон нутгаар/



Зураг 1.5. Докторын зэргээр суралцагчдын тоо (орон нутгаар)

Нийт суралцагчдыг аймгаар нь авч үзвэл бакалаврын сургалтад Улаанбаатар хотоос хамгийн их буюу 5454, аймгуудаас Архангай 1332, магистр Улаанбаатар 582, Архангай 171, доктор оюутан Улаанбаатараас 130, Архангайгаас 23 тус тус суралцаж байна.




Зураг 1.6. Гадаад оюутны тоо

21 гадаад оюутан суралцаж байгаагийн 57,1 хувь буюу 12 нь БНХАУ-ын суралцагч байна.

ШУТИС-д бакалавр зэргээр суралцагчдын насны ангилал

Хүснэгт 1.9

Насны бүлэг	2015-2016 оны хичээлийн жил	2016-2017 оны хичээлийн жил	2017/2018 оны хичээлийн жил
16 хүртэл	5	6	3
16 настай	63	40	54
17 настай	1155	971	1228
18 настай	3749	3141	3142
19 настай	3519	3463	2869
20 настай	3005	3091	3052
21 настай	2518	2264	2200
22 настай	1529	1342	1263
23 настай	1067	744	665
24 настай	653	529	418
25 настай	526	351	338
26 настай	411	331	262
27 настай	306	252	239
28 настай	214	202	223
29 настай	225	153	163
30-34 настай	636	572	574
35-39 настай	274	263	298
40-өөс дээш	254	218	196



Зураг 1.7. Бакалавр зэргээр суралцагсдын насны ангилал

Зураг 1.7-д үзүүлсэнээр ШУТИС-ийн бакалаврын түвшинд суралцаж буй оюутнуудын ихэнх нь 18-22 насны суралцагсад байгаа бөгөөд 2016-2017 оны хичээлийн жилд хамгийн их 13301 оюутан, 2017/2018 оны хичээлийн жилд 12526 суралцагч оюутантай байна.

Нийт багш ажилтны тоо

Хүснэгт 1.10

Ажилтаны тоо	2016-2017 оны хичээлийн жил	2017/2018 оны хичээлийн жил
Төв удирдлагын удирдах ажилтан	19	22
Төв удирдлагын захиргааны ажилтан	61	66
Төв удирдлага дахь аж ахуй, үйлчилгээний ажилтан	84	82
Бүрэлдэхүүн сургуулиудын удирдах ажилтан	38	37
Бүрэлдэхүүн сургуулиудын захиргааны ажилтан	159	156
Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын үйлчилгээний ажилтан	154	152
Бүрэлдэхүүн сургууль дахь аж ахуй, үйлчилгээний ажилтан	229	232
Нийт багш	1006	978
Ахмад гэрээт багш	95	78
НИЙТ	1845	1803

Багш нарын тоо /албан тушаалаар/

Хүснэгт 1.11

№	Сургууль	Багш ажилтны тоо	Багшийн тоо	Үүнээс:							
				Салбар тэнхимийн эрхлэгч	Зөвлөх профессор	Тэргүүлэх профессор	Профессор	Дэд профессор	Ахлах багш	Багш	Дадлагажигч багш
1	БАС	157	103	3	2	0	2	10	41	41	4
2	БУХС	190	119	4	2	0	7	16	51	38	1
3	ГУУС	167	106	4	8	0	8	11	37	38	0
4	ГХИ	114	97	3	0	0	1	3	49	37	4
5	ДаТС	143	88	4	0	0	2	3	28	50	1
6	ЕНИ	42	18	1	0	0	0	1	7	9	0
7	МехТС	150	83	4	3	0	5	7	36	25	3
8	МХТС	164	100	5	2	0	4	10	32	46	1
9	ҮТС	160	85	4	2	0	6	9	44	19	1
10	ХШУС	152	109	4	2	0	5	8	50	38	2
11	ЭХС	117	70	2	2	0	2	10	23	28	3
12	ШУТАС	22	15								
15	КООСЕН	20	13								
14	Захиргаа	170	8								
БҮГД		1768	1014	38	23	0	42	88	398	369	20

Эрдмийн зэрэг, цолтой багшийн тоо

Хүснэгт 1.12

№	Сургууль	Sc.D	Ph.D	Нийт эрдмийн зэрэгтэй багшийн тоо	Эрдмийн цолтой багшийн тоо			
					Академич	Хүндэт профессор	Профессор	Дэд профессор
1	БАС	2	29	31	1	1	4	9
2	БУХС		58	58			4	20
3	ГУУС	7	44	51	1		12	15


4	ДаТС		16	16				7
5	МехТС	3	34	37		2	4	14
6	МХТС		38	38			4	14
7	ҮТС	4	35	39			6	18
8	ХШУС	1	45	46			5	11
9	ЭХС	3	24	27	2		2	10
10	ГХИ	1	23	24				4
11	ЕНИ		5	5			1	1
	НИЙТ	21	351	372	4	3	42	123

Дээрхи багш нараас Төрийн одонтой 131 багш байдаг бол Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэгтэй 221 багш ажиллаж байна.

Профессор багш нарын тоо

Хүснэгт 1.13

Багшийн тоо	2016-2017 оны хичээлийн жил	2017/2018 оны хичээлийн жил
Профессор багшийн тоо	1006	978
Ахмад гэрээт багш	95	78
Гэрээт багш	132	88
НИЙТ	1233	1144



Зураг 1.9. Багш нарын тоо /насны ангиллаар/



ХОЁРДУГААР БҮЛЭГ

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. БАКАЛАВРЫН СУРГАЛТ

ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2017 ны 6 сарын 14-ний өдрийн хурлаар батлагдсан 2017/2018 оны хичээлийн жилийн Сургалтын нэгдсэн хуанлийн дагуу бакалаврын түвшний сургалтын элсэлт, төгсөлт, явцын сорил, улирлын шалгалт, диплом хамгаалалт гэсэн сургалтын үндсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Мөн ШУТАС, Коосэн ТДС, ИТДБ Төслийн хамтарсан бакалавр, бэлтгэл коосен хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг удирдлагаар ханган, байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудлыг хариуцан ажиллав.

2.1.1. Элсэлт

ШУТИС-ийн Захирлын 2017 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/64 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2017/2018 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн үйл ажиллагаа 07 дугаар сарын 01-07-ны хооронд элсэлтийн комисс зохион байгуулсан.

Элсэгчдийн бүртгэл, онооны жагсаалтыг тусгай програм хангамжийн тусламжтайгаар гарган, болзол хангасан элсэгчдийн цаашид суралцах мэргэжлийн сонголтыг хийлгэв.

Элсэлтийн ажлын график дараахь хуваарийн дагуу явагдав. Үүнд:

Бүртгэл: 2016 оны 07 сарын 01-04-ний өдрүүдэд 24 цагийн турш www.elselt.edu.mn вэб хаягаар бүртгэв.

Хар зургийн шалгалт: 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 9.00 цагаас

Онооны жагсаалт: 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 22.00 цагт


Хуваарь сонголт: 2016 оны 07 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд

2017/2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Удирдах зөвлөлөөс батлагдаж ирсэн хяналтын тооны дагуу ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад нийт 4181 оюутан шинээр элсэн суралцах болсон.


Шинээр элсэн орсон элсэгчид

Хүснэгт 2.1


Д/д	Сургууль	Тоо
1	Барилга, Архитектурын сургууль	516
2	Бизнесийн удирдагч, хүмүүнлэгийн сургууль	381
3	Геологи, уул уурхайн сургууль	549
4	Механик, тээврийн сургууль	511
5	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	527
6	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	457
7	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	59
8	Эрчим хүчний сургууль	603
9	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	204
10	Орхон аймаг дахь Технологийн сургууль	120
11	Коосэн, хамтарсан хөтөлбөрөөр	144




Зураг 2.1. ШУТИС-д сүүлийн гурван хичээлийн жилийн элсэгчдийн тооны харьцуулалт



Зураг 2.2. Элсэлтэнд бүртгүүлэгч ба ЕБС төгсөгч



Зураг 2.3. Хөдөө орон нутаг, Улаанбаатар хотоос сүүлийн гурван жилийн элсэгчийн тооны харьцуулалт



Зураг 2.4. Улаанбаатар хотоос элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо

**Улаанбаатар хотод ШУТИС-д бүртгүүлсэн элсэгчдийн
ерөнхий шалгалтын дундаж оноо**

Хүснэгт 2.2

Бүлэг	Бүртгүүлсэн элсэгчдийн тоо	ЭЕШ өгсөн ХИЧЭЭЛ 1-ийн оноо	ЭЕШ өгсөн ХИЧЭЭЛ 2-ын оноо
I	2206	539	526
II	285	536	526
III	442	526	553
IV	1697	525	548
V	915	514	526
VI	16	735	744
VII	18	548	701
VIII	15	712	710
НИЙТ	5594	579	604

Өнгөрсөн хичээлийн жилд бүртгүүлсэн элсэгчдийн тоотой харьцуулахад нийт бүртгүүлсэн элсэгчид 507 нэмэгдсэн, Хичээл 1-ийн дундаж оноо 11 оноогоор, Хичээл 2-ын дундаж оноо 43 оноогоор өссөн байна.

Сургалтын төлбөрөө бүрэн төлсөн, суралцах гэрээ байгуулах эрхийн бичиг авсан элсэгчдийн бүртгэлийг 2016 оны 08 сарын 13-30-ны өдрүүдэд бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын албад дээр явууллаа.

Цагийн сургалтын элсэлтийн тоо сүүлийн 3 хичээлийн жилээр

Хүснэгт 2.3

Д/Д	Сургууль	2015-2016	2016-2017	2017/2018
1	БАС	55	23	33
2	ГУУС			20
3	ЭХС	16	14	18
4	МТС	26	23	33
5	ДаТС	46	71	240
6	ОрТС		18	33
	НИЙТ	143	149	377

Бакалаврын хөтөлбөрт Цагийн сургалтаар элсэгчдийн тоо жил ирэх тусам өсөж байна.

Бэлтгэл КООСЭН хөтөлбөрт суралцагчид

Хүснэгт 2.4

Д/д	Мэргэжил	ЭЕШ өгсөн ХИЧЭЭЛ 1-ийн оноо	ЭЕШ өгсөн ХИЧЭЭЛ 2-ын оноо
1	Барилга, механик инженер	727,7	725,85
2	Архитектур	702,1	690,6
3	Бэлтгэл Коосэн	686,67	685,12
НИЙТ		568.23	561.48

ШУТАС-ийг төгсөгчдөөс ШУТИС-д элсэн суралцсан 76 оюутан, ИТДБ Төслийн бакалаврын хамтарсан хөтөлбөрт 93 оюутан, бэлтгэл КООСЭН хөтөлбөрт 39 оюутан, КООСЭН технологийн коллежид 29 оюутан, ахлах сургуульд 47 сурагч тус тус элсэн суралцлаа.

2.1.2. Суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн (GPA)

Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт 2017/18 оны хичээлийн жилийн намрын улиралд 17485 суралцагч 281103.1 кредит, хаврын улиралд 15254 суралцагч 231561.1 кредит сонгон суралцсан байна.

2017/2018 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт суралцагчдын тоо


Хүснэгт 2.5

Д/д	Сургууль	Үзүүлэлт	2017/2018							
			Бакалавр		Магистр		Доктор		НИЙТ	
			намар	хавар	намар	хавар	намар	хавар	намар	хавар
1	БАС	оюутны тоо	2839	2477	157	112	4	3	3000	2592
		кредит	45665	37793	1300	781	30	18	46995	38592
2	БУХС	оюутны тоо	1374	1217	489	443	19	33	1882	1693
		кредит	23189	20121	6032	4854	181	312	29402	25287
3	ГУУС	оюутны тоо	2089	1771	267	227	28	21	2384	2019
		кредит	33654.3	28229	2756	2118	291	197	36701.3	30544
4	ДарТС	оюутны тоо	943	768	95	126	0	0	1038	894
		кредит	15902.8	12485	1101	1471	0	0	17003.8	13956.1
5	МехТС	оюутны тоо	1641	1477	86	64	7	11	1734	1552
		кредит	27775	23625	1072	699	82	121	28929	24445
6	МХТС	оюутны тоо	1998	1733	60	70	9	11	2067	1814
		кредит	33086	26371	556	673	60	89	33702	27133
7	ҮТС	оюутны тоо	2135	1870	77	65	3	3	2215	1938
		кредит	35275	27343	759	616	34	30	36068	27989
8	ХШУС	оюутны тоо	349	317	44	33	8	5	401	355
		кредит	5925	4702	515	357	79	50	6519	5109
9	ЭХС	оюутны тоо	2292	1959	195	183	12	15	2499	2157
		кредит	39737	33150	1955	1645	129	174	41821	34969
10	ГХИ	оюутны тоо	202	172	11	10	0	0	213	182
		кредит	3281	2928	103	96	0	0	3384	3024
11	ЕНИ	оюутны тоо			6	2	0	0	6	2
		кредит			36	18	0	0	36	18
12	ОУДБСТ	оюутны тоо			37	45	9	11	46	56
		кредит			440	390	102	105	542	495
ШУТИС		оюутны тоо	15862	13761	1524	1380	99	113	17485	15254
		кредит	263490	216747	16625	13718	988	1096	281103.1	231561.1


Бакалаврын хөтөлбөрт суралцагчдын үнэлгээний голч дүн

Хүснэгт 2.6

Д.Д	Сургууль	2017 - 2018				
		Намар		Хавар		Голч дүнгийн дундаж
		Оюутны тоо	Голч дүн	Оюутны тоо	Голч дүн	
1	БАС	2920	2.19	2467	2.28	2.24
2	БүХС	1371	2.26	1216	2.37	2.32
3	ГУУС	2102	1.93	1781	2.06	2.00
4	ДаТС	1281	2.33	1008	2.28	2.31
5	МехТС	1674	2.13	1479	2.22	2.18
6	МХТС	1998	1.88	1731	1.89	1.89
7	ҮТС	2144	2.24	1872	2.28	2.26
8	ХШУС	349	2.15	316	2.32	2.24
9	ЭХС	2261	2.18	1966	2.23	2.21
10	ГХИ	203	1.96	174	2.10	2.03
11	ОрТС	557	1.85	462	2.05	1.95
ШУТИС		16860	2.10	14472	2.19	2.14




Зураг 2.5. ШУТИС-ийн үнэлгээний голч дүн
(бүрэлдэхүүн, харьяа сургууль, институт)



Зураг 2.6. Үнэлгээний голч дүнгийн харьцуулалт (сүүлийн 3 жилээр)

Бакалаврын хөтөлбөр, мэргэжил бүрийн 2017/18 хичээлийн жилийн ҮГД-ийн судалгааг хавсралт 1-ээр харуулав. Судалгаанаас харахад үнэлгээний голч дүн буурсан үзүүлэлттэй байна. 2017/2018 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт суралцагчдын үнэлгээний голч дүнг тодорхой хязгаараар гаргаж үзвэл 2 улирлын нийт дүнгээр 3,6 ба түүнээс дээш үнэлгээтэй 2233 оюутан, үүнээс захирлын нэрэмжит хуудсанд 934 суралцагч бичигдсэн бөгөөд 0,7 ба түүнээс доош үнэлгээтэй 5424 суралцагч анхааруулах хуудсанд бичигдсэн байна. Суралцагчдын дийлэнхи буюу 10218 суралцагч 2,0-3,0 үнэлгээтэй суралцаж байна. Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны зүгээс анхааруулах хуудсанд бичигдсэн оюутнуудад зөвлөх багшаар дамжуулан тодорхой арга хэмжээ авч ажиллаж байна.



Налфын улирал

Хаврын улирал

Зураг 2.7. Суралцагчдын үнэлгээний голч дүн

Цагийн сургалтын суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн

Хүснэгт 2.7

Д/Д	Салбар /тэнхим	Мэргэжил	Оюутны тоо	ҮГД	Оюутны тоо	ҮГД
			Намар		Хавар	
1. БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ						
1	Барилгын инженерийн салбар	Иргэний ба үйлдвэрийн	70	2.27	49	2.83
		Автозамын барилга	13	2.90	4	2.32
	Дундаж		83	2.34	53	2.58
2. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ						
2	Уул уурхайн салбар	Уул уурхайн ашиглалтын технологи	11	3,19	8	3.61
	Дундаж		11	3,19	8	3.61
3. ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ						
3	Технологийн салбар	Иргэний ба үйлдвэрийн барилга	21	3.06	17	2.81
4		Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	38	3.23	33	2.73
5		Уул уурхайн ашиглалтын технологи	56	3.02	49	3.07
6	Инженерчлэлийн салбар	Дулааны инженер	49	3.07	40	2.47
7		Дулааны цахилгаан станц	20	3.06	17	3.21
8		Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	29	2.17	17	2.06
9		Цахилгааны инженер	72	2.89	47	2.86

10		Цахилгаан систем	2	3.16	-	-
Дундаж			287	2.97	220	2.66
4. МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ						
11	Тээврийн салбар	Авто машины ашиглалт, авто аж ахуй	45	1.44	49	3.18
Дундаж			45	1.44	49	3.18
5. ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ						
12	Дулааны инженерийн салбар	Дулааны инженер	2	2.30	-	-
13	Цахилгааны инженерийн салбар	Цахилгааны инженер	12	2.69	42	2.75
Дундаж			14.00	2.69	42	2.75
6. ОРХОН АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ						
14	Эрчим хүч, мэдээллийн технологийн тэнхим	Цахилгаан системийн автоматжуулалт	30	2.24	27	2.12
15	Механикийн тэнхим		13	2.34	12	2.46
Дундаж			43.00	2.27	39.00	2.22
ШУТИС дундаж			483	2.48	411	2.73

2.1.3. Улирлын шалгалт

Шалгалтын хуваарь хийгдсэн хичээлийн тоо

Хүснэгт 2.8

Д/Д	Сургууль	Намрын улирал	Хаврын улирал
1	БАС	270	348
2	ГУУС	232	342
3	ҮТС	366	301
4	ХШУС	129	177
5	ЭХС	196	372
6	БУХС	262	198
7	МХТС	131	180
8	МехТС	288	276
9	ГХИ	70	74
Нийт		1944	2268

Намрын улиралд 28123 ширхэг, хаврын улиралд 17843 ширхэг шалгалтын картыг шалгалт зохион байгуулж байгаа бүрэлдэхүүн сургуулийн багш нарт тараан өгч, давхардсан тоогоор 123 хичээлийн 45966 шалгалтын материалыг тестийн машинаар уншиж засав.

2.1.4. Шилжилт хөдөлгөөн, кредит дүйцүүлэлт

Бусад их, дээд сургуулиудаас шилжин ирж байгаа оюутны шилжилт хөдөлгөөнийг хянаж, бүрэлдэхүүн сургуулиудаас ирүүлсэн оюутны материалыг шалгаж, Кредит дүйцүүлэх комиссоор батлуулав. Үүнд:

- Бусад их, дээд сургуулиудаас шилжин ирсэн оюутны тоог сургууль бүрээр гаргавал:

Шилжин ирсэн оюутны тоог (сургууль бүрээр)

Хүснэгт 2.9

Д.д	Сургууль	2017/2018 Намар					2017/2018 Хавар				
		Шилжилт		Давхар мэргэжлээр шууд элсэлт	Гадаад оюутан	Нийт	Шилжилт		Давхар мэргэжлээр шууд элсэлт	Гадаад оюутан	Нийт
		Гадаадын их, дээд сургууль, коллеж	Дотоодын их, дээд сургууль, коллеж				Гадаадын их, дээд сургууль, коллеж	Дотоодын их, дээд сургууль, коллеж			
1	БАС	8	6	6		20	1	1	1		3
2	БүХС	4	12			16		7	2		9
3	ГУУС	4	3	1		8		1			1
4	ДаТС	1	3	3		7		4	5		9
5	МехТС	4	4	1		9	2	2			4
6	МХТС	4	8	5		17	1		1		2
7	ҮТС	1	8	2		11		2	1		3
8	ХШУС	1	2			3					0
9	ЭХС	4	6	2		12		1			1
10	ГХИ	2	3	1		6	1				1
11	ОрТС	1	3			4		1			1
ШУТИС		34	58	21	0	113	5	19	10	0	34

- Энэ хичээлийн жилд давхар мэргэжлээр шууд элсэн суралцсан 31 оюутнаас ШУТИС-ийг төгссөн 18 төгсөгч давхар мэргэжил эзэмшихээр элсэн суралцаж байна.
- Кредит дүйцүүлэх комиссоос намар 99 оюутны 2623 кредитийн 32,550,808 төгрөгийн, хаврын улиралд 26 оюутны 796 кредитийн 9,202,678 төгрөгийн дүйцүүлэлт хийснээс, 125 оюутан 31,110,647 төгрөгийн дүйцүүлэлтийн төлбөр төлж дүйцүүлсэн кредит, дүнгээ баталгаажуулж авсан байна. Өмнөх хичээлийн жилүүдэд хийгдсэн дүйцүүлэлтийн төлбөрөөс 12,080,175 төгрөгийн төлбөр төлөгдсөн ба захиргааны дансанд нийт 29,987,505 төгрөг орсон байна.
- Энэ хичээлийн жилд Давхар мэргэжлээр суралцаж байгаа ШУТИС төгссөн 45 оюутан 2404 кредитээ дүйцүүлэн тооцуулж суралцаж байна.

Кредит дүйцүүлэлтийн тооцоо (сургууль бүрээр)

Хүснэгт 2.10

Д.д	Сургууль	2017/2018 Намар						2017/2018 Хавар					
		ШУТИС төгссөн		Дүйцүүлэлт хийгдсэн оюутны тоо	Дүйцүүлсэн кредит	Төлбөр 20 %	Төлсөн төлбөр	ШУТИС төгссөн		Дүйцүүлэлт хийгдсэн оюутны тоо	Дүйцүүлсэн кредит	Төлбөр 20 %	Төлсөн төлбөр
		Оюутны тоо	Дүйцүүлсэн кредит					Оюутны тоо	Дүйцүүлсэн кредит				
1	БАС	13	753	25	479	6,016,383	4,431,933	6	396	3	105	1,320,375	704,200
2	БүХС	3	167	14	422	5,591,500	4,717,000	5	359	7	211	2,107,439	1,378,000
3	ГУУС	2	125	6	157	1,974,275	1,798,225			2	38	471,814	471,814
4	ДаТС	1	113	6	166	1,884,100	90,800	4	162	2	74	839,900	
5	МехТС	1	27	7	243	3,055,725	3,055,725			6	173	2,175,475	2,175,475

6	МХТС	3	167	11	408	5,406,000	4,014,750	1	33				
7	ҮТС	2	48	9	280	2,892,250	1,873,675	1	93	2	31	389,825	389,825
8	ХШУС			2	31	358,825	358,825						
9	ЭХС			9	289	3,720,875	3,038,500			1	45	579,375	579,375
10	ГХИ	1	27	7	89	981,225	441,000	1	18	2	99	1,091,475	1,069,425
11	ОрТС			3	59	669,650	295,100			1	20	227,000	227,000
	ШУТИС	26	1427	99	2623	32,550,808	24,115,533	18	1061	26	796	9,202,678	6,995,114

- Кредит дүйцүүлэлтийн комиссоос гарсан шийдвэр, дүйцүүлсэн кредитийн төлбөрийн мэдээг бүрэлдэхүүн сургуулиудад өгөв.
- Кредит дүйцүүлэх комисст бүрэлдэхүүн сургуулиас ирүүлсэн нийт 199 оюутны материал, дүйцүүлэлтийн шийдвэрийг ШУТИС-ийн архивт хуулбарлан авч үлдтээ.
- Бүрэлдэхүүн сургууль хооронд намрын улиралд 142, хаврын улиралд 90 оюутан шилжилт хөдөлгөөн хийсэн байна. Шилжилт хөдөлгөөн хийсэн оюутнуудын материалын бүрдэлтийг

Бүрэлдэхүүн сургууль хоорондын кредитийн тооцоог Сургалтын албадаас тооцоонд орох хичээлүүд, кредит, сонголт хийсэн оюутны тоог гаргуулж, нэгтгэн мөнгөн дүнг бодож гарган ШУТИС-ийн захирлын албан бичгээр баталгаажуулан сургуулиудад, мөн Санхүү, эдийн засгийн албанд хүргүүлэв.

Хичээл сонголт хийсэн оюутны тоо, кредитын сонголт

Хүснэгт 2.11

Улирал	Оюутны тоо	Кредит	Мөнгөн дүн
Намар	1302	35632	3,711,696,012
Хавар	1205	25946	2,695,715,814

Цагийн сургалтын кредит дүйцүүлэлтийн тооцоо (сургууль бүрээр)

Хүснэгт 2.12

Дд	Сургууль	2016-2017 хичээлийн жил					
		ШУТИС төгссөн		Дүйцүүлэгт хийгдсэн оюутны тоо	Дүйцүүлсэн кредит	Төлбөр 20 %	Төлсөн төлбөр
		Оюутны тоо	Дүйцүүлсэн кредит				
1	БАС	7	387	24	541	7,431,825	2,892,455
2	ГУУС	4	172	15	556	7,243,200	1873675
3	ДаТС	22	1163	63	2623	29,771,050	14,017,370
4	МехТС	8	349	26	863	11,581,575	9,970,235
5	ЭХС			18	438	5,639,250	283,250
6	ОрТС	8	368	25	657	8,122,228	618,132
	НИЙТ	49	2439	171	5678	69789128	29655117



2.1.5. Байгууллагын магадлан итгэмжлэл

2017/2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийг гурав дахь шатны дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн магадлан шинжлэх үйл ажиллагаа явагдлаа. Өөрийн үнэлгээний тайлангийн мэдээллийг шинэчлэн

боловсруулж, 2017 оны 11 сард /2017.11.30-ны өдрийн 1/707 тоот албан бичиг/ БМИҮЗ-д хүргүүлсэн. БМИҮЗ-өөс томилогдсон магадлан шинжлэх баг 2018.03.14-16-ны өдрүүдэд ШУТИС-д ажиллав.



Зураг 2.8. Магадлан шинжилгээ хийх шинжээчдийн баг



Зураг 2.9. Ажил олгогчидтой хийсэн уулзалт



Зураг 2.10. Оюутнуудтай хийсэн уулзалт

ШУТИС-ийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 20 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэв.



Зураг 2.11. ШУТИС-ийн Өөрийн үнэлгээний котисс, магадлан шинжилгээ хийх шинжээчдийн баг



Зураг 2.12. ШУТИС магадлан итгэмжлэлийн гэрчилгээ гардан авлаа



Зураг 2.13.а. ШУТИС-ийн магадлан итгэмжлэлийн гэрчилгээ

2.1.1. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

Үндэсний магадлан итгэмжлэл

2017/18 оны хичээлийн жилд БАС-ийн “Архитектур”, УТС-ийн “Шим тэжээл судлал”, “Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт”, ЭХС-ийн “Үйлдвэрийн экологи”, БуХС-ийн “Бизнесийн удирдлага”, “Менежмент” хөтөлбөрүүдийг БМИҮЗ-өөр магадлан шинжлэх үйл ажиллагаа явагдаж, шинжээчдийн баг 2018 оны 2-5 дугаар сард ажиллав.

БАС-ийн “Архитектур”, ЭХС-ийн “Үйлдвэрийн экологи”, УТС-ийн “Шим тэжээл судлал”, “Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт” хөтөлбөрүүд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлж 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн гэрчилгээгээ авлаа.

Олон улсын магадлан итгэмжлэл

Монгол улсад төдийгүй Азид анх удаа АВЕТ-ийн ЕТАС буюу Инженер технологийн магадлан итгэмжлэх зөвлөлөөр Цахилгаан холбоо, Утасгүй холбоо хөтөлбөр магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагаа явагдаж, шинжээчдийн баг 2017 оны 11 сард ШУТИС-ийн МХТС-д ажиллав.

ГУУС-ийн “Геодези” хөтөлбөр Олон Улсын Магадлан Итгэмжлэлийн Герман улсын ASIIN болон Европын холбооны EUR-ACE байгууллагын зохих зөвлөмжүүдийг ханган биелүүлж, 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдэв /2017-2022/.



Зураг 2.13.б. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрүүд

2.1.2. Сургалтын үйл ажиллагааны хяналт, шалгалт

2017/2018 оны хичээлийн жилийн намрын улиралд ГУУС, ХШУС, ГХИ, Е-НИ-ийн намрын улиралд 2998, хаврын улиралд 2556 оюутан, 410 профессор багш нарт бакалаврын сургалтын, Намрын улиралд 315, хаврын улиралд 413, нийт 728 хичээлийн хуваарь, БАС, ЭХС-ийн 5466 оюутан, хаврын улиралд 4749 оюутан, нийт 215 профессор багш нар, бакалавр, эчнээ сургалтын нийт 746 хичээлийн хуваарийг тус тус зохион, хичээл зохицуулалтыг хийж ажиллалаа.

Хичээл сонголт-2

БАС, ГУУС, ХШУС, ЭХС, ГХИ, Е-НИ-ийн сургалтын албадаас оюутны хичээл сонголт 2-той холбоотой хичээлүүдийн өөрчлөлтийг улирал бүрийн 1-р долоо хоногт хүлээн авч сургалтын төлөвлөгөөтэй тулган, хянаж, хичээлийн хуваарьт өөрчлөлт, зохицуулалт хийв. Үүнд: 15 ба түүнээс доош оюутантай сонголт хийсэн хичээлүүдийг хасч, оюутны шилжилт хөдөлгөөн, давхар мэргэжлээр суралцахаар шууд элссэнтэй холбоотойгоор нэмж сонголт хийсэн хичээлүүд, заах багшийн хамт тодруулан хичээлийн нэгдсэн хуваарьт өөрчлөлтүүдийг хийж, зохицуулалт хийсэн.

ШУТИС-ийн хэмжээнд 2017/2018 оны хичээлийн жилд сургалт явагдаж байгаа хичээл тус бүрээр багш, оюутан нарын хоорондын зохицолттойгоор бие

даалтыг 5-р долоо хоногоос UNIMIS-д хичээлийн стандартын дагуу хуваарийг оруулснаар багш, оюутны цахим хуудсанд харагддаг болсон.

БАС, ЭХС-ийн Сургалтын албадаас оюутны хичээл сонголт-2-той холбоотой хичээлүүдийн өөрчлөлтийг улирал бүрийн 1-р долоо хоногт хүлээн авч сургалтын төлөвлөгөөтэй тулган, хянаж, хичээлийн хуваарьт өөрчлөлт, зохицуулалт хийв. Үүнд: 15-аас доош оюутантай сонголт хийсэн хичээлүүдийг хасч, оюутны шилжилт хөдөлгөөн, давхар мэргэжлээр суралцахаар шууд элссэнтэй холбоотойгоор нэмж сонголт хийсэн хичээлүүдийг, заах багшийн хамт тодруулан хичээлийн нэгдсэн хуваарьт өөрчлөлтүүдийг хийж, зохицуулалт хийсэн. Элсэлт аваагүй мэргэжлүүдийн үлдсэн оюутнуудын хичээлийн хуваарийг нэгтгэн гүйцэтгэв.

БАС-ын Авто замын барилга, Иргэн ба үйлдвэрийн барилга мэргэжил, ЭХС-ийн цахилгааны инженер мэргэжилийн эчнээ сургалтын 1, 2-р ангийн оюутнуудын хичээлийн хуваарийг хийж, сургалтын үйл ажиллагаа явагдсан. Эчнээ сургалтын намар, өвлийн сургалт тус тус 6 долоо хоног хичээллэв. ЭХИС-ийн Дулааны цахилгаан станц 2+2, Цахилгаан хангамж 2+2, Эмнэлгийн тоног төхөөрөмж 2+2 хамтарсан хөтөлбөрүүдийн хичээлийн хуваарийг хийж, суралцаж байгаа оюутнуудын хичээл сонголт-2-ийг журамд зааснаас илүү кредиттэйгээр сонгох зохицуулалтыг гүйцэтгэв.

Сургалтын үйл ажиллагааны явцад хяналт тавьж, бүрэлдэхүүн сургуулиудаар сар бүр явж хичээлийн явц, хоцролт, эрт тараалтыг шалгав. Бүрэлдэхүүн 11 сургуулиас хичээл таслалтын мэдээг авч, шалган, нэгтгэж Сургалтын албадад албан бичиг явуулж, багш нараас шалтгааныг тодруулан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл тасалсан багш нараас 2012 оын 01-р сарын 27-ны өдрийн А-17 тоот тушаалын дагуу суутгах мөнгөн дүнг гарган, бүрэлдэхүүн сургуулийн санхүүд хүргүүлэв.

Хичээл сонголт-1

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан, мэргэжил тус бүрт заагдах хичээлийн ерөнхий ангиллыг боловсруулан, улирлын төлөвлөгөөг гаргаж, хичээлийн нэгдсэн хуваарь гаргахад бэлдэв.

Хариуцсан сургуулиудын сургалтын албадаас оюутны хичээл сонголт 1-ийн нэгтгэлийг хүлээн авч, заавал болон сонгон суралцах хичээл, анги дүүргэлт, өмнөх холбоо, кредит зэрэг шалгуур үзүүлэлтээр хянан, хичээлийн ерөнхий хуваарийн бэлтгэл ажлыг улирлын төлөвлөгөөн дээр гүйцэтгэв.

Салбар, тэнхимүүдээс ирүүлсэн хичээл заах багшийн жагсаалтыг үндэслэн салбар, тэнхимийн эрхлэгч нартай багш нарын цагийн ачааллыг тооцоолон тохиров. Хичээлийн хуваарь хийхдээ:

1-р шат. Сургуулиудын мэргэжил, курс тус бүрээр оюутнуудын сонголт, багш, өрөөнүүдийн боломжийг харгалзан хичээлийн хуваарийг зохиов.

2-р шат. Бүх сургуулиудын S кодтой хичээлүүдийн сонгосон оюутны тоог харгалзан өрөөний багтаамжид тохируулан потокуудыг үүсгэв.

3-р шат. UNIMIS-д хичээлийн хуваарийг оруулахын тулд хичээлийн код, багш, кредит, оюутны тоог зохиосон хичээлийн хуваариас түүж гаргав.

4-р шат. Хянаж шалгасан хичээлийн хуваариа Сургалтын албанд өгч UNIMIS-д оруулсав.

5-р шат. Хичээл бүрийн бие даалтыг хуваарийг 5-р долоо хоногт багш, оюутан нарын хоорондын зохицолтойгоор хийж, UNIMIS-д шивж оруулав. Эхлэхтэй холбоотойгоор хариуцсан сургуулиудынхаа өрөөнүүдийн багтаамж, бэлтгэл байдлыг захиргаанаас томилогдсон ажлын хэсэгтэй хамтран ажиллав.


Сургалтын үйл ажиллагааны явцад хяналт тавьж, бүрэлдэхүүн сургуулиудаар сар бүр 3 ба түүнээс дээш удаа явж хичээлийн явц, хоцролт, эрт тараалтыг шалгав. Бүрэлдэхүүн 8 сургууль, 2 институтээс хичээл таслалтын мэдээг авч, шалган, нэгтгэж сургалтын албанд албан бичиг явуулж, багш нараас шалтгааныг тодруулан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл тасалсан багш нараас 2012 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-17 тоот тушаалын дагуу суутгах мөнгөн дүнг гарган, бүрэлдэхүүн сургуулийн санхүүд хүргүүлэв.

2.1.3. Төгсөлт


2017/2018 оны хичээлийн жилийн төгсөгчдийн товчоо

Хүснэгт 2.13


д/д	Улирал	Бакалаврын зэрэгтэй төгсөгч			Мэргэжлийн дипломтой төгсөгч
		Нийт	Хөтөлбөрийн төгсөлт	Онцлох дипломтой төгсөгч	
1	Намрын улиралд	1194	191	25	45
2	Хаврын улиралд	2290	1477	71	77
2016-2017 оны хичээлийн жилд		3484	1668	96	122




Зураг 2.14. Хаврын улиралд төгсөгчдийн үнэлгээний голч дүн




Зураг 2.15. Намрын улиралд төгсөгчдийн үнэлгээний голч дүн



Зураг 2.16. 2016-2017 оны хичээлийн жилийн төгсөлтөөс хойшилсон оюутны судалгаа



Зураг 2.17. Төгсөгчдийн үнэлгээний голч дүн /сүүлийн 3 жил/



Зураг 2.18. Онцлох дипломтой төгсөгчдийн тоо /сүүлийн 3 жил/

2017/2018 оны хичээлийн жилд диплом нөхөн авах хүсэлт гаргасан материалыг намрын улиралд 2017 оны 10 сарын 01-ээс 30-ны хооронд, хаврын улиралд 2018 оны 03 сарын 01-ээс 30-ны хооронд хүлээн авсан. Нөхөн диплом авах хүсэлт гаргасан нийт төгсөгчдийн материалыг шалгаж, холбогдох бүрэлдэхүүн сургуультай хамтран дүйцүүлэлтийг хийж дүйцүүлэлтийн комиссоор батлуулсан болно. Нөхөн дипломын бичилтийн баазыг бүрдүүлэн дипломуудыг кирилл, уйгаржин болон англи хэл дээр хэвлэн гаргаж баталгаажуулан хүсэлт гаргасан төгсөгчдөд хүлээлгэн өгөв.

2.1.4. Судалгаа

Оюутны мэдлэгийн түвшин тогтоох шалгалт, сэтгэл ханамжийн судалгаа

Хичээл бүр дээрх оюутны үнэлгээ

2017/18 оны хичээлийн жил багш тус бүрт тухайн багшийн зааж буй хичээлийг сонгон судалж буй оюутнуудаас 9 асуулт бүхий асуумж авч үр дүнг багшийн вэбээр үр дүнг багшид хүргэж байгаа бөгөөд багш тухайн үр дүнд анализ хийж харилцааны соёл, заах арга, ур чадвараа сайжруулах талаар ажиллах юм.

Оюутны ерөнхий сэтгэл ханамжийн судалгаа

2017/2018 оны хичээлийн жилд идэвхтэй суралцаж буй суралцагчдын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох зорилгоор судалгааг авсан. Судалгаанд 11 бүрэлдэхүүн сургууль, институт, төвийн 14538 суралцагч хамрагдсан. Санал асуулгын хариултыг хэмжих нэгжийг олон улсад ашигладаг ЛИКЕРТ-ийн хэмжүүрийн дагуу 1-5 оноогоор дүгнэсэн.

Оюутны сэтгэл ханамжийг тодорхойлох асуумж

Хүснэгт 2.14

Д/д	Асуулт	Үнэлгээ				
1	ШУТИС-д элсэх үед сургуулийн талаар өгсөн мэдээлэл, чиг баримжаа сайн байсан	5	4	3	2	1
2	Зөвлөх багш бүрэн дүүрэн зөвлөж чаддаг	5	4	3	2	1
3	Сургалтын албаны ажилтнуудаас мэдээ мэдээлэл авахад хялбар байдаг	5	4	3	2	1
4	Хичээлийн анги, танхим тохилог дулаан, агааржуулалт, цэвэрлэгээ, гэрэлтүүлэг сайн байдаг	5	4	3	2	1
5	Хичээл унших нам гүм, тав тухтай орчин хангалттай байдаг	5	4	3	2	1
6	Хичээлийн танхимд сургалтын техник хэрэгсэл ашиглах боломжтой	5	4	3	2	1
7	Лабораторийн хичээлд ашиглагдах багаж, тоног төхөөрөмж хангалттай байдаг	5	4	3	2	1
8	Сургуулийн ариун цэврийн өрөө цэвэрхэн байдаг	5	4	3	2	1
9	Анги танхимын суудлын тоо хүрэлцээтэй байдаг	5	4	3	2	1
10	Номын сангийн үйлчилгээ сайн байдаг	5	4	3	2	1
11	Номын сангийн хувьд ном товхимол, гарын авлага, мэдээллийн хэрэгслүүдийг олж хэрэглэхэд хялбар байдаг	5	4	3	2	1
12	Номын сангийн ширээ, сандал хангалттай байдаг	5	4	3	2	1
13	Интернетийн орчин шаардлага хангадаг	5	4	3	2	1
14	Оюутны зөвлөл, холбооны үйл ажиллагаа сайн байдаг	5	4	3	2	1
15	Манай сургуулийн сургалтын чанар сайн	5	4	3	2	1

5 – Бүрэн санал нийлж байна, 4– Санал нийлж байна, 3 – Хэлж тэдэхгүй байна, 2– Санал нийлэхгүй байна, 1 – Огт санал нийлэхгүй байна)

Оюутнаас авсан сургалтын орчны талаарх судалгааны үр дүн

Хүснэгт 2.15

Үзүүлэлт	БАС	БАТС	БүХС	ЭХС	ГУУС	ГХИ	МехТС	МХТС	ОУДБСТ	ҮТС	ХШҮС
Бүрэлдэхүүн сургуулийн дундаж үзүүлэлт	3.30	3.26	3.22	3.49	3.52	3.39	3.48	3.59	3.90	3.32	3.62
Сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт	3.5	3.5	3.5	3.5	3.5	3.5	3.5	3.5	3.5	3.5	3.5
Зөрүү	-0.20	-0.24	-0.28	-0.01	0.02	-0.11	-0.02	0.09	0.40	-0.18	0.12

**Оюутнаас авсан сургалтын орчны талаарх судалгааны үр дүн
/бүрэлдэхүүн сургуулиар**

/ Хүснэгт 2.16

Сургууль	Оюутны тоо	A-1	A-2	A-3	A-4	A-5	A-6	A-7	A-8	A-9	A-10	A-11	A-12	A-13	A-14	A-15
БАС	2791	3.39	3.53	3.38	3.28	3.17	3.31	3.44	3.14	3.31	3.56	3.49	3.14	2.58	3.00	3.72
БАТС	240	3.56	3.56	4.04	2.56	2.91	3.16	3.07	2.51	3.80	3.51	3.38	3.59	2.66	2.77	3.73
БуХС	1245	3.38	3.70	3.31	2.69	2.83	3.23	3.27	3.03	3.48	3.37	3.27	3.38	2.83	2.79	3.75
ЭХС	2232	3.53	3.77	3.11	3.54	3.46	3.66	3.78	3.39	3.49	3.76	3.68	3.35	2.90	3.15	3.82
ГУУС	2024	3.55	3.92	3.50	3.44	3.52	3.57	3.59	3.26	3.52	3.77	3.69	3.78	2.91	3.06	3.74
ГХИ	176	3.71	4.02	3.76	3.25	3.15	3.43	3.40	2.91	3.26	3.49	3.41	3.31	2.73	3.27	3.70
МехТС	1583	3.51	3.81	3.76	3.31	3.31	3.53	3.62	3.48	3.52	3.61	3.62	3.52	2.78	3.07	3.74
МХТС	1888	3.50	3.85	3.66	3.74	3.26	3.77	3.83	3.50	4.02	3.73	3.67	3.37	2.96	3.09	3.92
ОУДБСТ	11	4.00	4.00	3.36	4.09	4.18	4.18	3.91	3.27	4.27	3.64	4.09	4.27	4.18	3.18	3.91
ҮТС	1984	3.47	3.89	3.60	3.13	3.12	3.35	3.41	3.04	3.33	3.53	3.43	3.17	2.83	2.81	3.73
ХШУС	364	3.59	4.04	3.82	3.54	3.60	3.68	3.67	3.36	3.64	3.84	3.79	3.87	2.94	3.19	3.79
ШУТИС	14538	3.48	3.78	3.48	3.33	3.26	3.49	3.56	3.25	3.52	3.63	3.56	3.39	2.82	3.01	3.77

Төгсөгчдийг мөшгөх түүвэр судалгаа

ШУТИС-ийн төгсөгчид, тэдгээрийн суралцаж төгссөн хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлтэй хэр нийцэлтэй байгаа талаарх дүр зургийг харах боломжтой нэг чухал алхам нь төгсөгчдийнхөө төгсөлтийн дараах ерөнхий дүр зураг, ажил олгогчдын үнэлгээг тодорхойлох судалгаа юм. Төгсөгчдийг мөшгөх түүвэр судалгааг “Төгсөгчдийг мөшгөх судалгаа 1”-д 2016/17 оны хичээлийн жилд суралцаж төгссөн төгсөгчид, “Төгсөгчдийн мөшгөх судалгаа 2”-д 2014/15 оны хичээлийн жилд суралцаж төгссөн төгсөгчдийг хамруулан явууллаа. Судалгаанд 10 бүрэлдэхүүн сургуулийн 3467 төгсөгч хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн ажил эрхлэлт 73,1 хувь, нэг сарын дундаж хөдөлмөрийн орлого 858700 төгрөг байна.

“Төгсөгчдийг мөшгөх судалгаа 1”-ийн зарим үр дүн

Хүснэгт 2.17

Д/д	Бүрэлдэхүүн сургууль	Төгсөгчдийн тоо	Судалгаанд хамрагдсан төгсөгч		Ажил эрхлэлт			Нэг сарын дундаж хөдөлмөрийн орлого
			тоо	хувь	Мэргэжлээр	Мэргэжлийн бус	Хувь	
1	БАС	583	325	55.7	186	114	92.3	902000
2	БуХС	313	44	14.1	10	16	59.1	653000
3	ГУУС	491	396	80.7	133	156	73.0	958000
4	ДаТС	362	148	40.9	77	49	85.1	907000
5	МехТС	341	290	85.0	197	53	86.2	1152000
6	МХТС	353	215	60.9	82	70	70.7	745000
7	ҮТС	428	290	68.0	125	72	67.9	717000
8	ХШУС	129	113	88.0	47	31	69.0	741000
9	ЭХС	374	305	81.6	199	51	82.0	924000
10	ГХИ	93	88	94.6	15	25	45.5	888,000
	НИЙТ	3467	2214	66.9	1071	637	73.1	858700.0

2017/2018 оны хичээлийн жилд төгссөн төгсөгчдийн суралцсан хөтөлбөртөө үнэлгээ хийсэн байдал:

Төгссөн сургуульд сурсан хөтөлбөр танд дараах чадваруудыг хэр сайн олгосон гэж үзэж байна вэ?

Төгсөгчдийн үнэлгээ

Хүснэгт 2.18

Д/д	Сургууль	Манлайлах чадвар	Бие даан ажиллах чадвар	Багаар ажиллах чадвар	Бичих ур чадвар	Ярианы ур чадвар	Компьютер, интернет ашиглах чадвар	Тухайн ажил мэргэжлийн мэдлэг	Бизнес эрхлэх ур чадвар
1	БАС	3.95	4.39	4.29	4.23	4.11	4.31	4.24	3.51
2	БуХС	3.98	4.30	4.56	4.56	4.40	4.35	4.21	3.51
3	ГУУС	4.17	4.44	4.40	4.25	4.27	4.41	4.24	4.02
4	ДаТС	3.62	3.85	3.90	3.79	3.82	3.67	3.83	3.39
5	МехТС	3.87	4.04	3.93	3.55	3.94	4.10	3.92	3.17
6	МХТС	3.79	4.36	4.22	4.05	3.93	4.57	4.08	3.40
7	ҮТС	3.95	4.23	4.20	4.12	4.13	4.25	4.19	3.72
8	ХШУС	3.87	4.15	4.08	4.06	3.96	4.16	4.06	3.54
9	ЭХС	3.95	4.29	4.28	4.19	4.06	4.32	4.15	3.53
10	ГХИ	4.08	4.25	4.28	4.16	4.10	4.18	4.19	4.05

Тайлбар: 1-5 хүртэл оноогоор үнэлсэн

Дараах зүйлсийн аль нь манай сургуулийн хөтөлбөрийн давуу ба сул тал болдог гэж та үзэж байна вэ?

Төгсөгчдийн үнэлгээ

Хүснэгт 2.19

Д/д	Сургууль	Багш нарын мэдлэг ур чадвар		Анги танхим, тоног төхөөрөмж		Бусад хөтөлбөр, мэргэжилд хөрвөх чадвар		Судалгааны чадавхи		Мэргэжлийн эрэлт, хэрэгцээ	
		давуу	сул	давуу	сул	давуу	сул	давуу	сул	давуу	сул
1	БАС	154	56	101	81	139	42	124	58	136	45
2	БуХС	33	1	11	23	31	3	32	2	19	14
3	ГУУС	360	30	241	148	297	92	300	90	294	96
4	ДаТС	160	2	139	23	142	18	127	33	148	15
5	МехТС	266	17	225	58	226	57	161	122	240	43
6	МХТС	204	6	151	59	170	40	159	52	154	56
7	ҮТС	275	5	148	134	240	40	235	45	236	45
8	ХШУС	108	5	82	30	97	16	97	16	83	29
9	ЭХС	302	3	227	78	248	57	230	75	246	59
10	ГХИ	87	1	14	74	76	12	32	56	61	27
	ШУТИС %/	93.9	6.1	65.4	34.6	81.5	18.5	73.2	26.8	79.0	21.0

Тайлбар: давуу тал -1, сул тал 2


2.2. МАГИСТРЫН СУРГАЛТ

Магистрантурын сургалтанд суралцах суралцагчдын тоог нэмэгдүүлэх, сургалт судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн судлаач, мэргэжлийн магистр бэлтгэх, судалгаа шинжилгээний ажлын цар хүрээг өргөжүүлэх, элсэлт, төгсөлт, сургалт судалгааны ажлын уялдаа холбоог сайжруулах талаар ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна.

2.2.1. 2017/2018 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилт

1. Магистрантурын сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө стандартын дагуу чанарын зохих түвшинд явуулж, элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах;
2. Ахисан түвшний сургалтанд хамрагдан суралцах суралцагчдын тоог нэмэгдүүлэх;
3. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж магистрантурын сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийг хөтөлбөрийг шинэчлэн ICLOUD-д оруулах ажлыг салбартай хамтран шийдвэрлэх;
4. Магистрантын суралцах идэвхи чармайлт, удирдагч болон зөвлөхтэй хамтарч ажилласан байдал буюу сурах үйл ажиллагааг бодитой үнэлэх, магистрантын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын түвшинг тогтоох ажлыг үе шаттай хийж зохих хэмжээнд хүрсэн эсэхийг тогтоож үнэлэлт дүгнэлт өгөх зорилготой “Магистрант, докторантын сарын ажил”-ыг зохион байгуулах;
5. Магистрантур, докторантурын сургалтын хөтөлбөрүүдийг хөтөлбөрийн магадлан итгэмжлэлээр оруулах;
6. Магистрант, докторантын судалгааны ажлыг олон нийтэд таниулах, салбар/тэнхим/-ын судалгааны ажлын чанарыг сайжруулах, үр дүнг хэлэлцүүлэхэд чиглэгдсэн магистрант, докторантын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах;

Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн албанаас 2017/2018 оны хичээлийн жилд Монгол улсын БШУС-ын 2014 оны 07 сарын 12-ны өдрийн А/370 тоот “Магистр, докторын мэргэжлийн чиглэл индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” тушаалаар баталсан хөтөлбөрийн индекс дүрмийн баримтлан магистрантурын сургалтын үйл ажиллагааг стандарт хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.



Зураг 2.19. ШУТИС-д суралцаж буй магистр оюутны тоо /сүүлийн дөрвөн хичээлийн жилээр /


2.2.2.

Магистрантурын элсэлт

Элсэгчдийн тоог сургуулиар харуулбал

Хүснэгт 2.20

Д/Д	Сургууль	2015-2016 оны хичээлийн жил		2016-2017 оны хичээлийн жил		2017/2018 оны хичээлийн жил	
		судлаач	мэргэжлийн	судлаач	мэргэжлийн	судлаач	мэргэжлийн
1	БАС	50	38	56	35	56	7
2	ГУУС	89	16	114	21	124	16
3	БАТС	285	60	218	78	269	81
4	ДаТС	11	3	13	10	41	51
5	ХШУС	18	2	16	3	21	1
6	МехТС	31	7	37	11	31	20
7	ҮТС	23	11	34	18	35	5
8	МХТС	29	0	49	0	48	0
9	ЭХС	42	16	58	77	60	41
10	ГХИ	11	0	14	0	6	0
11	ОУДБСТ	22	0	34	14	42	4
НИЙТ		611	153	643	267	733	226



Зураг 2.20. ШУТИС-ийн магистр оюутны элсэлтийн тоо /сүүлийн дөрвөн хичээлийн жилээр /

2.2.3.

Магистрантурын сургалтын төгсөлт

Намрын улиралд ШУТИС-ийн захирлын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/09 тоот тушаалаар 285 төгсөгчид магистрын зэргийг олгосон.

Хүснэгт 2.21

Д/Д	Сургууль	Хуучин тусгай зөвшөөрлөөр		Хөтөлбөрийн				Нийт
		Магистр		Мэргэжлийн магистр		Судлаач магистр		
		Мэргэжлийн тоо	Төгсөгчийн тоо	Хөтөлбөрийн тоо	Төгсөгчийн тоо	Хөтөлбөрийн тоо	Төгсөгчийн тоо	
1	БАС	5	11	3	4	6	8	23
2	БУХС-БАТС	6	7	1	3	4	57	67
3	ГУУС	7	13	12	56	10	15	84
4	МХТС	4	4			5	10	14
5	MexTC	3	3	2	2	4	15	20
6	ҮТС	1	1	4	7	5	6	14

7	ХШУС					7	11	11
8	ЭХС	2	3	3	21	6	8	32
9	ГХИ					1	4	4
10	ДаТС	2	5	1	3	1	1	9
11	ОУДБСТ	1	1			1	6	7
НИЙТ		31	48	26	96	50	141	285

Хаврын улиралд ШУТИС-ийн захирлын 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/132 тоот тушаалаар 266 төгсөгчид магистрын зэргийг олгосон.

**2017/2018 оны хичээлийн жилийн хаврын
улирлын магистрын төгсөлт**

Хүснэгт 2.22

д/д	Сургууль	Хуучин тусгай зөвшөөрлөөр		Хөтөлбөрийн				Нийт
		Магистр		Мэргэжлийн магистр		Судлаач магистр		
		Мэргэжлийн тоо	Төгсөгчийн тоо	Хөтөлбөрийн тоо	Төгсөгчийн тоо	Хөтөлбөрийн тоо	Төгсөгчийн тоо	
1	БАС	3	4			6	8	12
2	БУХС-БАТС	6	10	4	20	7	67	97
3	ГУУС	9	11	6	10	11	14	35
4	МХТС	2	2		1	5	9	12
5	МехТС	2	2	1		7	12	14
6	ҮТС	2	2	8	9	2	2	13
7	ХШУС	3	3	1	1	5	9	13
8	ЭХС	3	4	7	27	6	8	39
9	ГХИ	1	1			2	4	5
10	ДаТС	1	1	3	8	3	5	14
11	ОУДБСТ			2	2	2	10	12
НИЙТ		32	40	32	78	56	148	266

Намрын улиралд Барилга архитектурын сургуулийн Барилгын инженер хөтөлбөрөөр суралцаж төгссөн Дуваагийн Баярцэцэг, Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хүнсний микробиологи хөтөлбөрөөр суралцаж төгссөн Чимэдбалдарын Болормаа, хаврын улиралд Мэдээлэл холбооны технологийн сургуулийн Мэдээллийн технологи хөтөлбөрөөр суралцаж төгссөн Чинзоригийн Бүжинлхам, Эрчим хүчний сургуулийн Цахилгаан, электроник хөтөлбөрөөр суралцаж төгссөн Чинбатын Ангараг нар шилдэг судлаачаар шалгарч “ШИЛДЭГ СУДЛААЧ” өргөмжлөл, нэг зуун мянган төгрөгөөр шагнагдсан.

**Магистрантур төгсөгчдийн голч дүнгийн (GPA) судалгаа
/хөтөлбөрөөр/**

Хүснэгт 2.23

д/д	Сургууль	17-18 намар				17-18 хавар			
		судлаач	GPA	мэргэжил	GPA	судлаач	GPA	мэргэжил	GPA
1	БАС	8	3.65	3	3.52	8	3.53		
2	ГУУС	15	3.68	55	3.52	14	3.68	10	3.50
3	БАТС	56	3.58	4	3.49	66	3.60	20	3.33
4	ДаТС	1	3.52	3	3.63	5	3.64	8	3.50
5	ХШУС	11	3.80			9	3.69	1	3.43
6	МехТС	15	3.65	2	3.48	12	3.61	1	3.66

7	ҮТС	6	3.78	7	3.50	2	3.82	9	3.49
8	МХТС	10	3.65			9	3.67		
9	ЭХС	8	3.76	21	3.57	8	3.67	27	3.60
10	ГХИ	4	3.48			4	3.66		
11	ОУДБСТ	6	3.76			10	3.74	2	3.59
НИЙТ		140	3.66	95	3.53	147	3.66	78	3.51

Магистрантур төгсөгчдийн голч дүнгийн судалгаа /мэргэжилээр/

Хүснэгт 2.24

д/д	Сургуулийн нэр	2015-2016 оны намар		2015-2016 оны хавар		2016-2017 оны намар		2016-2017 оны хавар		2017/2018 оны намар		2017/2018 оны хавар	
		Тоо	ҮГД	Тоо	ҮГД	Тоо	ҮГД	Тоо	ҮГД	Тоо	ҮГД	Тоо	ҮГД
1	БАС	26	3.39	26	3.36	22	3.42	17	3.44	11	3.38	4	3.25
2	БАТС	167	3.46	128	3.42	20	3.26	24	3.30	7	3.26	10	3.46
3	ДаТС	11	3.54	13	3.60	6	3.59	2	3.49	5	3.56		
4	ГУУС	45	3.55	60	3.48	20	3.51	29	3.49	13	3.39	11	3.59
5	МХТС	20	3.49	20	3.56	10	3.42	6	3.29	4	3.31	2	3.53
6	МехТС	13	3.64	19	3.53	8	3.45	7	3.45	3	3.40	2	3.26
7	ҮТС	22	3.62	22	3.53	9	3.57	5	3.39	1	3.47	2	3.69
8	ХШУС	9	3.63	8	3.61	4	3.64	3	3.59	0		3	3.44
9	ЭХС	34	3.52	43	3.55	28	3.52	17	3.52	3	3.47	4	3.30
10	ГХИ	5	3.26	5	3.43	1	3.57			0		1	3.63
11	ОУДБСТ	14	3.76	25	3.71	2	3.71	4	3.66	1	3.64	1	3.81
12	Е-НИ			1	3.38								
ШУТИС-ГРА		366	3.53	370	3.51	130	3.51	114	3.46	49	3.43	41	3.86

2.3. ДОКТОРЫН СУРГАЛТ

Монгол Улсын БСШУСайдын 2014 оны А/370 дугаар тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, 2010 оны 492 дугаар тушаалаар батлагдсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”, 2007 оны 187 дугаар тушаалын “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийг тус тус үндэслэн ШУТИС-ийн магистр, докторын сургалт, судалгааны ажил болон зэрэг хамгаалуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор “ШУТИС-д магистр, докторын сургалт зохион байгуулах, зэрэг хамгаалахад баримтлах журам”-ыг боловсруулж, журмын төслийг бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхимээр хэлэлцүүлж, 7 сургуулийн нийт 132 саналыг хүлээн авч, журмын төсөлд оруулж, хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

Их сургуулийг судалгааны их сургууль болгон хөгжүүлэх зорилгын хүрээнд дэлхийн хөгжингүй улс орны их, дээд сургуулиудын туршлагыг өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан хэрэгжүүлэх, магистрантур, докторантурын сургалтын үйл ажиллагааг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, сургалт судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

БСШУСЯ-ны Боловсролын салбарын ESIS мэдээллийн системд 2017/2018 оны хичээлийн жилд элссэн 83 доктор оюутны дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан.

ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар “2017/2018 оны хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанли”-г хэлэлцүүлэн батлуулж, магистр, докторын сургалтанд мөрдөн ажиллаж байна.

ШУТИС-ийн 2017/2018 оны хичээлийн жилийн намрын улиралд “Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”, хаврын улиралд “Докторант, магистрантаас мэргэжлийн болон гадаад хэлний нэгдсэн шалгалт авах ажил”-ын удирдамжийг тус тус батлуулан, зохион байгуулах комиссыг ШУТИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулан үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

2017/2018 оны хичээлийн жилд магистр, докторын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулж, эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл хэвлүүлэхэд бэлэн болсон.

Докторын сургалтын хөтөлбөрүүдэд оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэх ажлыг зохион байгуулж, Бизнесийн ахисан түвшний сургуулийн докторын 5 хөтөлбөрт ОӨУБГазраар эрхийн хамгаалалт хийлгүүлэхээр бэлэн болоод байна.

2017/2018 оны хичээлийн жилд докторантурт 83 элсэгч шинээр элсэн суралцаж байгаагаас гадна доктор (Ph.D)-ын зэргийг 23 горилогч тус тус амжилттай хамгаалж, төгслө.

Магистрантур, докторантурт суралцагчдын сэдэв, удирдагч, зөвлөх комиссын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, чөлөө хүсэх, сургалтаас чөлөөлөх өргөдөл, хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн.


2.3.1. Докторантурын сургалтын элсэлт

2017/2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Захирлын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/165 тоот тушаалаар 31 хөтөлбөрөөр 83 докторантыг докторантурт шинээр элсүүлэн суралцуулж байна.

Докторантурт элсэгчдийн тоо /2013-2018 оны байдлаар/

Хүснэгт 2.25

Д/Д	Сургууль, институт, төвийн нэр	Хичээлийн жил /он/					Нийт
		2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017/2018	
1	БАС	15	12	20	5	10	62
2	БАТС	22	22	21	16	20	101
3	ГУУС	25	21	18	16	16	96
4	МехТС	8	6	7	6	8	35
5	МХТС	11	7	10	15	11	54
6	ҮТС	8	8	5	4	2	27
7	ХШУС	3	11	6	3	3	26
8	ЭХС	7	4	5	11	7	34
9	ОУДБСТ	20	9	7	6	6	48
10	ГХИ	2	-	6	-	-	8
	Элссэн	121	100	105	82	83	491




Зураг 2.21. Докторантурт шинээр элсэгчдийн судалгаа

Мөн сүүлийн 5 жилийн байдлаар ШУТИС-ийн докторантурт нийт 491 элсэгч 44 мэргэжил, 66 хөтөлбөрөөр докторантурт суралцаж байна.

2.3.2. Докторантурын сургалтын төгсөлт

2017/2018 оны хичээлийн жилд докторантын сургалт, судалгааны ажлын явцын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулах удирдамжийг батлуулан, докторантын сургалт, судалгааны ажлын түвшинг тогтоож, мэргэжлийн нэгдсэн шалгалт авах ажлыг 2 удаа зохион байгуулсан. Докторантурын сургалт дүүргэсэн гэрчилгээ авахаар хүсэлт гаргасан докторант нарын материалыг хүлээн авч хяналтын магадлагаа хийн, Захирлын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А-38 тоот тушаалаар 18 докторантад доктор (Ph.D)-ын сургалтыг дүүргэснийг гэрчлэх гэрчилгээ олгож, 18 докторантыг горилогчоор баталсан.



Зураг 2.22. Докторантурын сургалт дүүргэж сертификат авсан горилогчдын судалгаа

Сүүлийн 5 жилийн байдлаар докторантурын элсэлт, төгсөлтийн тоог мэргэжил, хөтөлбөр тус бүрээр гаргаж үзэхэд БАС 8 мэргэжил, 9 хөтөлбөрөөр тус тус элсэлт

авсанаас 9 мэргэжлээр төгсөлт хийсэн, БАТС 5 мэргэжил, 4 хөтөлбөрөөр элсэлт авсанаас 10 мэргэжлээр төгсөлт хийсэн байх жишээтэй. Энэ нь батлагдсан тусгай зөвшөөрлийн дагуу мэргэжил, хөтөлбөрөөр сургалт явагдаж байгааг харуулж байна.

2.3.3. Докторын зэрэг хамгаалж төгссөн эрдэмтдийн мэдээлэл

Сүүлийн 5 жилийн байдлаар ШУТИС-ийн бүрэлдэхүүн 8 сургууль, институт, төвийн докторантурын сургалтыг нийтдээ 120 төгсөгч төгссөн.

ШУТИС-ийн докторантур төгсөгчдийн тоо

Хүснэгт 2.26

Сургууль, институт, төвийн нэр	Хичээлийн жил /он/					Нийт
	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017/2018	
БАС		6	1	2	3	12
БАТС	8	7	4	6	6	31
ГУУС	4	2	6	2	5	19
МехТС	1	2	3	2	1	9
МХТС	1	2	-	-	3	6
ҮТС	6		4	1	-	11
ХШУС	1	4	2	4	1	12
ЭХС	3	1	2	1	1	8
ОУДБСТ	4	2	2		2	10
ГХИ		1			1	2
НИЙТ	28	27	24	18	23	120

2017/2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Захирлын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/137 тоот тушаалаар 8 горилогч, 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А-230 тоот тушаалаар 3 горилогч, Захирлын 2018 оны 04 дүгээр 16-ны өдрийн А/69 тоот тушаалаар 2 горилогч, 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А-124 тоот тушаалаар 10 горилогч, нийт 23 горилогч докторын зэрэг хамгаалуулах 10 зөвлөл дээр докторын диссертация амжилттай хамгаалан, доктор (Ph.D)-ын зэрэг хүртсэн.


2017/2018 оны хичээлийн жилд доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан эрдэмтэд

Хүснэгт 2.27

Д/Д	Овог, нэр	Зэрэг	Мэргэжлийн чиглэл	Судалгааны ажлын сэдэв
1	Лүүрэвийн Лхагвасүрэн	Геологи, эрдэс судлалын ухааны	Ашигт малтмалын ордын хайгуулын өрөмдлөгийн техник технологи	Алтын шороон ордын хайгуулын өрөмдлөгийн дээжлэлтийн чанарыг үнэлэх судалгаа
2	Дашрэнчингийн Хандмаа	Техникийн ухааны	Химийн технологи/дулаан хангамж ба дулааны техник	Гамсагбулагийн нефтийг дулааны аргаар боловсруулах технологийн судалгаа
3	Галсангийн Бэхбат	Техникийн ухааны	Цахилгаан хангамж ба цогцолборууд	Монгол орны онцлогт тохирсон нарын зайн технологийн судалгаа

4	Оливия Куммел	Техникийн ухааны	Архитектур	Local governance research in so-called "informal" urban neighbourhoods
5	Очирдоржийн Алтанзагас	Техникийн ухааны	Барилгын бүтээц	Ү-хэлбэрийн хавиргат сараалжин холбоосыг ган-төмөрбетон бүтээцэд хэрэглэх судалгаа
6	Баатарсүрэнгийн Бат-Өлзий	Нийгмийн ажлын	Нийгмийн ажил	Нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох арга зүйг боловсронгуй болгох нь
7	Дашийн Ариунтуяа	Бизнесийн удирдлагын ухааны	Үйлдвэрлэл, технологийн менежмент	Монголын арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн технологийн хөгжлийн судалгаа
8	Цэрэндоржийн Мөнхдэлгэр	Хэл шинжлэлийн	Гадаад хэл шинжлэл	Монгол англи хэлний тэмдэг нэрийн зэргийн бүтэц-үүргийн зэрэгцүүлсэн судалгаа
9	Гонгоржавын Гантөгс	Бизнесийн удирдлагын ухааны	Хүний нөөцийн менежмент	Хүний нөөцийн менежментийн үр дүнгийн шинжилгээний арга зүйн асуудал
10	Нүэкэ Эрнэст Учэнна	Бизнесийн удирдлагын ухааны	Санхүүгийн менежмент	Хувьцаат компаний сайн дурын мэдээллийн тайлагналын нээлттэй байдал ба байгууллагын шинж төлөвийн хамаарлын судалгаа
11	Цэндийн Жавзмаа	Техникийн ухааны	Мэдээллийн технологи	Монгол улс дахь халдварт бус өвчлөлийн тархалтыг өгөгдөл тандалтын зарим аргаар боловсруулах нь
12	Жанлавын Сарантуяа	Техникийн ухааны	Барилгын бүтээц	Ашиглагдаж буй барилгын модон бүтээцийн элементийн төлөв байдлын судалгаа
13	Төмөртоогоогийн Мөнхцэцэг	Техникийн ухааны	Металлург, машин үйлдвэрлэлийн технологи	Вагоны явах ангийн хос дугуйн оношлолын судалгаа (монгол улсын төмөр замын ачааны вагоны явах ангийн хос дугуйн жишээн дээр)
14	Пүрэвжавын Эрдэнэчимэг	Техникийн ухааны	Геодези	Монгол орны дунд масштабтай байр зүйн зургийн тусгагийн судалгаа
15	Ламжавын Жаргалсайхан	Техникийн ухааны	Уул уурхайн ашиглалтын технологи	Нүүрсний ил уурхайн ажлын бус хажуугийн тогтворжилтод нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ, зэрэглэлийн үндэслэл
16	Чадраабалын Сугаррагчаа	Техникийн ухааны	Уурхайн машин тоног төхөөрөмж	Уурхайн автосамосвалуудын найдвартай ажиллагааны судалгаа
17	Ламжавын Эрдэнэбаяр	Техникийн ухааны	Утасгүй холбоо	Це сүлжээний контентийн нөөц хуваарилалтын судалгаа
18	Цэрэндондогийн Тэнгис	Техникийн ухааны	Компьютерийн техник хангамж	Стерео дүрс боловсруулалтанд суурилсан төлөвийн гэдрэг холбоотой удирдлагын аргачлалын судалгаа
19	Нацагдоржийн Баатар-Очир	Боловсрол судлалын ухааны	Дээд боловсролын удирдлага	Орон нутгийн боловсролын байгууллагын хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох нь /Хөвсгөл аймгийн боловсролын газрын жишээн дээр/
20	Андрейн Аюуш	Боловсрол судлалын ухааны	Дээд боловсролын удирдлага	Их сургуулийн урамшууллын системийн судалгаа

21	Мягмарын Бурмаа	Бизнесийн удирдлагын ухааны	Харилцаа холбооны менежмент	Ухаалаг хотын хөгжлийн түвшинг үнэлэх арга зүйн асуудал
22	Ганболдын Манлай	Бизнесийн удирдлагын ухааны	Үйлдвэрлэл, технологийн менежмент	Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гүйцэтгэлийг үнэлэх арга зүйн асуудал
23	Болдбаатарын Энхжаргал	Геологи, эрдэс судлалын ухааны	Геологи	Өмнөд монголын порфирын хүдэржилт бүхий гранитоид чулуулгийн геохими, геохронологи



Зураг 2.23. Доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан эрдэмтдийн судалгаа

2.3.4. Докторантур төгсөгчдийн голч дүнгийн үнэлгээ

2017/2018 оны хичээлийн жилд докторантурын сургалт дүүргэсэн төгсөгчдийн төгсөлтийн түвшинд дүн шинжилгээ хийж сургалтын дүнгийн голч үнэлгээг гаргасан.


Доктор оюутны голч дүнгийн судалгаа

Хүснэгт 2.28

Д/Д	Бүрэлдэхүүн сургууль	2016-2017 Намар	2016-2017 Хавар	Үнэлгээний голч дүн
1	Барилга, архитектурын сургууль	3.44	3.82	3.63
2	Бизнесийн ахисан түвшний сургууль	3.70	3.60	3.65
3	Гадаад хэлний институт	-	-	-
4	Геологи, уул уурхайн сургууль	3.64	3.74	3.69
5	Механик тээврийн сургууль	3.92	3.60	3.76
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	3.71	3.74	3.72
7	Олон улсын дээд боловсрол судлалын төв	3.65	3.79	3.72
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	4.00	3.48	3.74
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	3.80	3.96	3.88
10	Эрчим хүчний сургууль	3.97	3.74	3.85
Дундаж голч дүн		3.76	3.72	3.74

Багшлах эрхийн сургалт

ШУТИС-ийн болон их, дээд сургуулиудын багш нарын багшлах болон мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сурган заах арга зүйн боловсрол олгох түр сургалтыг 6 удаа зохион байгуулж, 211 хүн хамрагдсанаас 198 хүн төгсөж багшлах эрхийн үнэмлэх гардан авлаа.



Зураг 2.24. Багшлах эрхийн сургалт

Англи хэлний мэдлэг дээшлүүлэх дунд шатны сургалт

ШУТИС-ийн багш нарын хөгжлийг дэмжих зорилгоор Англи хэлний мэдлэг дээшлүүлэх дунд шатны сургалтыг 2018-01-03-ны өдрөөс 2017-01-28-нд 3, 4, 5 дах өдрүүдийн 14:00-15:30 цагийн хооронд ШУТИС-ийн Е-406 тоот сургалтын танхимд зохион байгуулж 18 багш хамрагдсан.

Их, дээд сургуулийн CLOUD UNIMIS систем сургалт

ШУТИС-ийн багшийн хөгжлийн төв, Е-Нээлттэй институт, ЕНИ-ийн багшийн хөгжлийн багтай хамтран “Их дээд сургуулийн CLOUD UNIMIS систем” сургалт зохион байгуулав. Сургалт 2018 оны 1 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд болж ХШУС, БУХС, ГХИ, БАС, ҮТС,ЭХС, ГУУС-ийн нийт 55 багш оролцлоо.



Зураг 2.25. Их, дээд сургуулийн CLOUD UNIMIS систем сургалт

CDIO стандарт, арга зүйн сургалт

ШУТИС-ийн Багшийн хөгжлийн төвөөс 2018 оны 05-р сарын 22-23-ны өдрүүдэд Е-504 тоот өрөөнд зохион байгуулж бүрэлдэхүүн сургуулиудын багшийн хөгжлийн багийн ахлагч, гишүүд хамрагдсан.



Зураг 2.26. CDIO стандарт, арга зүйн сургалт

“XXI зууны инженер багшийн хөгжил” сэдэвт сургалт-семинар, сургалт

ШУТИС-ийн Багшийн хөгжлийн төв, Е-Нээлттэй институт, ЕНИ-ийн багшийн хөгжлийн багтай хамтран “Их сургуулийн CLOUD UNIMIS систем” сургалтыг 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Уг сургалтыг багш нарын хүсэлтээр дахин зохион байгуулж бүрэлдэхүүн сургуулиудын 45 багш хамрагдав.


Дээд боловсролын шинэчлэл АХБ-ны төслийн CDIO стандарт, арга зүйг хэрэгжүүлэх сургалт.

Дээд боловсролын шинэчлэл АХБ-ны төслийн CDIO стандарт, арга зүйг хэрэгжүүлэх ШУТИС, МУИС, МУБИС, ХААИС, УБХИС, СУИС зэрэг 6-н их сургуулийн ажлын хэсэгт 2018-06-12-ны өдрөөс 2018-06-22-ны өдрүүдэд БХТөвүүд хамтран ажиллаж Багшийн хөгжлийг дэмжих сургалтын төв, цахим сургалтын төв, лекцийн танхимуудыг тохижуулах 100,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын төслийг хийв. Цахилгаан тоног төхөөрөмж, тавилгын үнийн судалгаа хийж, үзүүлэлт нэг бүрээр тооцоо гарган Захирлаар батлуулан, БСШУСЯ-ны төслийн зөвлөх Д.Ариунболорт хүлээлгэн өгөв.

2.4. ПРОФЕССОР БАГШ НАРЫН КРЕДИТИЙН СУДАЛГАА

(2014-2015, 2015-2016, 2016-2017 оны хичээлийн жилээр)

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институтын багш ажилчдын дундаж орлогыг санхүүгийн жилээр, БАС, ГУУС, ҮТС, ГХИ-иудын багш нарын бодит цалинг албан тушаалын ангилалаар 2015-2016 оны хичээлийн жил, 2016-2017 оны хичээлийн жилүүдээр нь нэгтгэн боловсруулж ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар танилцуулав.



Зураг 2.27. Профессор багшийн эрдэмт шинжилгээний орлого (мян. төг.)


Жилд дунджаар 208 профессор багш буюу нийт багш нарын 20.2% нь эрдэмт шинжилгээний ажил гүйцэтгэсэн байна.

Профессор, багш нарын тоо (сүүлийн гурван жилээр)


Хүснэгт 2.29

№	Албан тушаал	2014-2015 оны хичээлийн жил	2015-2016 оны хичээлийн жил	2016-2017 оны хичээлийн жил
1	Захирал	4	6	6
2	Дэд захирал	6	10	10
3	ЭНБД	10	9	9
4	Салбар, тэнхимийн эрхлэгч	40	41	43
5	Зөвлөх профессор	19	22	25
6	Профессор	76	77	55
7	Дэд профессор	132	127	107
8	Ахлах багш	425	420	401
9	Багш	324	320	298
10	Дадлагажигч багш	52	34	36
11	Сургалтын мастер	46	46	50
12	Гэрээт багш	143	141	218
13	Бусад			5
БҮГД		1277	1253	1263

2014-2017 онуудад профессор, багш нарын кредитийн гүйцэтгэл нь дундажаар 1264 кр байгаа бөгөөд ачааллын ихэнх хувийг ахлах багш, багш нар гүйцэтгэсээр байна.



Зураг 2.28. Хичээл заасан багш нарын тоо (хичээлийн жилээр)




Зураг 2.29. Хичээлийн жилийн дундаж кредитийн гүйцэтгэл

Сүүлийн 3 жилд ШУТИС-ийн хэмжээнд 66 зөвлөх профессор 11,4 кр, 208 профессор 20,98 кр, 366 дэд профессор 27,4 кр, ахлах багш 20,43 кр, багш 23,35 кр, 122 дадлагажигч багш 19,1 кр, 142 сургалтын мастер дундажаар 6,9 кр, 502 гэрээт багш 10,5 кредитийн хичээл заасан байна.


Хичээлийн жилийн дунджаас харахад дэд проф 7,2 кр, ахлах багш 25,9 кр, багш 25,5 кр-ийн, сургалтын мастер 5,0 кредитийн илүү цаг хийсэн.

Ахмад гэрээт багш нарын хувьд: Профессор (50%,75%) дунджаар 11кр, Ахлах багш (75%) дунджаар 9,9 кредитийн хичээл заасан байна. 2015-2016 оны хичээлийн жилд 15 ахмад багш 105 кредит гүйцэтгэсэн ба 2016-2017 онд 23 ахмад гэрээт багш 264 кредит гүйцэтгэсэн байна.



Зураг 2.30. Профессор, багш нарын кредитийн гүйцэтгэлийн дундаж (сүүлийн 3-н хичээлийн жилээр 2014-2017 он)

Хүснэгт 1.16-д үзүүлсэнээр нэг хичээлийн жилд дунджаар 1263 орчим багштай хичээллэсэн ба багш 45.1% илүү ачаалалтай байна. Салбар, тэнхимийн эрхлэгч нар 67,2% илүү ачаалал хийсэн байна.




Зураг 2.31. Ахмад гэрээт багш нарын кредитийн гүйцэтгэл

2015-2016 оны хичээлийн жилд 15 ахмад гэрээт багш 105 кредит, 2016-2017 оны хичээлийн жилд 23 ахмад гэрээт багш 264 кредит гүйцэтгэсэн байна.

**2014-2017 оны хичээлийн жилийн илүүгийн илүү ба
ногдлоос давсан кредитийн гүйцэтгэл**

Хүснэгт 2.30

Албан тушаал	Давсан зөвшөөрөгдөх кредит	Илүүгийн илүү
Бүрэлдэхүүн сургуулийн захирал	109.9	4.8
Дэд захирал	95.5	0.7
ЭНБД	99.1	55.3
Салбар, тэнхим эрхлэгч	748.8	407.1
Зөвлөх профессор	208.2	140.2
Профессор	1264.9	404.5
Дэд профессор	2674.6	566.8
Ахлах багш	10272.4	1253.2
Багш	7668.4	561.6
Дадлагажигч багш	476.1	32.0
Сургалт мастер	282.1	125.4
Гэрээт багш	538.5	344.4
Бусад	18.6	-
БҮГД	24,457.0	3,895.7



Зураг 2.32. Илүүгийн илүү ба ноогдлоос давсан кредитийн гүйцэтгэл

2.5. ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ

БСПШУСЯ-аас хэрэгжүүлж буй “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн бэлтгэл коосэн хөтөлбөрийн элсэлт 4 дэх жилдээ, бакалаврын хамтарсан хөтөлбөр 3 дахь жилдээ барилгын инженер, архитектур, механик инженер мэргэжлээр элсэлт авсан ба БАС, УТС-ийг түшиглэн сургалтын үйл ажиллагаа явагдаж байна. Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу хамтарсан бакалаврын 9 (13 групп) анги, Бэлтгэл коосэн хөтөлбөрийн 2 (6 групп) ангийн намар, хавар, өвөл, зуны улирлын хичээлийн хуваарийн зохицуулалт, оюутнуудын хичээл сонголт 2-ыг ЕНИ-тай хамтран удирдлагын мэдээллийн системд оруулж баталгаажуулсан.

ИТДБ төслийн бакалаврын хамтарсан хөтөлбөр, бэлтгэл Коосэн хөтөлбөрт Монгол улсад 208, Япон улсад 139 оюутан суралцаж байна.

ИТДБ төслийн хөтөлбөрт суралцагчид

Хүснэгт 2.31

Д/д	Мэргэжлийн чиглэл	Монгол улсад	Япон улсад	Нийт
1	Барилга, Хүрээлэн буй орчны инженер	66	22	88
2	Архитектур	29	7	36
3	Механик инженер	83	27	110
4	Бэлтгэл коосэн	30	83	113
Нийт		208	139	347

ИТДБ төслийн хамтарсан бакалавр, бэлтгэл коосэн хөтөлбөрийн суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн

Хүснэгт 2.32

Мэргэжил	Оюутны тоо	ҮГД	Оюутны тоо	ҮГД
	Намар		Хавар	
Архитектур	39	2.38	29	2.84
Барилга,ХБО-ны инженер	92	2.90	62	3.16
Механик инженер	89	2.99	82	3.11
Коосэн	65	2.31	60	2.56
Нийт	285	2.64	233	2.92

Улирал бүрийн төгсгөлд улирлын хичээлийн шалгалтын хуваарийг хийж багш, оюутнуудад мэдээлэл хүргэж ажилласан. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас мэргэжлийн болон гадаад хэлний өндөр мэдлэгтэй, заах арга барил сайтай, ерөнхий суурь, мэргэжлийн хичээлийн 71 багшийг сонгон хөтөлбөрийн 67 хичээлийг заалгаж байна. Мөн төслийн нэгжээс япон хэл, ерөнхий суурь хичээлийн 12 багш хичээл зааж байна.


ИТДБ төслийн Хамтарсан сургалт, судалгааны зөвлөлийн хурлыг 4 удаа хийж төлөвлөгдсөн асуудлыг хэлэлцэн, шийдвэрлүүлж ажиллав. Үүнд:

- Японы консерциумийн 10 сургууль 11 сард ШУТИС-д ирж шилжин суралцах шалгалтыг авах ажлыг зохион байгуулав. Шалгалтанд 63 оюутан хамрагдсанаас 56 оюутан тэнцэж, шилжин суралцаж байна.
- Төслийн санхүүжилтээр сурах бичиг худалдан авах, хэвлүүлэх сургууль, багш нарын захиалгыг авч хэлэлцүүлэн БАС, МехТС, ХШУС-ийн 7 багшийн сурах бичиг хэвлүүлэх зардал 39,680,000 төгрөгийн санхүүжилтыг ИТДБ төслийн Удирдах хороогоор батлуулав.
- 3 дугаар сарын 26-нд ИТДБ төслийн бакалаврын хамтарсан хөтөлбөрийн сургалтын үйл явц, үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлгийг БСШУСЯ, ИТДБ төсөл, бүрэлдэхүүн сургуулиудыг хамруулан зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргав.
- Японы консерциумын 10 сургуулийн танилцуулах өдөрлөгийг 6 дугаар сарын 3-ны өдөр ТХН-тэй хамтран зохион байгуулж оюутнуудыг шилжин суралцах сургуулиа сонгох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ажиллав.
- Зарим ерөнхий суурь хичээлүүдээр оюутны мэдлэгийн түвшин тогтоох шалгалт, оюутнуудаас багш нарын талаар сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч дүгнэлтийг ХССЗ-ийн хуралд тайлагнав.

Түвшин тогтоох шалгалтын дүн

Хүснэгт 2.33

Д/д	Хичээлийн нэр	Намар	Хавар	Дундаж хувь
1	Шугаман алгебр	69.4	60	64.7
2	Математик анализ	77.8	64.3	71.05
3	Англи хэл	77.2	69.4	73.3
4	Физик	51.9	78.9	65.4
Дундаж хувь		69.1	68.2	68.6125



Зураг 2.33. 2017/2018 оны хичээлийн жилийн жилд оюутнуудаас авсан түвшин тогтоох шалгалтын дүн

Оюутнуудаас багш нарын талаар авсан сэтгэл ханамжийн судалгаа

Хүснэгт 2.34

Д/Д	Асуулга	Намар	Хавар	Дундаж
1	Хичээлийн зорилго, зорилт ойлгомжтой байдаг	4.4	4.4	4.4
2	Үндсэн сурах бичиг, гарын авлага, ном тараах материалын хүртээмж хангалттай	4.2	4.3	4.3
3	Лекц, семинар, лабораторын хичээлүүд уялдаа холбоотой	4.4	4.4	4.4
4	Сургалтанд шинэлэг арга барил, технологи болон программ хангамж ашигладаг	4.2	4.3	4.3
5	Багш хичээлээ дэс дараатай, ойлгомжтой, сонирхолтой заадаг	4.3	4.4	4.4
6	Багш хичээлийн цагийг үр бүтээлтэй, бүрэн ашигладаг	4.4	4.4	4.4
7	Багшийн өгсөн даалгаварын зорилго, агуулга, түвшин, зарцуулах цаг нь тохирсон байдаг	4.4	4.4	4.4
8	Багш оюутныг хүндэтгэн, соёлтой харьцаж, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх уур амьсгалыг бүрдүүлдэг	4.4	4.4	4.4
9	Багшийн үнэлгээ бодиттой, шударга байдаг	4.4	4.5	4.4
Дундаж		4.4	4.4	4.4

Маш сайн-5, сайн-4, дунд-3, хангалтгүй-2, маш хангалтгүй-1 оноо

21 аймагт ШУТИС-ийн 2018/19 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх танилцуулга, сурталчилгаа хийх, ИТДБ төслийн элсэлтийн урьдчилсан сорил авах ажлыг амжилттай зохион байгуулж, энэ ажилд ШУТИС-ийн 32 профессор, багш, төслийн нэгжийн 10 ажилтан хамрагдаж, ШУТИС-аас 7,61 сая төгрөг зарцуулсан. Урьдчилсан шалгалтыг Улаанбаатар хотод 4 дүгээр сарын 21-н, орон нутагт 4 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Шалгалтад Улаанбаатар хотоос 463 сурагч хамрагдсанаас 50-иас дээш хувийн үнэлгээ авсан буюу тэнцсэн 239 сурагч, 21 аймагт нийт 1491 сурагч хамрагдсанаас 239 сурагч тэнцсэн байна. Нийт

1730 ширхэг шалгалтын материалыг засах ажлыг ХШУС-ийн болон төслийн нэгжийн математик, физик, химийн 6 багш хийж гүйцэтгэсэн.

Японы их дээд сургуулийн консерциумын 10 сургуулийн танилцах өдөрлөгийг 6 дугаар сарын 3-наас 6-ны өдрүүдэд ШУТИС дээр төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгөөр консерциумын 10 сургуулийн төлөөлөл 26 профессор, багш ирж бакалаврын хамтарсан хөтөлбөрийн оюутнуудад сургууль, мэргэжлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийв. ШУТИС-ийн мэргэжлийн багш нар өдөрлөгийн үйл ажиллагаанд оролцож өөрийн мэргэжлийн сургууль, хөтөлбөрийн талаар мэдээллийг авлаа. Мөн консерциумын багш нар ШУТИС-ийн зарим хичээлийн лабораториудыг үзэж танилцан туршлага солилцов.

2.6. ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ

ШУТИС-Коосэн технологийн коллежид нийт 11 ангид 128 суралцагч, 15 үндсэн багш, 31 цагийн багштайгаар сургалтын ажил явагдлаа.

2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр дээд боловсролын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт /4 дүгээр зүйлийн 4,5 дахь хэсэг/, БСШУС-ын сайдын 2016 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/177 тоот “Нийтлэг шаардлага батлах тухай” тушаал гарсантай холбоотойгоор Технологийн дээд сургуулийн нэрийг өөрчлөх асуудлыг УЗ-ийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцэн, Захирлын 8 дугаар сарын 31-ны өдрийн А/143 тоот тушаалаар “ШУТИС-КООСЭН технологийн коллеж” болгон өөрчлөх тушаал гаргасан. Дипломын зэргээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг БСШУСЯ-наас гаргуулав.

Сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 11 сарын 24-ны өдрийн А/219 тоот тушаалаар баталгаажуулав. технологийн дээд сургуульд 2017/18 оны хичээлийн жилд 9 дүгээр анги төгсөгчдөөс математик, физикийн хичээлийн агуулгаар шалгалт авч тэнцсэн 27 суралцагчийг элсүүлэн суралцуулж байна.

2017/18 оны хичээлийн жилд ШУТИС-КООСЭН технологийн коллежид 3 мэргэжлээр нийт 128 оюутан суралцаж байна.

ШУТИС-КООСЭН технологийн коллежийн суралцагч

Хүснэгт 2.35

Дд	Мэргэжил	1 курс	2 курс	3 курс	4 курс	Нийт
1	Зам, барилгын инженер	9	9	18	13	49
2	Цахилгаан электроникийн инженер	12	13	17	12	54
3	Механик инженер	6	7	12		25
	НИЙТ	27	29	47	25	128

ШУТИС-Коосэн ТК-ийн оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн Оюутнаас багш нарын талаар 6 асуулгаар 1-5 хүртэл оноогоор санал асуулгын судалгаа авахад дундаж дүн 4,02 гарсан байна.

Санал асуулгын үр дүн

Хүснэгт 2.36

Д/д	Асуулга	Дүн
1	Багш хичээлээ дэс дараатай, ойлгомжтой, сонирхолтой заадаг	3.96
2	Багш суралцагчдыг бодитой үнэлж дүгнэдэг	4.05
3	Багш хичээлийн цагийг үр бүтээлтэй, бүрэн ашигладаг	4.12

4	Үндсэн сурах бичиг, гарын авлага, тараах материал хүртээмжтэй байдаг	3.77
5	Багш суралцагчийг хүндэтгэн, соёлтой харьцаж, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх орчин бүрдүүлдэг	4.08
6	Суралцагчдад ижил тэгш, шудрага ханддаг	4.14
Дундаж		4.02

5 – Бүрэн санал нийлж байна, 4– Санал нийлж байна, 3 – Хэлж мэдэхгүй байна, 2– Санал нийлэхгүй байна, 1 – Огт санал нийлэхгүй байна

Сургалтын орчин, анги, танхимын талаар авсан сэтгэл ханамжийн судалгаанд 5 онооноос 2,74 оноогоор дүгнэсэн байгаа нь сургуулийн анги танхим, сургалтын орчныг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

Хүснэгт 2.37

Д/д	Асуулга	Дүн
1	Хичээлийн анги, танхим дулаан, агааржуулалт, гэрэлтүүлэг сайн байдаг	2.7
2	Хичээлийн анги, танхимын цэвэрлэгээ сайн байдаг	2.6
3	Сургуулийн ариун цэврийн өрөө цэвэрхэн байдаг	2.6
4	Оюутнуудын дунд зохиогддог соёл хүмүүжлийн ажил сайн явагддаг	3.3
5	Оюутны зөвлөлийн ажил сайн явагддаг	2.5
Дундаж		2.74

Хөрсний чулуулгийн 430 гаруй дээжинд физик механикийн шинж чанарын судалгааг тус тус хийсэн.	“Ил уурхайн ашиглалтын технологийн схем” тус тус хэвлүүлсэн.

ОМССХ-ийн сургалт, судалгааны ажлын тойм

Хүснэгт 3.19

Судалгааны ажил	Сургалтын үйл ажиллагаа
АХБ-ны ТА8874 төсөлтэй хамтран Мод бэлтгэлийн оновчтой аргын судалгааг явуулж туршилт зохион байгуулав.	Ойн нөхөрлөлийн чадавхийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Мод бэлтгэлийн хөрөөчин” сургалт
Unredd+ Олон улсын байгууллагатай хамтран хортон шавьж болон түймэрт өртсөн ойн талбайн нэмэлт тооллогын арга зүй боловсруулж тооллого явууллаа	Ойн нөхөрлөлийн чадавхийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Мод зүсвэрийн ажилтан” сургалт
“Ой, уур амьсгалын өөрчлөлт” хичээлийн стандарт, гарын авлага бэлтгэх ажлын хүрээнд сэдэвчилсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлээ.	Ойн нөхөрлөлийн чадавхийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Модон эдлэлийн мужаан” сургалт
Олон улсын байгууллагатай хамтран ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах судалгаа явуулж, сургагч багшийн сургалт зохион байгууллаа.	Барилгын модон хийцийн дэвшилтэт технологи танилцуулах сургалт


Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тойм

Хүснэгт 3.20

Судалгааны ажил	Гэрээт ажил	Түтээн дэлгэрүүлэх ажил
“Эргэлдэх буцлах давхаргатай зуухны горимыг судлан бүтээмжийг тодорхойлох” ШУТөсөл	“Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн “КВ-11.63-115ВТМ зуухыг буцлах давхаргад шилжүүлэх тооцоо, зураг, төсөв боловсруулах, угсралт, тохируулга хийх” ажил	БНХАУ-ын Манжуур хотын шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэн
“Монголын эрчим хүчний нэгдсэн системийн хөгжлийн загвар боловсруулах” суурь судалгаа	“Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын халаалтын зуухны газарт DZL-1.2 зуухны метал хийц үйлдвэрлэх” ажил	“Шинжлэх ухаан – инноваци 2017” үзэсгэлэнд “Илч” бүтээлээрээ шилдэг бүтээлийн шагнал хүртсэн.
“Хувьсах чадалтай эх үүсвэртэй хоршин ажиллах дулааны аккумуляторын судалгаа” инновацийн төсөл	“Оюутолгой” ХХК-ний дулааны станцын “HFX29-2.0/130/70-М зуухны өөрчлөлтийн техникийн шийдэл, тооцоо, зураг төсөл боловсруулах” ажил	“Гэрийн зуухны шаталтын технологи” сэдвээр үндэсний үйлдвэрлэгчдэд сургалт зохион байгуулсан.
“Хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах арга технологи” инновацийн төсөл	“Увс аймгийн Дулааны II станц, ДШС ОНӨААТҮГ-ын нэгдүгээр зууханд фильтр суурилуулах” ажил	400 айл өрхөд дулаан хангамжийн талаар танилцуулга хийж, судалгаа явуулсан.

Судалгааны лаборатори

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад 38 лаборатори, харьяа хүрээлэнд 4 лаборатори судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус сургуулийн профессор, багш, судлаач, суралцагчдын (төгсөх курсын оюутан, магистрант, докторант) эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлын тасралтгүй үйл ажиллагааг хангах, гадаад, дотоод хамтарсан судалгааны ажлыг өргөжүүлэх боломж бүрдүүлэх зорилгоор бүрэлдэхүүн сургуулиудад судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа лабораториудыг бүртгэлжүүлэв.




Зураг 3.9. ШУТИС-ийн судалгааны лабораториуд
(бүрэлдэхүүн сургуулийн салбар, хүрээлэнгээр)

Судалгааны лабораторийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хамрах хүрээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, шинэчлэгдсэн байдал, ашиглалтын хугацаа, тухайн лабораторид хийгддэг туршилт судалгааны ажлын тоо, стандарт аргууд, лабораторийн хөрөнгө оруулалт, магадлан итгэмжлэгдсэн байдал, хариуцагч, байр ашиглалт, холбогдох хаяг зэрэг үзүүлэлтээр ангилан бүртгэлжүүлэв.

Бүрэлдэхүүн сургуулиудад судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 38 лабораториудаас 10 лаборатори итгэмжлэлийн тогтолцооны дагуу сорилт гүйцэтгэх ур чадвараа тогтоолгон магадлан итгэмжлэлийн гэрчилгээтэй, 2 лаборатори нь магадлан итгэмжлэлд хамрагдахаар бэлтгэж байгаа ба магадлан итгэмжлэлд хамрагдаагүй 26 лаборатори байна.

Лабораториудын магадлан итгэмжлэгдсэн байдал

ШУТИС-ийн харьяа хүрээлэнгүүдэд судалгааны 4 лаборатори үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 лаборатори нь сорилт болон шалгалт тохируулга, лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлагыг хангаж, сорилт гүйцэтгэх ур чадвараа тогтоолгон гэрчилгээ аван ажиллаж байна. Үүнд: УУХ, ХҮСХХ-ийн 2 лаборатори 6 удаа итгэмжлэгдсэн ба ДТҮЭХ-ийн лаборатори хамаарна.



Зураг 3.10. Судалгааны лабораторийн магадлан итгэмжлэгдсэн байдал

Магадлан итгэмжлэгдсэн лабораториуд

Хүснэгт 3.21

Харьяа болон бүрэлдэхүүний хүрээлэнгүүдийн лаборатори					
1	ДТҮЭХ	Зуух туршилтын лаборатори	2009	СБД 16-р хороо Бэлхийн 34-р гудамж ДТҮЭХ-ийн байр	Магадлан итгэмжлэгдсэн 2016-06-06 нд
2	УУХ	Геотехникийн лаборатори	1980	УУХ- 101 тоот	2002 оноос хойш 6 удаа магадлан итгэмжлэгдсэн
		Нүүрсний шинжилгээний лаборатори-хагас коксжуулалтын туршилтын лаборатори	1977	УУХ- 201 тоот	Магадлан итгэмжлэгдээгүй
3	ХҮСХХ	Сорилтын төвийн итгэмжлэгдсэн лаборатори	1979	ХҮСХХ -102, 103, 203, 204	2003 оноос 6 удаа магадлан итгэмжлэгдсэн

Салбар дундын нээлттэй лаборатори

Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв нэгжүүдэд 2015 оноос хойш худалдан авсан сургалт, судалгааны зориулалтаар ашиглагдаж байгаа өндөр нарийвчлалтай, тоног төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлт, багажны нэр, зориулалт, ашиглалтын хугацаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэсэн улс зэрэг үзүүлэлтээр нь бүртгэлжүүлэхэд

7 сургуулийн 22 лабораторийг нэгдсэн нээлттэй лабораториуд болгон ашиглах боломжтой байна.

Өндөр нарийвчлалтай багаж, тоног төхөөрөмжтэй лабораторийн жагсаалт

Хүснэгт 3.22

д/д	Бүрэлдэхүүн сургууль	Лабораторийн нэр	Лабораторийн хаяг	Лабораторийн эрхлэгч
1	БАС	Хөрсний механикийн лаборатори /сургалт, судалгааны лаборатори/	ШУТИС-ийн хичээлийн II байр 05 тоот	Ж.Алтанцэцэг
2		Байгууламжийн сорил шинжилгээний лаборатори /судалгааны/	ШУТИС-ийн хичээлийн Т-байр 106 тоот	М.Сугар
3		Барилгын материалын лаборатори/судалгааны сургал,	ШУТИС-ийн хичээлийн II байр 17 тоот	Б.Буянжаргал
4		Керамикийн материалын, Эрдэсийн лаборатори /судалгааны/	ШУТИС-ийн хичээлийн V байр 127 тоот	Б.Буянжаргал
5		Автозамын материал судлалын лаборатори /судалгааны/	ШУТИС-ийн хичээлийн V байр 121 тоот	С.Амарбуян
6		Гидравлик, гидромашини лаборатори/сургалтын/	ШУТИС-ийн хичээлийн E- байр 116 тоот	Б.Уранзаяа
7		Хүрээлэн байгаа орчин, усны шинжилгээний лаборатори/судалгааны/	ШУТИС-ийн хичээлийн II байр 101a,б тоот	Б.Лхагвадулам
8	ГУУС	Эрдэс баялгийн судалгаа, гео мэдээлэл сургалтын төвийн лаборатори	ШУТИС-ийн хичээлийн I байр 225 тоот	Ж.Эрдэнэбаяр
9		Геодезийн лаборатори	ШУТИС-ийн хичээлийн V байр 21 тоот	Ч.Цэцэгдэлгэр
10	МехТС	Металл хайлах лаборатори	МехТС-ийн хичээлийн 7-р байрны лабораторийн корпусын 214б тоот	М.Дэлгэрмаа
11		Цутгуурын лаборатори	МехТС-ийн хичээлийн 7-р байрны лабораторийн корпусын 121б тоот	М.Дэлгэрмаа
12		Биомеханикийн судалгааны лаборатори	ШУТИС-ийн сангийн E-10 тоот	Д.Ганбат
13	МХТС	Мэдээллийн сүлжээ, Аюулгүй байдлын лаборатори	МХТС-ийн 206 тоот	И.Идэрмөнх
14		Холбооны салбарын лаборатори	МХТС-ийн 127 тоот	Н.Эрдэнэхүү
15		Компьютерийн Ухааны салбарын програмчлалын технологийн лаборатори	МХТС-ийн 202 тоот	Э.Гэрэлмаа
16	ХШУС	Хатуу түлшний химийн технологи	ШУТИС-ийн 1-р байр 120 тоот	П.Мөнхбаатар
17		Математик тооцооллын лаборатори	ШУТИС-ийн 1-р байр 414тоот	Ц.Жаргалсайхан
18		Физик загварчлалын лаборатори	ШУТИС-ийн 1-р байр 404тоот	Г.Мөнхсайхан
19	ҮТС	Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв	Сонгино хайрхан дүүрэг, 4 хороо Хүнсчдийн гудамж, Мах	Г.Төрмөнх

			импекс ХК-ийн хашаанд, өөрийн байр	
20		НPLC-ийн судалгаа шинжилгээний лаборатори	ШУТИС, UTC,10-116	Х.Уртнасан
21	ЭХС	Үйлдвэрлэл ба технологийн процессын автоматжуулалтын лаборатори	ШУТИС-ийн хичээлийн 2 байр 518 тоот	Бя.Бат-эрдэнэ
22		Шингэн ба хийн динамикийн лаборатори	ШУТИС-ийн хичээлийн 2 байр Бл-403 тоот	Д.Цэрэндолгор

Мөнгөн ус болон урвалж бодис ашигладаг лабораторийн жагсаалт

Хүснэгт 3.23

Д/Д	Бүрэлдэхүүн сургууль	Лабораторийн нэр	Лабораторийг хариуцагчид
1	БАС	Хүрээлэн байгаа орчин, усны шинжилгээний лаборатори	Б.Лхагвадулам
2	ГУУС	Газрын тосны бүтээгдэхүүний лаборатори	В.Алимаа
3		Хээрийн судалгааны төв	Н.Манчук
4	МехТС	Цутгуурын лаборатори	М.Дэлгэрмаа
5	ХШУС	физик ба коллоид химийн лаборатори	Ш.Ган-Эрдэнэ
6		Нефть боловсруулалтын химийн технологийн лаборатори	М.Золтуяа
7		Органик ба хатуу түлшний лаборатори	М.Золтуяа
8		Аналитик хими	М.Энх-Үжин
9		Ерөнхий хими	Б.Мөнхпүрэв
10		Материал судлалын төв	Б.Мөнхпүрэв
11		Анализын нэгдсэн лаборатори	Ш.Ган-Эрдэнэ
12		Химийн технологийн лаборатори	Ө.Бекен
13	UTC	Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв	Г.Төрмөнх
14	ЭХС	Дулааны хэмжил хэмжүүрийн лаборатори	Ц.Жамбалсамбуу

3.7. БУСАД

Боловсруулсан дүрэм, журам

2017-2018 оны хичээлийн жилд дараах дүрэм журмуудыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж байна. Үүнд:

1. ШУТИС-ийн “Эрдмийн зөвлөлийн дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай ЭЗ-ийн хурлын 2018.01.11-ний өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан..
2. ШУТИС-ийн “Технологи дамжуулах журам” 2018.03.16-ны өдрийн А/48 тоот захирлын тушаалаар баталгаажуулсан.
3. ШУТИС-ийн дэргэд “Тарааны компани байгуулах журам, хөгжүүлэх журам”-ыг захирлын 2018.03.19-ний өдрийн А/52 тоот тушаалаар батлагдсан.
4. “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам”-д нэмэлт өөрчлөлт Захирлын 2018.03.12-ны өдрийн А/46 тоот тушаалаар тус тус батлуулан хэрэгжүүлж байна.

Багш нарын бүтээлийн чөлөө

“Бүтээлийн чөлөө олгох журам”-ын дагуу тус сургуулийн эрдэмтэн, профессор, багш нарт эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжлийн ном, сурах бичиг

хэвлүүлэх нөхцөлөөр хангах зорилготойгоор 10 багш, судлаачдад бүтээлийн чөлөө олгох, үргэлжлүүлэн ажиллахад нь холбогдох тушаал шийдвэр гаргуулж ажиллаа.


Багш нарын бүтээлийн чөлөө

Хүснэгт 3.24

Д/Д	Багшийн овог, нэр	Сургууль	Чөлөөний хугацаа
1	Г.Оюунбат	МехТС	2017.10.01-2017.12.31
2	М.Оюун-Эрдэнэ	ЭХС	2017.09.01-2017.12.01
3	А.Эрдэнэ	ЭХС	2017.09.01-2017.12.01
4	М.Бурмаа	БуХС	2017.09.18-2017.12.18
5	Т.Мөнхбат	МехТС	2017.09.01-2018.01.01
6	Г.Зоригт	ХШУС	2018.02.01-2018.05.01
7	Н.Насанбаяр	БАС	2018.01.29-2018.04.29
8	Ц.Ариунаа	МХТС	2018.03.13-2018.06.13
9	Ү.Ариунаа	ХШУС	2018.03.12-2018.06.12
10	Д.Ариунтогос	БуХС	2018.04.16-2018.07.16

Эрдмийн зэрэг хамгаалсан багш, судлаачид

Тайлант онд ШУТИС-ийн багш нарын 9 нь гадаадын их, дээд сургуульд, 15 нь дотоодын их сургуульд эрдмийн зэрэг хамгаалсан байна. Тэдгээрийг сургууль тус бүрээр нь авч үзвэл:



Зураг 3.11. Эрдмийн зэрэг хамгаалсан багш нар



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

ДӨРӨВ. ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1. ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ГАДААД ТОМИЛОЛТ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ

2017-2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд нийт 311 багш, ажилтан гадаадад томилогдон явж ажилласнаас ШУТИС-ийн зардлаар 218 хүн, хүлээн авагч талын зардлаар 52 хүн, төслийн зардлаар 33 хүн, хувийн зардлаар 9 хүн тус тус явсан байна.



Зураг 4.1. ШУТИС-ийн гадаад томилолтыг чиглэлээр ангилан авч үзвэл

Дээрх багш, ажилтнаас 111 хүн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан хөтөлбөр, ЭШ судалгааны ажилд оролцох ажлаар, 175 хүн ОУ-ын хурал, сургалт семинарт оролцох ажлаар, 25 хүн ОУ-ын үзэсгэлэн, уралдаан тэмцээнд оролцох ажлаар тус тус гадаадад томилогдон ажилласан байна.

ШУТИС-ийн профессор багш нарын гадаад томилолт (бүрэлдэхүүн сургууль бүрээр)

Хүснэгт 4.1

Сургууль	БАС	БүХС	ГУУС	МеТС	МХТС	УТС	ХШУС	ЭХС	ДаТС	Е-НИ	ГХИ	Захиргаа	ШУТАС	КООСЭН-Техн. Сур	БҮГД
Хамтарсан хөтөлбөр, төсөл, судалгаа ЭШ-ний ажил, ХА хөгжүүлэх ажлаар	2	11	11	14	4	8	17	15	1	1	5	18	0	4	111
ОУ-ын хурал, сургалт семинар	39	29	20	14	11	9	16	13	0	7	2	11	2	2	175
ОУ-ын үзэсгэлэн, тэмцээн, дадлага	5	2	1	2	9	3	2	1	0	0	0	0	0	0	25
Нийт	46	42	32	30	24	20	35	29	1	8	7	29	2	6	311

Гадаад томилолтыг 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар бүрэлдэхүүн сургуулиудын түвшинд авч үзэхэд ОУ-ын хурал, сургалт, семинар, хамтарсан хөтөлбөр, төсөл, судалгаа ЭШ, хамтын ажиллагаа хөгжүүлэх ажлаар гадаадад томилогдсон багш, ажилтны тоо давамгайлж байна.

Судалгаанд суурилсан их сургуулийн хүний нөөцийг бэлтгэх зорилтын хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн 41 багш, судлаачид урт хугацаагаар гадаадын хамтын ажиллагаатай их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад тухайн улсын засгийн газар болон их дээд сургууль ЭШ-ний байгууллагын тэтгэлэгээр магистр, докторантурын сургалтад хамрагдан суралцаж байна. Үүнд:

- ОХУ-д 20 хүн
- БНХАУ -д 5 хүн
- Япон -д 5 хүн
- БНСУ -д 6 хүн
- Итали -д 5 хүн



Зураг 4.2. Магистрантур, докторантурын сургалтад хамрагдаж буй ШУТИС-ийн багш, ажилчид, оюутны тоо

Мөн гадаадын их дээд сургууль, байгууллагатай байгуулсан гэрээ, хамтын ажиллагааны хүрээнд ОУ-ын IAESTE байгууллагын зардалаар 6 хүн, ERASMUS/MUNDUS зэрэг төслийн зардлаар 33 хүн, Японы Санко сэйки компанийн танилцах хөтөлбөрөөр 18 хүн, Акитагийн их сургуульд 2, “Санко Сэйки” компанитай байгуулсан гэрээний хүрээнд ШУТИС-ийн профессор багш, ажилтнууд 2018 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 3-ний өдрүүдэд Япон улсын их, дээд сургууль, технологийн хүрээлэнгийн сургалтын үйл ажиллагаа, лабораторийн орчин, судалгааны ажлын чиглэл, хүрсэн түвшинг судалж, өндөр технологийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, чанарын хяналтын системтэй танилцсан.


4.2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ

2017-2018 оны хичээлийн жилд гадаадын боловсрол, шинжлэх ухааны нийт 22 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ сунгаж, шинээр байгуулсан.

**Шинээр хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан гадаадын
их дээд сургууль, байгууллагууд**

Хүснэгт 4.2

Д/Д	Сургууль	Улс	Гэрээний ангилал	Он сар
1.	Уралын холбооны их сургууль	ОХУ	Гэрээ /нэмэлт өөрчлөлт/	2017.12.12
2.	Эрхүүгийн техникийн их сургууль	ОХУ	Гэрээ	2018.04.16
3.	Кубаны улсын их сургууль	ОХУ	Гэрээ	2018.04.23
4.	ОХУ-ын их дээд сургуулиудын “Ногоон байгууламж төв” консорциум	ОХУ	Санамж бичиг	2018.04.23
5.	Москвлагийн Барилга архитектурын Шинжлэх Ухааны Академи	ОХУ	Гэрээ	2018.06.15
6.	Бранденбургийн Технологийн их сургууль	ХБНГУ	Гэрээ	2017.10.14
7.	Мицүбиши корпораци	Япон	Гэрээ / сунгав /	2017.09.19
8.	Сүмитомо корпораци	Япон	Гэрээ / сунгав /	2018.03.23
9.	Глобал Траст Нэтворк компани	Япон	Гэрээ	2018.06.04
10.	Ат Нави Корпораци	Япон	Гэрээ	2018.06.04
11.	Нага-Окагийн технологийн их сургууль	Япон	Гэрээ / сунгав /	2018.06.04
12.	Конжу үндэсний их сургууль	БНСУ	Гэрээ	2018.06.05
13.	Чүн Юань Кристиан их сургууль	Тайвань	Санамж бичиг	2017.10.09
14.	Истанбул хотын Айдin их сургууль	Турк	Гэрээ	2018.02.13
15.	Бахчешихир их сургууль	Турк	Санамж бичиг	2018.04.06
16.	Техас мужийн Уйслиан их сургууль	АНУ	Гэрээ	2018.04.10
14	Цахар соёл судлалын нийгэмлэг	БНХАУ	Санамж бичиг	2018.04.20
15	Нанжин аж үйлдвэрийн их сургууль	БНХАУ	Санамж бичиг	2018.05.21
16	“Нари” групп	БНХАУ	Санамж бичиг	2018.05.22
17	Баруун хойд Хятадын Политехникийн их сургууль	БНХАУ	Гэрээ	2018.05.23
18	Өвөр Монголын Технологийн их сургууль	БНХАУ	Гэрээ	2017.09.26
19	Өвөр Монголын Үндэсний их сургууль	БНХАУ	Санамж бичиг	2017.09.26
20	Өвөр Монголын Химийн инженерчлэлийн мэргэжлийн сургууль	БНХАУ	Гэрээ	2017.09.27
21	Өвөр Монголын Барилгын техникийн сургууль	БНХАУ	Гэрээ	2017.09.27
22	Шанхай хотын Шинжлэх ухаан, технологийн их сургууль	БНХАУ	Гэрээ	2018.05.28



Зураг 4.3. Хамтын ажиллагааны гэрээ, саналж бичигт гарын үсэг зурав.

Мөн дээр дурдсанаас гадна гадаадын Монгол дахь ОУ-ын байгууллагууд, төлөөлөгчийн газруудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.

Тухайлбал: Япон Монгол улсын Засгийн газрын хооронд хэрэгжиж байгаа дээд боловсролын MJEED төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Японы Нагокагийн технологийн их сургууль, Кюшү их сургууль, Китамийн технологийн сургууль, Токиогийн технологийн их сургуулиудтай сургалтын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх ажлын хүрээнд нийт 15 багш 22 оюутан, Европын холбооны улсын ERASMUS төслөөр нийт 33 багш судлаачид хамруулан мэргэжил дээшлүүлээд байна.

4.3. ГАДААДЫН МЭРГЭЖИЛТЭН, БАГШ ЗОЧИН ПРОФЕССОР

2017-2018 оны хичээлийн жилд гадаадын их дээд сургууль, сайн дурын болон олон улсын байгууллагаас 13 багш, мэргэжилтэн ШУТИС-д 6 сар, түүнээс дээш хугацаагаар ажиллаж байна.

ШУТИС-ийн гадаадын мэргэжилтэн, багш нар

Хүснэгт 4.3

Харьяалагдах гадаадын байгууллага	Ажиллаж буй сургууль	Тоо
БНСУ-ын WITN байгууллагын мэргэжилтэн	ҮТС	4
БНСУ-ын НИРА байгууллагын мэргэжилтэн	ГУУС	1
БНХАУ-ын Шандуны их сургуулийн мэргэжилтэн багш	ГУУС	1
Японы сайн дурын мэргэжилтэн багш	ГХИ	1
АНУ-ын Төрийн департаментийн мэргэжилтэн	ГХИ	1
БНХАУ-ын Ханбаны их сургуулийн мэргэжилтэн багш	ГХИ	1
БНСУ-ын KOICA байгууллагын мэргэжилтэн	БИАС	1
Гэрээгээр	БУХС	1
Гэрээгээр	ЭХС	1
Гэрээгээр	КТК	1
Нийт		13

4.4. ОЮУТАН СОЛИЛЦОО, ГАДААД ОЮУТАН, ГАДААДЫН ТЭТГЭЛЭГ

4.4.1. Оюутан солилцоо

2017-2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн гадаадын их дээд сургуулиудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн хүрээнд нийт 83 оюутан солилцоо, гадаад оюутан, гадаадын тэтгэлэгт хамрагдаад байна.


Үүнээс БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Аж үйлдвэрийн технологийн их сургуульд "Химийн технологи", "Химийн инженерчлэл" мэргэжлээр 18 оюутан үйлдвэрлэлийн дадлагад, ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн улсын их сургуульд "Логистик менежмент", "Тээврийн менежмент" мэргэжлийн ангийн 23 оюутан танилцах дадлагад, ОХУ-ын Новосибирск хотын Сибирийн геосистем, технологийн их сургуульд "Хэрэглээний геодези"-ийн чиглэлээ олон улсын сургалт, дадлагад 9 оюутан, Япон улсын Бүнкёо их сургуулийн оюутан солилцооны хөтөлбөрт 2 оюутан, Япон улсын Китамигийн технологийн их сургуулийн оюутан солилцооны хөтөлбөрт 1 оюутан, ОУ-ын IAESTE байгууллагын техникийн солилцооны хөтөлбөрт газрын тос, эрчим хүч, архитектур, хүрээлэн буй орчны инженер, Мэдээлэлийн технологи, биотехнологийн зэрэг мэргэжлээр 6 оюутан, БНХАУ-ын Баруун хойд Политехникийн их сургуульд "2018-Summer Program" зуны сургалт, семинарт 4 оюутан, БНХАУ-ын Харбины Технологийн их сургуулийн зуны сургалтад 10 оюутан, New Solution группын тэтгэлэгээр БНСУ-ын их сургуулиудтай танилцах сургалт хөтөлбөрт 5 оюутан, Япон улсын Сакура Сайнс Хөтөлбөрийн тэтгэлэгээр Японы Шиба-Урагийн технологийн их сургуульд 5 оюутан шинжлэх ухааны семинар сургалтад тус тус хамрагдав.



Зураг 4.4. ШУТИС-ийн оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдсан оюутнууд

4.4.2. Гадаад оюутан


2017-2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд нийт 24 гадаад оюутан бакалавр, магистр, докторын түвшний хөтөлбөрт хамрагдан суралцаж байна. Үүнээс бакалавр оюутан 12, магистрант 6, докторант 6 оюутан тус тус суралцаж байна (зураг 4.5).



Зураг 4.5. Гадаад оюутны тоо улс орноор

ШУТИС-д суралцаж буй гадаад оюутнууд зардлын хэлбэрээр


- Засгийн газрын тэтгэлгээр 10 хүн
- Оюутан солилцоогоор 3 хүн
- Хувийн зардлаар 11 хүн



Зураг 4.6. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутны тоо
(бүрэлдэхүүн сургуулиар)

4.5. ГАДААДЫН ТЭТГЭЛГҮҮД

Хамтын ажиллагааны хүрээнд Японы Мицүбиши корпорацийн тэтгэлэгт 10 оюутан, тус бүр 1 сая төгрөг, Сүмитомо корпораци тэтгэлэгт 20 оюутан тус бүр 1 сая төгрөг, Санко-Сэйки группийн тэтгэлэгт 5 оюутан тус бүр 1 сая төгрөг, БНСУ-ын ПОСКО ТиЖи Парк сангийн тэтгэлэгт 10 оюутан тус бүр 700 ам. доллар, “Тоёота ШУТИС” сангийн тэтгэлэгт 20 оюутан тус бүр 500,0 төгрөгийн тэтгэлэгт тус тус хамрагдав. Гадаадын хамтын ажиллагаатай байгууллагаас ШУТИС-ийн оюутнуудад нийт 62 сая төгрөгийн тэтгэлэг олгогдоод байна.



Зураг 4.7. ШУТИС-ийн оюутнуудад олгогдсон гадаадын тэтгэлэг

ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй “ШУТИС-ийг олон улсын их, дээд сургуулиудын эрэмбэ /ranking/ тогтоох үйл явцад хамруулах нь”, Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй “Монголын үндэсний их, дээд сургуулийн эрэмбэ тогтоох аргачлал боловсруулах нь” төслүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2018 оны 06 сард төслийн явцын 2 дахь тайланг Эрдмийн дэд зөвлөлд танилцуулсан.



Зураг 4.8. “Дээд боловсролын бодлогын зөвлөмж” цуврал сэтгүүл



Зураг 4.9. “Боловсролын салбарын шинэчлэл ба залуусын ажил эрхлэлт” сэдэвт семинар

“Нийгмийн салбар дахь өөрчлөлт, шинэчлэлтийн менежмент” (MOST) хөтөлбөрийн ерөнхий үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, ЮНЕСКО-ийн Бээжин дэх салбартай хамтран “Нийгмийн салбар дахь өөрчлөлт, шинэчлэлтийн менежмент, Монгол улсын хөгжлийн хэрэгцээ: Боловсролын салбарын шинэчлэл ба залуусын ажил эрхлэлт” сэдэвт семинарыг зохион байгууллаа.

Семинарын гол зорилго нь нэгд, төрийн бодлого боловсруулагчид болон шийдвэр гаргагчдад эрдэмтдийн хийж байгаа судалгааны үр дүнг ашиглахад дэмжлэг үзүүлэх, хоёрт судлаачдаас бодлого төлөвлөлттэй уялдаатай судалгаа хийж, шийдвэр гаргагчдыг хэрэгцээтэй ойлгомжтой баталгаа нотолгоотой мэдээллээр хангах шинэ арга барилд шилжихэд сургах, бэлтгэл хангахад оршиж байсан бөгөөд семинарт хэлэлцүүлсэн Монгол улсын дээд боловсролын шинэчлэлийн талаар хэлэлцүүлж, санал солилцсоны үр дүнд гарсан дүгнэлтийг бодлогын зөвлөмж болгон гаргасан.

ЮНЕСКО-ийн MOST хөтөлбөр нь төрийн бодлого боловсруулахад оролцогч талуудыг холбон тэдний хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж судалгаанд суурилсан буюу судалгааны үр дүнгийн талаар бүрэн мэдээлэлтэй байж бодлого гаргахад дэмжлэг үзүүлэх гол зорилготой. MOST нь нийгмийн өөрчлөлтийг удирдах Засгийн газар хоорондын шинжлэх ухааны хөтөлбөр юм.



Зураг 4.10. ЮНЕСКО-ийн MOST хөтөлбөрийн тэргэжилтэн

4.6. ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШУТИС-ийн дотоод хамтын ажиллагаа, маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагааны хувьд 2017-2018 оны хичээлийн жилд их сургуулийн сургалт судалгааны ажлын явц, үр дүнг олон нийтэд танилцуулан сурталчлах, байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны хамрах хүрээг дотоод, гадаадад тэлэх, байнгын болон зорилтот хэрэглэгчийг сэдэлжүүлэх зорилгоор 4 чиглэлээр нийт 57 ажил хийж гүйцэтгэв.

4.6.1. Маркетингийн бодлого боловсруулах ажлын хүрээнд

Тус хичээлийн жилд ШУТИС нь Маркетинг, олон нийттэй харилцах албыг шинээр байгуулж ШУТИС-ийн маркетингийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, маркетингийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Б.Сүхбатын удирдлага доор БүХС-ийн захирал Б.Энхбат, профессор багш нар анхан шатны дотоод, гадаад орчны судалгаа хийж цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлын төлөвлөгөөний саналыг боловсруулан хэлэлцүүлсэн байна.

Зохион байгуулсан хэлэлцүүлэг

Хүснэгт 4.4

№	Хэлэлцүүлгийн сэдэв	Хугацаа	Хэлэлцүүлсэн нэгж	Шийдвэр, санал
1	“ШУТИС-ИЙН МАРКЕТИНГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ”	2017/12/22	Профессор, багш нар нээлттэй хэлэлцүүлэг	Маркетингийн хөтөлбөр, боловсруулан хэрэгжүүлэх
2	“ШУТИС-ИЙН МАРКЕТИНГИЙГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ БА ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО”	2017/12/24	ШУТИС-ийн залуу багш, ажилтны анхдугаар чуулга уулзалт	ШУТИС-ийн үнэт зүйл, алсын хараа, эрхэм зорилго зэргийг илүү элсэгч, суралцагч, төгсөгч нарын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайжруулах
3	“ШУТИС-ИЙН МАРКЕТИНГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ САНАЛ”	2018/01/23	Захирлын зөвлөлийн хурал	ШУТИС-ийн маркетингийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх
4	“ШУТИС-ИЙН МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ САНАЛ”	2018/02/21	БүХС	Тусгайлан төсөв шаардлагагүй маркетингийн үйл ажиллагааг шат дараалан хэрэгжүүлэх

Зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүдийн зөвлөмж, профессор багш нарын саналыг үндэслэн (Д.Баярмаа, Д.Ганбаатар) ШУТИС-ийн орчны, өрсөлдөгчийн, хэрэглэгчийн шинжилгээ, гадаад орчны иж бүрэн судалгаа хийж, олон улсын их дээд сургуулийн маркетингийн стратегийг туршлага зэргийг судлан Маркетингийн стратеги төлөвлөгөө боловсруулах чиглэлийн дагуу ажиллаж байна.



Зураг 4.11. ШУТИС-ийн залуу багш, ажилтны анхдугаар чуулга уулзалт

4.6.2. Хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажил

ШУТИС-ийн өдөр дутмын үйл ажиллагааг таниулах, нэр хүндийг өсгөх, тодорхой имижийг бүрдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг оновчтой сонгох, хамтран ажиллах гэрээ байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг сонгохдоо зорилтот хэрэглэгчид, илгээлтийн онцлог зэргийг харгалзан үзэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн судалгаа боловсруулан гаргадаг “Максима Медиа” ХХК-ний судалгаа ашиглав.

Тайлант хугацаанд гэрээ байгуулан хамтран ажилласан 11 байгууллагаас өдөр тутмын сонин 6, телевиз 2, сайт 3 байна. Гэрээний нөхцлийн дагуу 11 байгууллагаас 9 байгууллагатай 20-30 хувийн үнийн дүнгийн хөнгөлт үзүүлэх нөхцөл бүхий гэрээ байгуулсан.

- Гэрээ байгуулсан өдөр тутмын сонин – 6
- Гэрээ байгуулсан телевиз – 2
- Веб сайт – 3

Хамтран ажиллах гэрээ байгуулж, ажилласан ОНМХ-ийн жагсаалт

Хүснэгт 4.5

№	Сонин	Гэрээний дугаар	Хугацаа	Хөнгөлөлт
СОНИН				
1.	“Зууны мэдээ” сонин	“2018/15	1 жил	30 хувь
2.	“Монцамэ агентлаг”	“2018/06	1 жил	30 хувь
3.	“Open Door” сонин	“2018/03	1 жил	30 хувь
4.	“Үндэсний шуудан” сонин	“2018/02	1 жил	20 хувь
5.	“Өнөөдөр” сонин	“2018/04	1 жил	20 хувь
6.	“Өдрийн сонин”	“2018/04	1 жил	20 хувь
ТЕЛЕВИЗ				
1.	UBS телевиз	“2018	1 жил	30 хувь
2.	Эх орон телевиз	“2018	1 сар	

САЙТ				
1.	“Монцамэ агентлаг” сайт	°2018/06	1 жил	30 хувь
2.	www.ner.mn	°2018/03	1 жил	30 хувь
3.	Масс Ти Ви MASS AGENCY GROUP	°2018/09		

4.6.3. Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа

Тус ажлын хүрээнд мэдээллийн илгээлтийг бэлтгэхдээ 2018-2019 оны хичээлийн жилийн Элсэлтийн үйл ажиллагаанд чиглүүлэн “Их сургуулийн үйл ажиллагааны давуу талыг таниулах, нэр хүндийг өсгөх, тодорхой имижийг бүрдүүлэх, хоногшуулах” чиглэлтэй ажилласан. Нийт бэлтгэсэн ярилцлага, мэдээ - 11, сайтын мэдээлэл - 7, телевизийн цуврал нэвтрүүлэг - 7, зохиомжит теле нэвтрүүлэг - 1, богино хэмжээний видео бичлэг - 2, телевизийн мэдээ -12 бэлтгэн хүргэсэн байна.

А. ӨДӨР ТУТМЫН СОНИНД ХЭВЛҮҮЛСЭН СОНИНЫ ЯРИЛЦЛАГА, ЗАР, МЭДЭЭ

Өдөр дутмын сонинд хэвлүүлсэн сонины ярилцлага,
мэдээ мэдээлэл

Хүснэгт 4.6

№	Сонин	Дугаар	Сэдэв
1	“Нээлттэй хаалга” сонин	2018.02.23-03.02 №07(185)	ШУТИС хичээлийн шинэ байртай болно
2	“Нээлттэй хаалга” сонин	2018.03.30-04.06 №12(190) ШУТИС-ийн ХШУС-ийн профессор Г.Саран	21 зууны дэвшилтэт технологид материал судлал орно
3	“ШУТИС Мэдээлэл”	2018.03 008(41) “ДЦС-4”-ийн цахилгааны инженер А.Батзориг	Би сургуулиараа хаана ч, хэзээ ч бахархдаг
4	“ШУТИС Мэдээлэл”	2018.03 008(41) ШУТИС-ийн ХШҮЭ дэд захирал Ц.Баатархүү	Чанарын удирдлагын тогтолцоог ШУТИС-ийнхаа захиргаанд нэвтрүүлнэ
5	“Монголын мэдээ”	2018.04.12 №15(655) ШУТИС-ийн багш Ц.Энхцолмон Япон мэргэжилтэн багш, оюутнууд	Инженер технологийн дээд боловсрол төслийн үр дүн
6	“Монголын мэдээ”	2018.04.12 №15(654) Төслийн удирдагч Б.Намсрай	Инженер технологийн дээд боловсрол төслийн үр дүн
7	“Үндэсний шуудан”	2018.04.18 №077 (3031) ЭШХА эрхэлсэн проректор Т.Намнан	Инженерийг хөгжлийн бодлогод тулгуурлан бэлтгэх ёстой
8	“Зуны мэдээ”	№82,83 (5789, 5790) ШУТТНС-гийн захирал Ч.Гулнар	Дэлхийн номын өдрийг өргөн цар хүрээтэй тэмдэглэх учиртай
9	“Нээлттэй хаалга” сонин	2018.05.18-25 №19(197) ШУТИС-ийн УЗ-гийн гишүүн Д.Болор	Залуус бидний одоо ба угтах ирээдүй
10	“Өнөөдөр” сонин	2018.05.02 Лхагва №085(6378) ШУТИС-ийн	ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2018-2019 оны

		Сургалтын хөтөлбөр, бүртгэлийн албаны дарга Д.Батдорж	хичээлийн жилд оюутан элсүүлэх журам
11	“Зууны мэдээ” сонин	2018.06.27 Лхагва №129(5836) ШУТИС-ийн Сургалтын хөтөлбөр, бүртгэлийн албаны дарга Д.Батдорж	ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2018-2019 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам
12	Нээлттэй хаалга” сонин	2018.06.29 №24 ШУТИС-ийн ЭХС-ийн багш Д.Үлэмж	“Эрчим салбар, одоо ба ирээдүй”



Зураг 4.12. Өдөр тутмын сонин сэтгүүлд гарсан мэдээлэл

Сайт дээр гарсан мэдээ мэдээллийн жагсаалт

Хүснэгт 4.7

№	Огноо	Сайт/холбоос	Сэдэв
1	MONTSAME.MN 2018-02-23	http://montsame.mn/read/81754	ШУТИС хичээлийн шинэ байртай болно.
2	IKON.MN 2018-3-14	https://ikon.mn/n/18ot	ШУТИС-иас 96 суралцагч Япон улсад суралцах батламжаа авлаа.
3	MONTSAME.MN 2018-03-19	http://montsame.mn/read/84026	ШУТИС шинэ үеийн инженер бэлтгэх “CDIO” сургалтын аргыг нэвтрүүлж байна
4	NER.MN 2018-05-25 Уншигчын тоо: 3691	http://ner.mn/p/919	Залуус бол бидний одоо бас угтах ирээдүй. Инженерийн мэргэжил хамгийн чухал.
5	NER.MN 2018-06-26 Уншигчын тоо: 11335	http://ner.mn/p/944	ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилийн элсэлтийн бүртгэл 2017 оны 07 дугаар сарын 1-нээс эхлэнэ.
6	ELSELT.MN	http://www.elselt.mn/o/13	ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилийн элсэлт ХШУС-ийн сурталчилгаа
7	NER.MN 2018-04-24 Уншигчын тоо: 12769	http://ner.mn/p/873	ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн

Б. ТЕЛЕВИЗ, САЙТ, ПЭЙЖ ХУУДСААР ДАМЖУУЛАН НЭВТРҮҮЛСЭН НЭВТРҮҮЛГҮҮД

2018-2019 оны хичээлийн жилийн элсэлтэд зориулсан сурталчилгааг телевиз, сайт (live), пейж хуудсаар 2018 оны 3 дугаар сараас эрчимтэй сурталчлах ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

Сурталчилгааны ерөнхий төлөвлөгөө

Хүснэгт 4.8

	Сар	Б	Н	Д	М	Л	П	Б	Б	Н	Д	М	Л	П	Б	Б	Н	Д	М	Л	П
“ШУТИС-ЭЛСЭЛТ СУРТАЛЧИЛГАА I”	III-V																				
ЭЭШ	VI	1 6	1 7	1 8	1 9	2 0	2 1														
“ШУТИС-СУРТАЛЧИЛГАА II”	VI							2 2	2 3	2 4	2 5	2 6	2 7	2 8	2 9	3 0					
МИДСК БҮРТГЭЛ	VII																1	2	3	4	5
ШУТИС-ийн БҮРТГЭЛ	VII																1	2	3	4	

“ШУТИС-ЭЛСЭЛТ СУРТАЛЧИЛГАА I” ажлын хүрээнд ШУТИС-ийн бакалаврын 60 хөтөлбөр, 100 мэргэжлжил, гадаадын их дээд сургуультай хамтарсан хөтөлбөрийн талаар UBS, TV9, TV5, SBN, Эх орон, МҮОНРТ телевизийн нэвтрүүлгүүдээр дэлгэрэнгүй ярилцлага хийсэн.

Мэдээлэл, илгээлтийн агууллага:

- А. Сургалтын хөтөлбөр, мэргэжлүүд
- В. 2+2 хөтөлбөр

- C. Оюутны сургалтын тэтгэлэг
D. Мэргэжлийн онцлог

“ШУТИС-ЭЛСЭЛТ СУРТАЛЧИЛГАА I”

Хүснэгт 4.9

№	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Бүрэлдэхүүн сургууль	Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирлууд
1.	“UBS” Кофе юу? Цай юу?	БАС	Ж.Азжаргал
		БУХС	Д.Ганбаатар
		ГУУС	Н.Буянхишиг
2.	Энэ өдөр мэдээллийн хөтөлбөрийн зочин	МТС	Ж.Хашбат
		ГХИ	Ц.Энхбаатар
3.	“TV5” Гэгээн өдөр	МХТС	З.Буянхишиг
		ХШУС	А.Сарнай
4.	“SBN” Өдрийн зочин	Захиргаа ЭХС	Х.Отгон-Эрдэнэ Б.Пүрэвсүрэн
		Захиргаа УТС	Д.Батдорж П.Булга
6.	“МҮОНРТ” Өглөөний зочин	Захиргаа	Д.Батдорж
7.	TV5 Гэгээн өдөр	ДарТС	Я.Батцэцэг



Зураг 4.13. Телевизийн нэвтрүүлгүүд

“ШУТИС-ЭЛСЭЛТ СУРТАЛЧИЛГАА II” ажлын хүрээнд тус хичээлийн жилийн хаврын улирлын төгсөлтийн ёслолын нэгдсэн ажиллагааг СБЗГ, СХА, ОСҮА-уудтай хамтран зохион байгуулж элсэлтийн дам сурталчилгааны мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан хүргэсэн. Тус ажлын хүрээнд төгсөлтийн ёслолын арга хэмжээг Mass agency group-тэй хамтран live хийж шууд дамжуулсныг нийт 40.000 мянган хүн үзэж, 472 удаа дамжуулсан байна.

Мэдээлэл, илгээлтийн агуулга:

- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг амжилттай гүйцэтгэж байна.
- Хоёр орны их сургуулийн хос дипломтой төгсөнө.
- Монголын хамгийн эрэлт ихтэй 20 мэргэжлийн жагсаалтад ШУТИС-ийн сургалт явуулж буй 12 мэргэжил багтсан.

**“ШУТИС-ЭЛСЭЛТ СУРТАЛЧИЛГАА II” ажлын
хүрээнд хийсэн нэвтрүүлгүүд**

Хүснэгт 4.10

№	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Ярилцлага өгөх хүн	Огноо	Нэвтрүүлэг
ТЕЛЕВИЗЭЭР СУРТАЛЧИЛАХ				
1	МУОНРТ	Б.Очирбат	2018/6/23	Мэдээллийн хөтөлбөр
2	NTV	Б.Очирбат	2018/6/23	Мэдээллийн хөтөлбөр
3	TV9	Х.Энхжаргал	2018/6/23	Мэдээллийн хөтөлбөр
4	TV5	Д.Гэрэлт-Од	2018/6/23	Мэдээллийн хөтөлбөр
ШУУД НЭВТРҮҮЛЭГ				
5	Mass agency group	Оюутан, багш нар	2018/6/23	Шууд дамжуулагч




Зураг 4.14. ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилийн 80 дахь төгсөлтийн ёслолын нэгдсэн арга хэлжээ

“ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА НЭВТРҮҮЛЭГ”

“Эх орон” телевизтэй хамтран чанартай боловсрол ирээдүйн баталгаа 30 минутын теле нэвтрүүлгийг бэлтгэж 2018 оны 6 дугаар сарын 13, 23, 29-ний өдрүүд, Эфирийн оргил цагаар нийт 3 удаа “Эх орон” телевизээр нэвтрүүлсэн бөгөөд “Шинжлэх Ухаан, технологийн их сургууль”, “Эх орон” телевизийн пэйж хуудсанд байрлуулсныг 2018 оны 7 дугаар сарын 4-ний байдлаар нийт 31.600 хүн үзсэн байна.

Мэдээлэл, илгээлтийн агууллага:

- Сургалтын хөтөлбөр, мэргэжилүүд
- 2+2 хөтөлбөр
- Оюутны сургалтын тэтгэлэг
- Мэргэжлийн онцлог
- Сургалтын орчин
- Манай төгсөгчид гадаадад мэргэжлээрээ ажилладаг
- ШУТИС-ийн оюутнууд хөгжих бүх нөхцөл боломжоор хангагддаг
- Өндөр зэрэглэлийн багш, судлаачид ШУТИС-д ажилладаг



Зураг 4.15. “Чанартай боловсрол – ирээдүйн баталгаа” нэвтрүүлэг

Тус ажлын хүрээнд “ШУТИС-ийн хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр, мэргэжил” 1 минут 55 секундын видео бичлэг (2018.7.4-ний байдлаар 7300 хүн үзсэн), “Олон улсын хамтарсан хөтөлбөр” 1 минут 28 секундын видео бичлэг (2018.7.4-ний байдлаар 7300 хүн үзсэн) бэлтгэн олон нийтийн сошиал маркетинг хийж байна.



Зураг 4.16. “ШУТИС-ийн хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр, мэргэжил” видео бичлэг



Зураг 4.17. “Олон улсын хамтарсан хөтөлбөр” видео бичлэг

В. ОНЦЛОХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭЖ ХҮРГЭХ

Тус ажлын хүрээнд ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй бусад их, дээд сургуулиас ялгарах давуу талаа харуулах зорилготойгоор онцлох мэдээ, мэдээллийг бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан хүргэсэн.

Мэдээлэл, илгээлтийн агуулга:

А. ШУТИС-ийн төгсөгч инженерүүд Японд ажиллах боломжтой боллоо.

- В. Хөдөлмөрийн зах зээл дээр инженер, технологийн мэргэжилтэн хамгийн эрэлттэй бөгөөд цаашдаа ч эрэлт хадгалагдах болно. Үүний жишээ бол ШУТИС юм.
- С. Боловсролын зээлийн сан болон ШУТИС "Дээд боловсролын байгууллагатай хамтран ажиллах гэрээ" байгуулснаар суралцагчид БЗС-гаас үйлчилгээ авах боломжтой боллоо.
- Д. ШУТИС-ийн МТС их дээд сургуулиудын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоог анхлан хэрэгжүүлэгч.
- Е. ШУТИС орчин үеийн сургалт, судалгааны 8 дугаар байртай болно.
- Ү. ШУТИС инженерийн зохион бүтээх үйл ажиллагааг хөгжүүлэх, инженерчлэлийн инноваци, шинэ бүтээл оновчтой саналыг дэмжиж байна.
- Г. CDIO-ийн стандарт, арга зүйгээр сургалтын үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулснаар дотоодод төдийгүй олон улсад магадлан итгэмжлүүлэх хөтөлбөрүүдийн тоо нэмэгдэж, зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй, боловсролтой шинэ зууны иргэнийг бэлтгэх боломж нэмэгдэх юм.



Зураг 4.18. "TV9" телевизийн Энэ одор тэдээллийн хөтөлбөр



Зураг 4.19. SBN, TV8, TV25, "Өлзий TV", Royal, Star телевизийн тэдээллийн хөтөлбөр



Зураг 4.20. SBN, ROYAL телевизийн тэдээллийн хөтөлбөр



Зураг 4.21. SBN, TV8, TV25, Ulzii TV, Royal, Star, Сүлд телевизийн мэдээллийн хотолбор



Зураг 4.22. SBN телевизийн мэдээллийн хотолбор



Зураг 4.23. SBN, Royal, Star, Сүлд телевизийн мэдээллийн хотолбор

Г. ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

“Боловсролын шинэчлэл-2018” үзэсгэлэн яармаг: 2018 оны 4 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд “Мишээл экспо төвд” зохион байгуулагдаж ШУТИС-ийн МОНХА, СХБА-тай хамтран оролцлоо. Үзэсгэлэнгийн зорилго нь дээд боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, боловсролын бодлогын асуудлыг сурталчлах, боловсролын салбарын хөгжлийн түвшин, өнөөгийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах юм. “Боловсролын шинэчлэл-2018” үзэсгэлэнд ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгчид оролцсоноор нийгэмд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлүүдийн талаар мэдээлэл авч, мэргэжлээ зөв сонгоход нь мэргэжлийн багш туслалцаа үзүүлсэн юм. Түүнчлэн их, дээд сургууль, коллежид элсэгчдэд шалгалтаа өгөх болон бүртгүүлэхэд нь шаардлагатай заавруудын талаар танилцуулах, олон нийтэд дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл өгсөн.



Зураг 4.24. “Боловсролын шинэчлэл-2018” үзэсгэлэнгийн үеэр

"Шилдэг боловсрол - 2018" үзэсгэлэн яармаг: Монголын оюутны холбоо, Монголын залуучуудын шинэ давлагаа төрийн бус байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдөд гадаад болон дотоодын их, дээд сургууль, коллежуудын элсэлтийн үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг хүргэх зорилгоор "Шилдэг боловсрол - 2018" үзэсгэлэн яармагийг 2018 оны 7 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд Blue Sky цамхгийн нэг давхрын үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулсан бөгөөд тус үзэсгэлэнд МОНХА нь бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш нартай хамтран сургалтын хөтөлбөр, мэргэжлүүдээ нийт 682 ЕБС сургуулийн төгсөгчдөд танилцуулав.




Зураг 4.25. "Шилдэг боловсрол - 2018" үзэсгэлэн яармагийн үеэр

Д. ШУТИС-ИЙН АЛБАН ЁСНЫ ОЛОН НИЙТИЙН ПЕЙЖ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

ШУТИС-ийн нэр хүнд, бүтээгдэхүүн үйлчилгээг бага зардлаар олон нийтэд таниулах, сурталчлах, улмаар бүтээгдэхүүн үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх, шинэ хэрэглэгчдийг татах, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг цаг алдалгүй олон нийтэд хүргэх зорилгоор “Шинжлэх ухаан,




технологийн их сургууль” олон нийтийн пейж хуудсыг хөгжүүлж байна. Тус пейж хуудсыг 2018 оны 6 дугаар сарын 6-наас эхлэн идэвхжүүлэн хөгжүүлсэн бөгөөд 2018 оны 7 дугаар сарын 4-ний байдлаар нийт 11,163 дагагчидтай, хуудас таалагдсан хүмүүсийн тоо 10,966 байна. Идэвхүүжэлтийн хугацаанд нийт 43 удаа мэдээ, мэдээлэл, видео нийтлэж, 9 удаагийн бүүст хийгээд байна. Пейж хуудсанд байралсан видео бичлэг хүрсэн хүний тоо 35,530, нийтлэлийн даралт 3802, хариу үйлдэл үзүүлсэн 557, зураг хүрсэн хүний тоо 27,036, нийтлэлийн даралт 3084, хариу үйлдэл үзүүлсэн 434 хүн байна.



Зураг 4.26. ШУТИС-ийн пейж хуудас таалагдсан хүмүүсийн тоон үзүүлэлт






Зураг 4.27. ШУТИС-ийн пейж хуудасны дагагчдын тоон үзүүлэлт



Зураг 4.28. Нийтлэлийн тоон үзүүлэлт

ШУТИС-ийн албан ёсны олон нийтийн пейж хуудсаар дамжуулсан идэвхижүүлэлт хийсэн мэдээллийн (BOOST) жагсаалт
Хүснэгт 4.11

№	Бүүст хийх мэдээлэл	Хугацаа
1	ШУТИС-ийн танилцуулга	06.26
2	Элсэгчдэд зориулсан гарын авлага	06.27
3	“Чанартай боловсрол ирээдүйн баталгаа” нэвтрүүлэг	06.28
4	Элсэлтийн бүртгэлийн мэдээлэл	06.29
5	Хөтөлбөр, мэргэжлийн танилцуулга	06.30
6	Сүлд дуу. "ШУТИС-Бидний бахархал"	07.01
7	Элсэлтийн бүртгэлийн мэдээлэл	07.02
8	Олон улсын хөтөлбөр танилцуулга	07.03
9	Элсэлтийн бүртгэлийн мэдээлэл	07.04
Нийт		9 өдөр

18.06.29 23:37		ШУТИС-ийг сонг он суралцах гэж			62.2K		11.2K 837		
18.06.28 21:01		"ШУТИС-Чанарт ай боловсрол ир			47K		4.5K 416		
18.06.28 1:44		Шинжлэх ухаан, технологийн их с			39.2K		4.4K 818		
18.06.27 21:13		ШУТИС-ийн элсэ гчдэд зориулсан			102.8K		10.8K 1.3K		
18.06.27 2:27		Элсэлтийн вэб w ww.elselt.edu.mn			116.2K		9.2K 1.9K		

Зураг 4.29. Пэйж хуудасны хандалт

Олон нийтийн пэйж хуудас дах мэдээллийн үр дүнгээс харахад хамгийн өндөр хандалттай мэдээлэл:

1. “ШУТИС-ийн Элсэлтийн вэб”-ийн мэдээлэл хүрсэн хүний тоо 116.200, нийтлэлийн даралт 9200, хариу үйлдэл үзүүлсэн 1900
2. “ШУТИС-ийн элсэгчдэд зориулсан гарын авлага” хүрсэн хүний тоо 102.800, нийтлэлийн даралт 10.800, хариу үйлдэл үзүүлсэн 1300
3. ШУТИС-ийг сонгон суралцах элсэгчдэд зориулсан мэдээлэл хүрсэн хүний тоо 62.200, нийтлэлийн даралт 11.200, хариу үйлдэл үзүүлсэн 837
4. “Чанартай боловсрол ирээдүйн баталгаа нэвтрүүлэг” хүрсэн хүний тоо 47.000, нийтлэлийн даралт 4500, хариу үйлдэл үзүүлсэн 416
5. “ШУТИС 3 дах удаагаа магадлан итгэмжлэгдэв” хүрсэн хүний тоо 39.200, нийтлэлийн даралт 4400, хариу үйлдэл үзүүлсэн 818 байна.



ТАВДУГААР БҮЛЭГ

ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

ТАВ. ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨЛӨВШИЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШУТИС-ийн сургалтын систем, хөтөлбөрийн онцлогийг таниулах, оюутнуудын ая тухтай суралцах нөхцөл бололцоог хангах, тэднийг дэмжин ажиллах, ёс зүйтэй төлөвшсөн иргэн болгон хүмүүжүүлэх зорилгын хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилд үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Оюутанд чиглэсэн сургалт семинар

Хүснэгт 5.1

Д/д	Сургалтын нэр	Илтгэгч	Хугацаа	Оролцсон оюутны тоо
1	Нэгдүгээр курсийн зөвлөх багш нарт “Оюутны төлөвшилд багшийн оролцоо” сэдэвт семинар	СБЗГ-ын дарга, доктор, дэд профессор Д.Гэрэлт-Од багш нарт оюутнаа төлөвшүүлэх, өөрийн ажлын үр дүнг сайжруулахыг анхааруулж холбогдох мэдээллийг өглөө. СБА-ны дарга Д.Батдорж Сургалтын үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлын талаар мэдээллийг өгч багш нарын санал бодлыг сонсож харилцан санал солилцлоо. ОСҮА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмаа Оюутанд үзүүлэх үйлчилгээ, түүний үр дүнгийн асуудлаар мэдээлэл хийж багш, оюутнуудын хамтын ажиллагаа, I курсын оюутанд “Оюутны сайн дурын оролцоог дүгнэх” хуудсыг мөрдөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцууллаа. Мөн БүХС-ийн ХУС-ын дэд профессор, доктор Ц.Батцэрэн ШУТИС-ийн багш, оюутны харилцаа хандлагын талаар лекц уншлаа.	2017 оны 08 сарын 25 нд	Нэгдүгээр курсийн зөвлөх багшаар ажиллах 8 сургууль 1 институтын 58 багш оролцов.
2	Амжилттай суралцах нь	МХТС-ийн ахлах багш Ц.Ариунаа, ЭХС-ийн профессор, доктор, дэд профессор Б.Сэргэлэн, Салбар бүрийн профессор багш нар тус тус уншсан	2017.09.18 -22	1700 гаруй оюутан 16 зөвлөх багш
3	Хувь хүний ёс зүй, төлөвшил	ГХИ-ийн Европ Судлалын тэнхимийн эрхлэгч, доктор,		

		дэд профессор Г.Туяа, УТС-ийн захирал доктор Д.Булга, ГХИ-ийн ахлах багш, доктор Н.Мэнд		
4	Хотын соёл аяны хүрээнд (Гэмт хэрэг, хэв журмын зөрчил, Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх лекц,)	Монголын түүхийн багш нар НЗЦГ, НЦГ, НПП-ын албан хаагчид болон мэргэжилтэн	Хичээлийн жилийн хавар, намрын улиралд	3500 оюутан 11 багш, ЗЦГ-ийн 18 албан хаагч, НЦГ-ийн 5 албан хаагч, НПП-ийн 9 албан хаагч
5	Санхүүгийн мэдлэг олгоход чиглэсэн сургалт, сурталчилгаа	Голомт банкны салбарын захирал Д.Бадрал	2017 оны 9 сард	Оюутнуудын хичээлийн шинэ жилд зориулан санхүүгээ хэрхэн зохицуулах талаар лекц угшуулсан нийт 130 оюутан хамрагдав.
6	“Дээд боловсрол: Ёс зүй, ил тод, шударга байдал” Хэлэлцүүлэг	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг оюутны зөвлөлүүд	2018.03 сард	Бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөлүүдээс 2 оюутан сургагч башаар суралцаж 400 гаруй оюутанд мэдээллийг хүргэсэн.
7	Транспэрэнси Интернэйшнл Монгол байгууллага	Транспэрэнси Интернэйшнл Монгол байгууллагын лектор багш нар лекц уншсан	2017.10.11	Авлигын тухай ойлголт олгох сургалтанд нийт 190 гаруй оюутан хамрагдаж БУХС-ийн 2 багш оюутнуудын хамтаар Олон Улсын Авлигын Эсрэг өдрийг тохиолдуулан "Transparency Award" шагнал гардуулах арга хэмжээ буюу кино өдөрлөгт оролцсон.
8	“Хандлага Нэрэгч” цуврал лекц	Лекцэнд Ж.Алтаншагай, Ч.Ганжавхлан, Ж.Золбаяр, С.Эрдэнэболд, Л.Оюун-Эрдэн, С.Жавхлан нарын нийгэм улс төрийн манлайлал болсон залуучуудаар лекц уншуулав.	2018 оны 03-06 сарын хооронд	Оюутан залууст зөв хандлага, эерэг уур амьсгал залуус бие биэндээ манлайллыг бий болгоход чиглэсэн цуврал сургалтыг танхимд зохион байгуулан

				онлайнаар нийт 2000 гаруй залууст хүргэх баазыг бий болгосон.
9	Хэв журам сахиулах сургалт, сурталчилгаа	ОСҮА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмаа	2018.05 сард 4 удаа	Биеийн тамирын аялалын хичээл сонгосон нийт 1200 гаруй эрэгтэй оюутнуудад хүргэсэн
10	АНУ-ын Үндэсний Эрүүл мэндийн хүрээлэнгийн санхүүжилттэй сургалт, үзлэг	Монголын эрүүл мэндийн үүсгэл НҮТББ-ын гүйцэтгэх захирал Б.Уянга	2018 оны 03-04 сард	120 орчим оюутанд сургалт, 50 багш оюутанд үнэгүй үзлэг оношлогоог хийлгэсэн.
11	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	Засгийн газрын реферэнт Э.Батжаргал	2017.11.02	Нийт 2 арга хэмжээнд 633 оюутан хамрагдлаа.
12	Ажилд ороход анхаарах зүйлс	АПУ ХК-ний маркетингийн менежер Б.Уранжаргал		
13	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаарх ерөнхий ойлголт олгоход чиглэсэн online сургалтын зар сурталчилгааг тавьж оюутнуудад хүргэсэн	ГУУС-ийн Геологи, гидрогеологийн салбарын профессор, доктор (Ph.D), С.Жаргалан, ГУУС-ийн Уул уурхайн менежментийн профессор, доктор (Ph.D) Б.Оюунчимэг, МХТС-ийн Электроникийн салбарын ахлах багш Ц.Тэнгис, БуХС-ийн технологийн менежментийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор Л.Оюунцэцэг, ГХИ-ийн Ази судлалын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа, ҮТС-ийн дизайны салбарын дэд профессор, доктор Б.Сэргэлэн	2017 оны 10 сар, 2018 оны 3 сар	сургалтын видео бичлэгийг must.edu.mn -д байршуулан сурталчилсан.1695 views
14	“Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газраас цагийн ажил хайх, иргэд, оюутан суралцагчдыг цагийн ажилд зуучлах болон гарааны бизнесийг	Хөдөлмөр эрхлэлтийн газрын сургалт, судалгаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Г.Долгорсүрэн	2018 оны 05 сар	120 оюутан хамрагдав.

	дэмжих арга хэмжээ”			
15	“Ирээдүйн карьер ба амжилт”	Оюуны чадвар ТББ-ын үүсг байгуулагч, лектор Г.Мөнгөн	2018 оны 05 сар	120 оюутан хамрагдав.
16	“Нийгмийн даатгалын төрөл, сайн дурын даатгал түүний ач холбогдол”	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Үйл ажиллагааны хөгжлийн хэлтсийн дарга М.Гэрэлмаа Б.Номиншагай	2018 оны 05 сар	120 оюутан хамрагдав.
17	ШУТИС-иас оюутнуудад олгодог тэтгэлэг хөтөлбөрүүд, хөнгөлөлт, зээл” Хамтын ажиллагааны гэрээтэй гадаад болон дотоодын байгууллагуудаас олгодог тэтгэлэг хөтөлбөрүүдийн танилцуулга, тавигдах шаардлага	Оюутны соёл, үйлчилгээний албаны мэргэжилтэн Х.Оюунхишиг, Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны М.Болортуяа нар өгөв.	2017 оны 10 сар	62 оюутан оролцож 100 ш гаруй танилцуулга тараав.
18	“Боловсролын зээлийн сан”-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, дэлхийн шилдэг их дээд сургуулиуд суралцах хэрхэн тэтгэлэгтэй суралцах боломж, төрөөс олгож буй тэтгэлэг хөнгөлөлт болон “Оюутны хөгжлийн зээл”	Боловсролын зээлийн сангийн Зээлийн албаны дарга Э.Батсэлэм	2017 оны 10 сар	62 оюутан оролцож 500 ш гаруй танилцуулга тараав.
Нийт				10357

5.2. ОЮУТЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, БҮТЭЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН

Монгол Улсын Гавьяат багш, Академич С.Батмөнхийн нэрэмжит ШУТИС-ийн оюутны “Эрдмийн XVIII чуулган” илтгэлийн уралдааныг 3 үе шаттай зохион байгуулж I шатнаас шалгарсан 45 илтгэлээс шилдэг 35 илтгэлийг хэлэлцэн шилдгийг тодруулсан.



Зураг 5.1. ШУТИС-ийн оюутны “Эрдмийн XVIII чуулган”

Оюутны бүтээлийн уралдаанд нийт 43 бүтээлээр 71 оюутан 40 багш удирдагчаар тус тус оролцлоо.

Эрдэм шинжилгээний хуралд шалгарсан илтгэл

Хүснэгт 5.2

д/д	Салбар	Шагнал т байр	Сургууль	Илтгэлийн нэр	Удирдсан багш	Оюутны нэр
1	Техник технологийн салбар	I-р байр	МХТС	“Аг технологийн аппликейшн хөгжүүлэлт”	Мэдээллийн технологийн салбарын сургалтын мастер Г.Мөнхбат	МХТС –ийн МТ-IV курсийн оюутан Б.Нямхүү
		II-р байр	БАС	“Хаягдал ашиглан өнгөлгөөний тоосго үйлдвэрлэх судалгаа”	БАС-ийн ХБОИС-ын дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор Д.Сүнжидмаа	БАС-ийн БМҮТ-III, БМҮТ-IV курсийн оюутнууд Э.Мөнхбаяр, Э.Буянхишиг, Ж.Мөнхжаргал, Ц.Гүржав нар

		III-р байр	ГУУС	“Хаягдал хадгалах байгууламжийн эргэлтийн усан сангийн тусгаарлах далангийн хажуугийн тогтворжилтын судалгаа”	ГУУС-ийн ахлах багш, Доктор (Ph.D), Б.Ганзориг	ГУУС-ийн, УУАТ-IV Курсийн оюутан Н.Эрдэнэбулган
2	Байгаль ухаан, экологийн салбар	I-р байр	ГУУС	“Алтай таван богд үндэсний паркийн мөстлөгийн үе шат ба гадаргын үнэмлэхүй насны судалгаа”	ГУУС-ийн дэд профессор, Доктор (Ph.D) С.Оюунгэрэл профессор	ГУУС-ийн – Геологи- IV курсийн оюутан Ц.Нинжин, П.Пүрэв-Очир
		II-р байр	ХШУС	Автоклавын уусгалтын уусмалаас катодын ээс гарган авах судалгаа”	ШУТИС-ийн Хүндэт профессор Ж. Бүдсүрэн	ХШУС-ийн ХИ-IV курсийн оюутан Б.Мичидмаа
		III-р байр	ЭХС	“Хаягдал энерги ашиглан элма сувилалын газрын хэрэгцээний халуун усны дулааны ачааллыг хаах боломжийн судалгаа”	ЭХС-ийн ДИС-ын Эрхлэгч, Доктор (Ph.D) П.Бямбацогт	ЭХС-ийн ДХ- IV курсийн оюутан Л.Батзориг
3	Нийгмийн ухаан, хүмүүнлэг, дизайны салбар	I-р байр	БАС	“Оюутан сурагчдын бүтээлийн үзэсгэлэнгийн орчин”	БАС-ийн Архитектурын салбарын багш, магистр Д.Өлзийсүрэн	БАС-ийн Архитектур- II курсийн оюутан Б.Болортуяа
		II-р байр	ГХИ	“Хятад хэлний орон байр заасан угтвар үгийн орчуулга, хэрэглээ”	ГХИ-ийн ахлах багш, доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа	ЭХС-ийн ЭТТА, СЭХ хөтөлбөр-II курсийн оюутан Т.Энхтуул, Г.Мөнхнасан нарын
		III-р байр	ҮТС	“Монгол улсын шинжлэх ухаан технологийн их сургуулийн урлаг заалны акустикийн судалгаа”	ҮТС-ийн Дизайны салбарын багш /Магистр/ Б.Энхжаргал	ҮТС-ийн КГД-IV курсийн оюутнууд М.Мөнхзаяа, М.Хулан М.Тодбилэг, А.Уламбаяр нар

Оюутны бүтээлийн уралдаанд шалгарсан бүтээл

Хүснэгт 5.3

д/д	Салбар	Шагналт байр	Сургууль	Бүтээлийн нэр	Удирдсан багш	Оюутны нэр
1	Техник технологийн салбар	I-р байр	МХТС	“Цэгц аппликейшн” бүтээлээр	МХТС-ийн Мэдээллийн технологийн салбарын сургалтын мастер Г.Мөнхбат багшийн удирдсан	МХТС Мэдээллийн технологи 4 курсийн оюутан Ж.Бямба-Очир, Б.Нямбүүгийн баг

		II-р байр	ЭХС	“Алсын болон гар удирдлагатай цахилгаан тэргэнцэр”	ЭХС-ийн Цахилгаан техникийн тэнхимийн ахлах багш, Доктор /Ph.D/ Б.Нямбаяр	ЦСА-4,2 курсын оюутнууд Г.Өсөхбаяр, Б.Мөрөн, Э.Шижир, Х.Дэлгэртамир нарын баг
		III-р байр	ҮТС	“Чацарганы хатаамал”, “баяжуулсан бүхэл үрийн талх”, “баяжуулсан аарцны ундаа” бүтээлээр	ҮТС-ийн Хүнсний инженерчлэлийн салбарын Доктор /Ph.D/ дэд.профессор Ц.Одбаяр, Доктор /Ph.D/Сэржмядаг	“Эрүүл зохистой хооллолт” клубийн баг
		Академчийн нэрэмжит шагналаар	МехТС	“Энергийн хэмнэлт бүхий сур элдэх хүндийн хүчний төхөөрөмж” бүтээлээр	Механик, мехатроникийн салбарын дэд профессор, доктор (Ph.D) Я.Ренчинванжил	Мехатроникийн III курсийн оюутан Б.Амарбат ахлагчтай баг
2	Байгалийн ухаан, Нийгмийн салбарт	I-р байр	БАС	"Comfortable housing engineers" бүтээлээр	БАС-ийн Архитектурын салбарын багш Э.Болорцэцэг	Архитектур-2, ХАС, БИБ-2 курсийн оюутнууд болох Б.Энх-Амгалан, Г.Ганчимэг, О.Чулуунбаатар нарын баг
		II-р байр	МХТС	“Фитнесс ба эрүүл мэндийн аппликейшн”	МХТС-ийн Мэдээллийн технологийн салбарын ахлах багш Б.Мөнхбуян	МХТС Мэдээллийн системийн 4 курсийн оюутан Г.Халиун
		III-р байр	ҮТС	“CAZOKOШЛЕК ЦИ” бүтээлээр	ҮТС-ийн Дизайны салбарын ахлах багш П. Болормаа	ҮТС, Хувцасны Дизайн- Iүвкурсийн оюутан Т.Баярмаа

Оюутнуудаа удирдан дэмжин ажилласан шилдэг багш нарыг тодруулан дараах багш нарт батламж, мөнгөн шагнал олгов. Үүнд

- МХТС-ийн Мэдээллийн технологийн салбарын сургалтын мастер Г.Мөнхбат
- БАС-ийн Хүрээлэн буй инженерийн салбарын дэд профессор Доктор /Ph.D/ Д.Сүнжидмаа
- БАС-ийн Архитектурын салбарын багш Э.Болорцэцэг
- ҮТС-ийн Хүнсний инженерчлэлийн салбарын ахлах багш Доктор /Ph.D/Сэржмядаг
- ГХИ-ийн Ази судлалын тэнхимийн ахлах багш Доктор /Ph.D/ Ц.Эрдэнэзаяа
- ГУУС-ийн Уул уурхайн салбарын багш Доктор /Ph.D/ Б.Ганзориг
- ХШУС-ийн химийн инженерчлэлийн салбарын ахлах багш Доктор /Ph.D/ Ж.Бүдсүрэн нарыг тус тус батламж, мөнгөн шагналаар шагналаа.

Дээрх тэргүүн, дэд, гутгаар байр эзэлсэн оюутнууд бүтээлээрээ инновацийн 7 хоногийн арга хэмжээнд бүтээлээрээ оролцох урилга хүлээн авсан ба бүтээлээ 2018 оны 05 сарын 11, 12 ны өдрүүдэд орлцсон.

БуХС-ийн менежментийн багш нар бүтээлүүдтэй танилцан ажиллаж "COMFORTABLE HOUSING ENGINEERS" бүтээлээр БАС-ийн Архитектурын салбарын багш Э.Болорцэцэг багшийн удирдсан Архитектур-2, ХАС, БИБ-2 курсийн оюутнууд болох Б.Энх-Амгалан, Г.Ганчимэг, О.Чулуунбаатар нарын багийг ЗХУ-ын Эрхүү хотод зохион байгуулагдах Start-up weekend уралдаанд оролцуулахаар шалгаруулж хамтран ажиллахаар боллоо.



Зураг 5.2. Оюутнуудаа удирдан дэмжин ажилласан шилдэг багш нар

5.3. ОЮУТНЫ САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Оюутны санаачилгыг дэмжих төсөл”-д ШУТИС-ийн оюутнуудын 10 төслийн багуудын эцсийн шатны хэрэгжилтийн тайланг хүргүүлэн тайлагнав.

Оюутны санаачилгыг дэмжих төслийн нэрс

Хүснэгт 5.4

д/д	Төслийн нэр	Тэтгэлгийн хэмжээ /мянган төгрөг/
1.	Электрон хаягдлыг ашиглан соронзон сепаратор зохион бүтээх төсөл	2901
2.	Хүлэмжийн хяналтын систем	3000
3.	Хийсвэр бодит орчин ашиглан түүхийн мэдлэг олгох электрон хичээл	3000
4.	Модны нүх ухах эксваторын ажлын төхөөрөмж үйлдвэрлэх төсөл	2978,8
5.	Бие даалтын өрөөг тохижуулах төсөл	3000
6.	Уул уурхайн салбарт хэрэглэгддэг IT программын сургалт	3000
7.	Бүтээлч сэтгэлгээг урамшуулах	3000
8.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дээд боловсрол эзэмших боломжийг дээшлүүлэх төсөл	3000
9.	Оюутны байрны жишиг гал тогоо	3000
10.	ШУТИС-ийн жишиг фитнес байр	3000
Нийт дүн		29879,8



Модны нүх ухах төхөөрөмж

Зураг 5.3. “Оюутны санаачилгыг дэлжих төсөл”-ийн хүрээнд хийгдсэн ажлууд



Хүлэмжийн хяналтын систем

5.4. ОЮУТНЫ КЛУБ

2017-2018 оны хичээлийн жилд мэргэжлийн болон сайн дурын клубүүдийг дэмжин ажилласнаар сайн дурын 11 клуб, мэргэжлийн 12 клуб үйл ажиллагаагаа тогтмол явууллаа. Урлагийн клубүүдэд хуваарийн дагуу СУИС-ийн дуу, бүжиг, хөтлөгчийн мэргэжлийн багш нараар хичээлийг нийт 5 сар заалгав.

Анги танхимд хичээллэх шаардлагатай клубийн үйл ажиллагааг Блок- 05 тоот танхимд хуваарийг гарган үйл ажиллагааг явуулах боломжоор хангасан. Клубүүд өөрсдийн санаачлагаар танхимынхаа засвар тохижилтыг өвлийн амралтаараа хийж гүйцэтгэв.

“Клубийн нээлттэй өдөрлөг”-ийг намар, хаврын улиралд зохион байгуулж, энэхүү өдөрлөгөөр клубийн гишүүнчлэлийг нэмэх, клубийн үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулдаг ба энэ жил тусдаа байртай МХТС, МехТС, БуХС-дад очиж сурталчилгаа хийж ажилласан нь үр дүнтэй байлаа.

Клубүүдийн үйл ажиллагааг улирал бүрийн төгсгөлд профессор багш нараар дүгнүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж сайн ажилласан клубийн оюутнуудыг кредитийн урамшуулалд хамрууллаа.

Клубүүдийн тайлан хэлэлцэх хуралд ажилласан профессор багш нараас дараах санал дэмжлэгүүд гарсан байна. Үүнд Соёмбо клубийн үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг БуХС-ийн ХУС-ийн дэд профессор, доктор Д.Сэрдарам гарган өгч дэмжихээр болсон. Мөн Соёмбо клуб, Багшийн туслах оюутан клубийг тусдаа байртай салбар сургуулиуд дээр байгуулах хэрэгтэй гэх саналыг тавьж байлаа.

Клубүүдийн шинэ жилийн цэнгүүний нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан ба тус арга хэмжээн дээр клубүүдийн үйл ажиллагааны үр дүнг үндэслэн 2017 оны шилдгийн шилдэг клуб, шилдэг клуб, шилдэг клубийн ахлагч нарыг сонгон шалгарууллаа. Сонгон шалгаруулалтанд клубүүдийн үйл ажиллагааны тогтвортой хөгжиж буй байдал, оюутнуудын оролцоо, үр дүн зэргийг харгалзан дүгнэлээ.



Зураг 5.4. Клубүүдийн шинэ жилийн цэнгүүний нэгдсэн арга

- Шилдгийн шилдэг клубээр сайн дурын “АЙСЭК-ШУТИС” клуб
- Шилдэг клубээр мэргэжлийн “WIZZ” клуб

Шилдэг клубийн ахлагчаар ардын бүжгийн “АНАРВААН” клубийн ахлагч Б.Цагаан нар шалгарлаа.

Мөн клубийн үйл ажиллагааг зөв чиглүүлэн удирдаж сайн ажилласан төгсөх курсийн ахлагч нараас МОХ-ны дээд шагнал “МАНЛАЙЛАГЧ ОЮУТАН” шагналаар “ХӨТЛӨГЧ”-ийн клубийн ахлагч Б.Мөнх-Эрдэнэ, “ЭРҮҮЛ ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТ” клубийн ахлагч Ш.Эрхэмбаяр, “EMPOWERMENT” клубийн ахлагч О.Болор-Эрдэнэ, “Оюутан цагдаа”-д ажилласан оюутнуудын ахлагчаар ажилласан ГҮУС-ийн Геодезийн IV курсийн оюутан Э.Бат-Эрдэнэ нарыг шагналаа.




Соёмбо клубийг байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн “Оюутан цагдаа”-гаар ажилласан 10 оюутанд Сүхбаатар дүүргийн цагдаагийн газраас өргөмжлөл, оюутнуудаа дэмжин сайн ажиллуулсан ШУТИС-ийн захиргаанд талархал олгов.

Үйл ажиллагаагаа тогтмол амжилттай сайн зохион байгуулж буй клубүүдэд ШУТИС-н клуб мөн болохыг баталгаажуулан БАТЛАМЖ гардууллаа. Үүнд

- Мэргэжлийн: IDEA, Эрдмийн индэр, Oil&Gas, СЭХ, Зохион бүтээлч залуус, Must cad, Inspiration клубт
- Сайн дурын: Хитонен, Морин хуур, Дуулаачийн клуб, AIESEC, Martins клуб



Зураг 5.5. 2017-2018 оны хичээлийн жилд үйл ажиллагаагаа явуулсан клуб болон гишүүдийн судалгаа



Зураг 5.6. Мэргэжлийн клубууд

Оюутны клубүүдийн үйл ажиллагаа:

Доктор, математикч, яруу найрагч Пүрэвийн Лхагвасүрэнгийн “Сэтгэлийн томъёолол” номын нээлт 2018 оны гуравдугаар сарын 6-ны өдөр ШУТИС-ийн Урлаг танхимд зохион байгуулагдан Хөтлөгчийн клубийн гишүүн Б.Батдэлгэр арга хэмжээг хөтлөж, Зохиогчийн зохиосон олон хэл дээр дуулагдсан нийтийн хүртээл болсон “Алсад суугаа ээж” дууг дуулаачийн клубийн ахлагч Ж.Ядамсүрэн, Б.Батдэлгэр нар хамтран дуулсан.



Зураг 5.7. Доктор, татематикч, яруу найрагч Пүрэвийн Лхагвасүрэнгийн “Сэтгэлийн томъёолол” номын нээлт

ШУТИС-ийн урлагийн клубүүдийн **“Оюутны хавар”** тайлан тоглолт 2018 оны 5-р сарын 17-нд зохион байгуулав. Тоглолтонд дуулаач, хөтлөгч, чөлөөт бүжиг, морин хуурын клубүүд, ардын бүжгийн “Анарваан”, цэнгээнт бүжгийн “Хос-Уянга”, “Акапэлла” хамтлагийн 50 гаруй авьяаслаг оюутан оролцсон. Энэхүү тоглолт нь жил бүр уламжлал болон зохион байгуулагдах бөгөөд цаашид байнгын үйл ажиллагаатай ШУТИС-ийн дэргэдэх чуулгыг байгуулах, 60 жилийн ойн хүндэтгэлийн тоглолтын бэлтгэл ажил юм.



Зураг 5.8. ШУТИС-ийн урлагийн клубүүдийн **“Оюутны хавар”** тайлан тоглолт

ШУТИС-ийн дэргэдэх Хос-Уянга цэнгээнт бүжгийн хамтлаг 8 хос 16 хүний бүрэлдэхүүнтэй Монголын бүжгийн спортын холбоо, Улаанбаатар хотын бүжгийн спортын холбоо хамтран зохион байгуулсан “Улаанбаатар хотын бүжгийн спортын аварга шалгаруулах цэнгээнт бүжгийн тэмцээн”-д **латин формэйшн** бүжгийн төрөлд амжилттай оролцон шагналт **IV** байр эзэллээ. Дэлхийд 5-т бичигдэх шилдэг хамтлаг Moon dance, Master dance гэх мэргэжлийн хамтлагуудтай өрсөлдсөн.



Зураг 5.9. “Улаанбаатар хотын бүжгийн спортын аварга шалгаруулах цэнгээнт бүжгийн тэтгээн”-д латин формэйшн бүжгийн торолд амжилттай оролцогчид.

Оюутан бүр сургуулийн дотоод дэг журам сахиулах “Баруун гарын дүрэм биелүүлцгээе” уриаг нийтэд сурталчлан мөрдүүлэх, “Хотын соёлыг хэвшүүлж-Хорт зуршлаас татгалзъя” шторкийг цагдаагийн байгууллагатй хамтран хийж оюутнуудад хэрэгжүүлэхийг уриалж үр дүнтэй ажилласан

Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн дарга “Монгол HD” TV-ийн өглөө хөтөблөрт урилгаар оролцож хэрхэн амжилттай суралцах, нийгмийн идэвхтэй байх, клубээр хөгжих талаар ярьж ШУТИС-ийг сурталчилсан.

Клубийн оюутнууд Нийслэлийн инновацийн газар, БСШУЯ, ШУТИС-аас хамтран зохион байгуулсан “Start Up Weekен”-д нэгдсэн арга хэмжээнд зохион байгуулагчаар амжилттай ажилласан.

ШУТИС-ийн төгсөлтийн нэгдсэн арга хэмжээнд хөтлөгчийн, дуулаачийн клубийн оюутнууд амжилттай оролцов.

Клубийн оюутнууд өөрсдийн санаачлагаар “Оюутны хөгжил” танхим блок-05-н засвар тохижилтын ажлыг хийсэн.

Их сургуулийн болон бүрэлдэхүүн сургуулийн арга хэмжээ бүрт урлагийн клубүүд арга хэмжээг хөтлөх болон урлагийн тоглолтоор оролцож ажиллав. Жишээлбэл Их сургуулийн дэргэдэх цэцэрлэгийн нээлт, лабораторийн нээлтүүд, эрдэм шинжилгээний нэгдсэн XVIII чуулган болон бусад арга хэмжээ.

5.5. ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, УРАМШУУЛАЛ, ХӨНГӨЛӨЛТ

Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжид хамрагдсан байдал

2017-2018 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн тэтгэлгийн санхүүжилтэд 802 оюутны 1 тэрбум 286 сая 942 мянган төгрөгийн санхүүжилтийг тооцоог Боловсролын зээлийн сантай хийж, төлбөрийн тэтгэлэгт хамрагдахыг хүссэн 162 оюутны холбогдох материалыг бүрдүүлэлтийг хянаж ажиллаа. Мөн энэ хичээлийн жилийн оюутны материалуудыг цахим архивт шилжүүлсэн.

Буцалтгүй тусламжийн санхүүжилтийн тайлан
/мянган төгрөгөөр/

Хүснэгт 5.5

Д/д	Сургууль	Хөдөлмөрийн чадвараа алдсан өрх		Хөгжлийн бэрхшээлтэй		Бүтэн өнчин		Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх		Нэг өрхийн 3 болон түүнээс дээш		нийт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	БАС	65	106973	11	17308	26	45013	9	11619	8	14788	119	195702
2	БуХС	72	123471	10	17108	35	62010	9	19398	15	26760	141	248748
3	ГХИ	0	0	2	3308	1	1654	0	0	0	0	3	4961
4	ГУУС	17	28460	7	9537	23	38298	27	46462	9	13596	83	136353
5	ДАТС	23	31374	6	8376	30	39852	1	1703	2	3269	62	84573
6	МеХТС	32	46915	6	9824	18	26905	8	12706	3	3429	67	99779
7	МХТС	34	50960	14	21195	22	39782	4	2401	8	11130	82	125467
8	ОРТС	23	33677	3	3112	8	13109	4	4530	3	4309	41	58738
9	ҮТС	38	63272	14	23450	33	50668	10	14864	2	3018	97	155272
10	ХШУС	5	5500	2	3334	2	2695	1	1736	1	1736	11	15001
11	ЭХС	44	75381	11	16470	30	54322	7	11989	4	4187	96	162349
	Дүн	353	565982	86	133021	228	374309	80	127408	55	86222	802	1286942

5.6. ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛ

2017-2018 оны хичээлийн жилийн хаврын улирлаас “Оюутны хөгжлийн зээлийн журам” шинэчлэгдэн батлагдаж Боловсролын зээлийн сангаар дамжуулан “Оюутны хөгжлийн зээл”-ийг олгож мэдээллийг оюутнуудад хүргэв.


Сургалтын албаны программд суралцаж буй оюутны хаягийн мэдээллийг шинэчлэн засварлах ажлыг зохион байгуулав. Е-Нээлттэй институтээр оюутны мэдээллийг сургалтын албаны программаас оюутны хөгжлийн зээлийн мэдээллийн сан руу шууд шилжүүлдэг болгов.

Оюутны хөгжлийн зээлд хамрагдсан оюутны тоо
(2018 оны 09-12 сар)


Хүснэгт 5.6

Д/д	Тавигдах шаардлага	Хамрагдсан тоо	Зээлийн мөнгөн дүн /мян.төг/
1	Хүү бууруулах зээл Богино хугацаатай зээл -ЭЕШ –д 400 дээш оноо авсан шинэ элсэгч бакалаврын суралцагч -ҮГД 2.0 болон түүнээс дээш голчтой бакалаврын суралцагч Урт хугацаатай зээл -ЭЕШ –д 650 дээш оноо авсан шинэ элсэгч бакалаврын суралцагч -ҮГД 3.0 болон түүнээс дээш голчтой -Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжил ҮГД 2.3-иас дээш дүнтэй бакалаврын суралцагч	220	374964.216

Оюутны хөгжлийн зээлд хамрагдсан оюутны тоо (боловсролын зээлийн сангаар)



Зураг 5.10. Оюутны хөгжлийн зээлд хамрагдсан оюутны тоо



Зураг 5.11. Оюутны хөгжлийн зээлд хамрагдсан оюутны нийт мөнгөн дүн

Гадаад суралцагчийн тэтгэлэг, хөнгөлөлт

Засгийн газрын гэрээгээр суралцагч гадаад 7 оюутанд 9-12 сард 5956,5 мянган төгрөгийн сургалтын төлбөр, амьжиргааны зардал 5040 мянган төгрөг, 01-06 сард 9 оюутанд 14517,3 мянган төгрөг сургалтын төлбөр, амьжиргааны зардал 11160

мянган төгрөгийн тооцоог Боловсролын зээлийн сантай хийж нийт 20473,8 мянган төгрөгийн сургалтын төлбөр, 16200 мянган төгрөгийн амьжиргааны зардлын тооцоог хийв.


Гадаад суралцагчийн тэтгэлэг, хөнгөлөлт

Хүснэгт 5.7


Д/д	Сургууль	БНАЛАУ		Казахстан		БНХАУ		ОХУ		Нийт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	Дүн \мян.төг\
1	БАС	1	1886,25							1	1886,25
2	БУХС							1	2981,25	1	2981,25
3	ГУУС	4	7545,0							4	7545,0
4	МХТС			1	1987,5					1	1987,5
5	ҮТС					1	3018,0			1	3018,0
6	ХШУС					1	3055,8			1	3055,8
	Дүн	5	9431,25	1	1987,5	2	6073,8	1	2981,25	9	20473,8

Оюутанд замын зардал нөхөн олгосон байдал

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн нийт 1347 оюутанд 122 сая 236 мянга 500 төгрөгийн замын зардлыг нөхөн олгосноос ДаТС-ийн 44 оюутны 4 сая 47 мянга 900 төгрөг, ОрТС-ийн 9 оюутны 1 сая 71 мянга 100 төгрөгийн нийт хөдөө орон нутгийн сургуулийн 53 оюутны 5 сая 119 мянган төгрөгийн замын зардлыг нөхөн олгосон.



Зураг 5.12. 2017-2018 оны хичээлийн жилд замын зардал нөхөн олгосон байдал.



Зураг 5.13. Замын зардал нөхөн олгосон суралцагчдын тоо /айтгаар/

5.7. ГАДААД, ДОТООДЫН БАЙГУУЛЛАГЫН ТЭТГЭЛЭГ

2017-2018 оны хичээлийн жилд “Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ийн дагуу бүрэлдэхүүн сургуулийн 11 шинэ элсэгч оюутанд “Шилдэг элсэгч” өргөмжлөл, 30 хүртэлх кредитийн хөнгөлөлт, шилдэг суралцагч оюутанд 15 хүртэлх кредитийн хөнгөлөлт, шилдэг төгсөгчдөд “Шилдэг төгсөгч” өргөмжлөл, 100 мянган төгрөг мөн гадаад, дотоодын байгууллагаас нийт 136 оюутан 148 сая 537 мянга 540 төгрөгийг тэтгэлгийг тус тус авсан байна.

2017-2018 онд сан тэтгэлэг, хөтөлбөрүүдэд хамрагдсан оюутны тоо


Хүснэгт 5.8

Д/д	Сан, тэтгэлгүүд	Тэтгэлгийн хэмжээ /мян.төг/	Хамрагдсан оюутны тоо	Нийт мөнгөн дүн /мян.төг/
1	Ректорын нэрэмжит тэтгэлэг /шилдэг элсэгч	30 кредит хөнгөлөлт	11	20430
2	Ректорын нэрэмжит тэтгэлэг /шилдэг суралцагч	15 кредит хүртэлх хөнгөлөлт	13	13203,525
3	Ректорын нэрэмжит тэтгэлэг /шилдэг төгсөгч/	100	26	2600
4	Санко группийн нэрэмжит тэтгэлэг	1000	5	5000
5	Оюу толгой ХХК	Сургалтын төлбөр	17	19319,64
6	Тайвань Монголын нийгэмлэгийн тэтгэлэг	800-1000	4	3800
7	Дэлхийн зөн ОУБ	Сургалтын төлбөр	16	19553,5


8	Зориг сан	Сургалтын төлбөр	4	4068,875
9	Сүмитомо Корпорацийн нэрэмжит	1198	20	23762
10	Мицубиши Корпораци нэрэмжит	1000	10	10000
11	Тоёото ШУТИС сангийн тэтгэлэг	500	20	10000
12	Поско Ти Жи Парк сан	1680	10	16800
Нийт дүн /мян.төг/			136	148537,54

5.8. КРЕДИТИЙН УРАМШУУЛАЛ


2017-2018 оны хичээлийн жилд эрдэм шинжилгээний хурал, олимпиадад амжилт гаргасан, сурлагаараа тэргүүлсэн, спортын өндөр амжилт гаргасан, клуб, олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон, оюутны холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон нийт 1409 оюутанд 2643,5 кредитийн урамшуулал олгосон.




Зураг 5.14. 2017-2018 оны хичээлийн жилийн намрын улиралд кредитийн урамшуулал олгосон нийт оюутны тоо



Зураг 5.15. 2017-2018 оны хичээлийн жилийн намрын улиралд олгосон нийт кредит



Зураг 5.16. 2017-2018 оны хичээлийн жилийн хаврын улиралд кредитийн урамшуулал олгосон оюутны тоо




Зураг 6.17. 2017-2018 оны хичээлийн жилийн намрын улиралд олгосон кредитийн тоо

5.9. ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн даатгал


Энэ хичээлийн жилд 19 наснаас доош насны 1396 оюутныг СБД-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран эрүүл мэндийн даатгалд хамруулав. 2017-2018 оны хичээлийн жилд суралцаж буй 9882 оюутныг мэдээллийг СБД-ийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв. МеХТС, БуХС, МХТС-ийн сургалтын алба харьяа дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдтэй хамтран оюутнуудаа даатгалд хамрууллаа.



Зураг 5.18. Хичээлийн жилд Эрүүл мэндийн даатгалд хамруулсан оюутны тоо

Нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих цахим карт

НЗДТГ, Нийслэлийн боловсролын газраас 2017-2018 оны хичээлийн жилд 15000 хөнгөлөлттэй үнээр зорчих картын квотыг олгосон бөгөөд 2017 оны 9 дүгээр сарын эхний 14 хоногт бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба, Нийслэлийн боловсролын газартай хамтран ажиллаж, 8462 оюутан автобусны картыг захиалан автобусаар хөнгөлөлттэй үнээр зорчих боломжтой болсон.



Зураг 5.19. 2017-2018 оны хичээлийн жилд автобусны карт захиалсан оюутны тоо

Оюутан цэрэг хөтөлбөр

Сүхбаатар дүүргийн цэргийн штабтай хамтран 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ҮГД 2.8-иас дээш I курсийн 240 оюутныг бүртгэсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ээс 5 дугаар сарын 27-ныг дуустал Бямба, Ням гарагт Хичээлийн II байрны ТВЗ-д цэргийн ерөнхий бэлтгэл хичээл явагдав.

БСШУСЯ -ын сайд Ц.Цогзолмаа, БХЯ-ны сайд Н.Энхболд болон бусад албаны хүмүүс ШУТИС-д 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зочлон Оюутан-цэргүүдийн “Цэргийн ерөнхий бэлтгэл” сургалтын үйл явцтай танилцаж, оюутан залуусын санал сэтгэгдлийг сонсож уулзалт болов.


“Оюутан цэргийн тангарагын баяр” 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдөр болж ШУТИС-ийн сургалт, оюутны дэд захирал Х.Энхжаргал бусад албаны хүмүүс оролцов. ШУТИС-ийн 140 оюутан цэрэг хөтөлбөрт хамрагдлаа. Оюутан цэрэг сургалтанд амжилттай суралцсан 10 оюутанд тус бүр 2 кредит нийт 20 кредитийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг олголоо.



Зураг 5.20. Оюутан цэрэг хотөлборт хамрагдсан оюутнууд

Оюутны цахим карт

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн багш, оюутны цахим карт захиалах программд өөрчлөлт оруулж бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтан болон оюутан суралцагчдын 1615 цахим карт хэвлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 5.21. Цахим карт хэвлэсэн тоо

5.10. ОЮУТНЫ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

2017-2018 оны хичээлийн жилд оюутны 4 оюутны байранд нийт 943 оюутныг хүлээн авч, тав тухтай амьдран суралцах боломжоор ханган ажилласан байна. Байрны ашиглалт, оюутан хүлээн авах ажлын бэлтгэл шалгах ажлыг ОСҮА, СБЗГ, ЭМТ-тэй хамтран зохион байгуулж ажлыг сайжруулах талаарх санал хүсэлтийг Хөрөнгө оруулалт, хангамжийн газарт тавьж шийдвэрлүүлсэн.

Оюутны байр

Хүснэгт 5.9

Д/д	Оюутны байр	Сургууль \Оюутны тоо\										Гадны оюутан	Нийт
		БАС	БуХС	ГУУС	МехТС	МХТС	YTS	XSHUS	ЭХС	ГХИ	Коосен		
1	I байр	44		67	12	7	81	6	24	4	6	45	296
2	III байр	42	134	19	3	11	7	20	92	1		28	357
3	IV байр		2			99	1					25	127
4	V байр	1	1	5	86	1	2		1			66	163
Нийт		87	137	91	101	118	91	26	117	5	6	164	943

Оюутны байрны сэтгэл ханамжийн судалгаа

Байр ашиглалтын нэгдсэн алба, Оюутны соёл, үйлчилгээний алба, Эрүүл мэндийн төвтэй хамтран Оюутны байруудад 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрөөс 08-ны өдрийн хооронд шалгалт хийж, оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг авсан болоно. Судалгаанд оюутны I байр 100 оюутан, оюутны III байр 96 оюутан, оюутны IV байр 100 оюутан, оюутны V байр 95 оюутан нийт 391 оюутан хамрагдсан. Судалгаанаас гарсан үр дүнд тулгуурлан байр хариуцсан бүрэлдэхүүн сургуулиудийн захирлуудад оюутны амьдрах таатай орчинг бүрдүүлэх тал дээр засаж сайжруулах ажлыг хийж шийдвэрлүүлэв.

5.11. НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ


“Хичээлийн шинэ жилийн нээлт” төгсөлтийн арга хэмжээ

2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн ёслолын ажиллагаанд БСПУСЯ-ын сайд Ц.Цогзолмаа, Дээд боловсролын газрын дарга Т.Амаржаргалан, ШУТИС-ийн удирдлага, гадны зочид төлөөлөгчид оролцлоо. Захирлын нэрэмжит тэтгэлэг, Санко группийн тэтгэлэгт хамрагдах хүсэлтэй оюутны материалыг хүлээн авч нээлтийн үеэр оюутнуудад тэтгэлгийг гардууллаа.




Зураг 5.22. ШУТИС-ийн хичээлийн шинэ нээлтийн ёслолын ажиллагаа

2017-2018 оны хичээлийн жилийн намрын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагааг хурлын танхим, хаврын улирлын төгсөлтийн үйл ажиллагааг Буянт-Ухаа спорт цогцолборт зохион байгуулав. Төгсөлтийн ёслолын хувцасны тоог 500 ширхэгээр нэмэгдүүлэв. Намар, хаврын төгсөлтийн баярын үеэр суралцах хугацаандаа сурлага, спорт, урлагийн амжилтаараа манлайлсан шилдэг 26 төгсөгчдөд өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.



Зураг 5.23. Хаврын улиралд төгсөгчидийн ёслолын ажиллагаанд оролцсон оюутны тоо



Зураг 5.24. Намрын улиралд төгсөгчидийн ёслолын ажиллагаанд оролцсон оюутны тоо




Зураг 5.25. ШУТИС-ийн 79,80 дахь удаагийн төгсөлтийн ёслолын ажиллагаа

“Тэтгэлэг олгогчдын өдөрлөг”

Тэтгэлэг олгогчдын өдөрлөгийг 2017 оны 10 дугаар сарын 18-нд зохион байгуулсан бөгөөд ШУТИС-иас оюутнуудад олгодог тэтгэлэг хөтөлбөрүүд, хамтын ажиллагааны гэрээтэй гадаад болон дотоодын байгууллагуудаас олгодог тэтгэлэг хөтөлбөрийн мэдээлэл танилцуулгыг хийж, Боловсролын зээлийн сангийн Зээлийн албаны дарга Э.Батсэлэм “Боловсролын зээлийн сан”-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, дэлхийн шилдэг их дээд сургуулиуд суралцах хэрхэн тэтгэлэгтэй суралцах боломж, төрөөс олгож буй тэтгэлэг хөнгөлөлт болон “Оюутны хөгжлийн зээл”-ийн талаар оюутнуудад дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Оюутнуудад “Оюутны хөгжлийн зээл” болон ШУТИС-иас олгодог тэтгэлэгт хөтөлбөрүүдийн танилцуулгыг бэлтгэж 200 ширхэгийг сонирхсон оюутнуудад тараав.



Зураг 5.26. ШУТИС-иас олгодог тэтгэлэгт хөтөлбөрүүдийн танилцуулга




Зураг 5.27. Тэтгэлэг олгогчдын өдөрлөгт оролцсон оюутны тоо

“Ажлын байрны үзэсгэлэн яармаг өдөрлөг”

Ажлын байрны үзэсгэлэн яармаг 2018 оны 5 сарын 04-ний өдөр зохион байгуулав. Тус өдөрлөгөөр төгсөгчдөө ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах

эээлийн мэдээлэл зөвлөгөө хүргэх, ажил олгогчийн зүгээс хүний нөөцийн бодлого, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, төгсөгч оюутнуудыг ажилтай болгох, мэргэжлээрээ ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилготой зохион байгууллаа. Уг өдөрлөгт Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын сургалт, судалгаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Г.Долгорсүрэн төгсөгч оюутнуудад хандан “Цагийн ажил хайх иргэд, оюутан суралцагчдыг цагийн ажилд зуучлах болон гарааны бизнесийг дэмжих” хөтөлбөрийн талаар мэдээлэл өглөө.



Мөн Оюуны чадвар ТББ-ын үүсгэн байгуулагч, лектор Г.Мөрөн “Ирээдүйн карьер ба амжилт” сэдвээр лекц уншлаа. Нийгмийн даатгалын ерөнхий

газрын Үйл ажиллагааны хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Нарантуяа “Нийгмийн даатгалын төрөл, сайн дурын даатгал түүний ач холбогдол” сэдвээр сургалт явуулж 120 оюутан хамрагдсан байна. Уг өдөрлөгт Оюутны соёл, үйлчилгээний албатай хамтран ажилладаг 37 байгууллага оролцов.

600 гаруй төгсөгч оюутан онлайнаар анкет бөглөсөн ба ажил олгогч байгууллагуудад танилцуулан, ажлын байрны захиалгын дагуу мэргэжлийн чиглэлээр төгсөгч оюутнуудын мэдээллийг өгсөн болно. Тус өдөрлөгт 37 байгууллага 1400 нээлттэй ажлын байрны саналтай ирж, нийт 267 гаруй оюутныг цагийн болон байнгын ажилд зуучилсан болно.



“Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүний онцлог, суралцахад тулгарч буй бэрхшээл”-ийг танилцуулах өдөрлөг

ШУТИС-ийн багш, оюутнуудад хараагүй болон харааны бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголт өгөх, тэдний онцлог хэрэгцээний талаар болон тэдэнд хүртээмжтэй орчинг хэрхэн бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүн туслах үйлчилгээний тухай танилцуулах зорилготой өдөрлөгийг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо болон Оюутны соёл, үйлчилгээний алба хамтран 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ШУТИС-ийн Хурлын танхимд зохион байгуулав. Энэхүү өдөрлөгийн үеэр Италийн их сургуулийн харааны бэрхшээлтэй оюутнуудад үзүүлэх боловсролын үйлчилгээний талаар видео танилцуулгыг хүргэлээ. Мөн харааны бэрхшээлтэй оюутнуудын онцлог, суралцах явцад тулгарч буй бэрхшээлийг оюутнуудад дэлгэрэнгүй бодит жишээгээр тайлбарлаж өглөө. Харааны бэрхшээлтэй оюутнуудад суралцахад тулгардаг бэрхшээлийг 5 хүнд бодит байдал дээр хичээл заах байдлаар үзүүлэв. Уг өдөрлөгт



оролцсон 50 гаруй багш, ажилчид, 50 оюутан нийт 100 гаруй хүмүүс харааны бэрхшээлтэй хүний онцлог, тэдэнд тулгарч буй бэрхшээлийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй боллоо.

“Мэргэжил бүхэн сайхан өдөрлөг”

ЕБС-ийн сурагчидад мэргэжил сурталчлах үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлогын томоохон үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн. Тус ажлын хүрээнд ШУТИС-ийн залуу 16 багшийг нийслэлийн 5 дүүргийн 16 сургуульд хуваарилан ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулж нийт 1600 орчим сурагчидад сургуулиа сурталчлав. Хөдөө орон нутгийн захиргааны байгууллага, ТББ-тай хамтран ажиллаж 12 сарын 14 нд сэлэнгэ аймгийн 28 сурагч, Зүүнхараа, баруун хараагийн 50 сурагчдад мэдээлэл хийж сургууль, мэргэжлээ сурталчилан ажиллав.

Үүний үр дүнд 6 багш хөдөө орон нутагт ажиллаж мэргэжил сурталчилах багт орж амжилттай ажиллав.

“Монгол инженер-2018” нэгдсэн арга хэмжээний нээлт боллоо

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчидад мэргэжлээ сонгоход нь туслах зорилгоор “Монгол инженер-2018” нэгдсэн арга хэмжээг 2018 оны 04 сарын 20 ны өдөр сургуулийн гадна талбайд мэргэжил тус бүрээр үзэсгэлэн гаргаж сургуулийн танилцуулга бэлтгэн тараах зэргээр ажилласан. Тус арга хэмжээнд мэргэжлийн болон сайн дурын клубүүд, сургуулийн оюутны зөвлөлүүд идэвхтэй сайн ажиллаж 500 гаруй сурагчид түүний эцэг эх хамрагдсан.

Тус арга хэмжээний талаарх шторкийг олон нийтийн телевиз, радиогоор дамжуулан олон нийтэд их сургуулийн үйл ажиллагааг сурталчилах үйл ажиллагааг зохион байгууллаа.



“Шинэ элсэгчдийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн”



2017-2018 оны хичээлийн жил элсэн орсон оюутнуудын дунд “Элсэгчдийн аварга шалгаруулах сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг ШУТИС-ийн 2017 оны 10 дугаар сарын 18-25 –ны өдрүүдэд ШУТИС-ийн оюутны холбоотой хамтран зохион байгуулж, бүрэлдэхүүн сургуулийн эмэгтэй 6, эрэгтэй 9 багийн 160 гаруй тамирчид оролцож аваргаа тодруулсан.

“Оюутны спортын III наадам”

ШУТИС-ийн Оюутны спортын III наадмыг ХШУС-ийн Биеийн тамирын тэнхимтэй хамтран Сагсан бөмбөг, Волейбол, Үндэсний бөх, Шатар, Ширээний теннис, ЭШ-ний илтгэлийн төрлүүдээр 450 гаруй оюутнууд өрсөлдөж ШУТИС-ийн Оюутны спортын III наадам 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 13-ны

өдрүүдэд зохион байгуулсан. Тэмцээний хаалтын үйл ажиллагааг Спортын төв ордонд зохион байгуулж, ШУТИС-ийн логотой медалийг шагналт байранд шалгарсан баг тамирчдад гардуулан багийн дүнгээр эхний 3 байрт шалгарсан сургуулиудад мөнгөн шагнал, шилжин явах цом гардуулсан.



“Урлагийн XVII Их Наадам”



жүжигчин, соёлын тэргүүний ажилтан Ш.Мөнхбаяр нар ажилласан юм. Энэ жилийн гранпри шагналыг Барилга архитектурын сургууль хүртсэн.

Оюутны соёл, үйлчилгээний алба, оюутны холбоо хамтран жил бүр уламжлагдаж зохион байгуулагддаг Урлагийн XVII их наадам нь 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулагдаж шилдгүүдээ тодрууллаа. Тус наадмын шүүгчээр Guys хамтлагийн дуучин, хөгжмийн зохиолч, продюссер А.Төгсбаяр, Бүжгийн спортын олон улсын хэмжээний мастер, Moon dance хамтлагийн бүжигчин Б.Эрдэнэ,

“MUST CUP-2018”



Оюутны соёл, үйлчилгээний алба, оюутны холбоо хамтран жил бүр байгуулж MUST CUP-2018 хөл бөмбөгийн тэмцээн нь 5 сарын 12-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Үүнд бүрэлдэхүүн сургуулиудын шилдэг тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорьж аваргууд тодорсон юм. Энэхүү тэмцээний гол зорилго нь оюутан залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, спортоор хичээллүүлэх мөн Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн шигшээ багийг бүрдүүлэхэд оршсон юм. Энэхүү тэмцээний ахлах шүүгчээр хөлбөмбөгийн холбооны шүүгч А.Алтантуяа, туслах шүүгчээр Б.Бямба, туслах шүүгчээр Г. Мөнхбаяр нар ажиллалаа. Тэмцээнд нийт 7 баг оролцсон бөгөөд Геологи Уул Уурхайн Сургууль тэргүүн байр эзэлсэн юм.

5.12. ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АЖИЛ

“Их цэвэрлэгээ”

Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний хэлтэс, Оюутны хөгжил, үйлчилгээний алба, бүрэлдэхүүн сургууль, институт хамтран 2018 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр ШУТИС-ийн өөрийн байрны эдэлбэр газар, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, явган хүний зам, хашаа хайсны хогийг цэвэрлэлээ.

Мөн Сүхбаатар дүүргээс хариуцуулсан Е-Мартын уулзвараас Арслантай гүүр хүртэлх Сэлбэ голын ай сав газрыг цэвэрлэлээ. Энэхүү бүх нийтийн их цэвэрлэгээнд 400 гаруй оюутан, багш, ажилчид оролцлоо.



“Оюутан эргүүл”


Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэс, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс хамтран хэрэгжүүлдэг “Оюутан-эргүүл” үйл ажиллагааны нээлтийн арга хэмжээ 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Оюутны талбайд зохион байгуулсан. Уг нээлтийн арга хэмжээнд ШУТИС-ийн оюутны клубын гишүүд, Оюутны зөвлөл болон Оюутны холбооны 100 гаруй оюутнууд оролцлоо.



Иргэдийнхээ аюулгүй, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, урин дулааны улиралд нийслэлд зочлох гадаадын аялагч, жуулчдын аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхээр зорилгоор их дээд сургуулиуд хамтран ажиллахаар болж ШУТИС-ийн хэв журам, ёс суртахууны Соёмбо клубийн 10 гаруй гишүүн 1 сарын туршид хуваарийн дагуу оюутан эргүүлээр ажиллав.

“ЭЭРЭГ ХАНДЛАГА – ЭРҮҮЛ ОЮУТАН” аян

Гэр бүл хүүхэд, хөгжлийн газар “ЭЭРЭГ ХАНДЛАГА – ЭРҮҮЛ ОЮУТАН” аянг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн I, II, IV, V оюутны байрны оюутнуудын дунд 2017 оны 10-р сарын 18-аас 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг аяны хүрээнд оюутнуудад эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлахад чиглэсэн уг аянд оюутны байранд амьдарч буй 185 гаруй оролцов.



Зураг 5.28. "Эрэг хандлага-Эрүүл оюутан" аянд оролцсон байрны оюутны тоо

5.13. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

“Төгсөгчдийн мөшгих судалгаа” явуулж 2016-2017 оны хичээлийн жилд төгссөн 2355 оюутан судалгаанд хамруулж хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргав. Мөн Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран оюутан суралцагчдыг цагийн болон байнгын ажлын байранд зуучласан болно. Нийслэлийн хөдөлмөрийн газрын мэдээллийн баазад төгсөх оюутнуудыг мэдээллийг оруулав.

ШУТИС-ийн 2016-2017 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин /бүрэлдэхүүн сургууль бүрээр/

Хүснэгт 5.10

д/д	Мэргэжил	Нийт төгсөгч	Хөгжлийн бэрхшээлтэй төгсөгч тоо	Ажил эрхлэж буй төгсөгчдийн тоо	Мэргэжлийн чиглэлээр ажиллаж буй төгсөгч	Ажил эрхлэлтийн хувь %	Мэргэжлийн чиглэлээр ажил эрхлэлтийн хувь %	Төгсөгчийн ажлын байрны хэвшил		
								Төрийн байгууллага	Хувийн хэвшил	Өөртөө бий болгосон ажлын байр /мэргэжлээр/
	1	2		3	4	5	6	7	8	9
1	БАС	338	1	248	199	76.5	63.5	6	201	7
2	БУХС	44	1	27	3	57.5	6.5	1	20	0
3	ГУУС	387	1	244	107	63	29	18	188	38
4	МЕХТС	291	0	233	175	79.5	58	36	179	18
5	МХТС	353	1	275	213	77	58	51	192	32
6	ҮТС	301	3	207	129	68.5	41	8	189	10
7	ХШУС	110	0	79	48	70.5	39.5	10	65	4

8	ЭХС	293	11	242	195	82	65.5	81	156	5
9	ГХИ	93	0	49	12	53	17.5	2	40	2
10	ДАТС	145	0	107	71	73.5	49	21	84	3
	ДҮН	2355	18	1711	1152	72.6	48.9	234	1314	119

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтын ажиллагааны гэрээний байгуулж гэрээний дагуу байнгын болон цагийн ажил эрхлэх сонирхолтой оюутныг бүртгэж www.lmis.gov.mn хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн мэдээллийн санд оруулав.


Цагийн болон байнгын ажлын байранд зуучласан оюутны тоо

Хүснэгт 5.11

Д/д	Нэг. Оюутан суралцагчдын мэдээдлэл	Нийт тоо	Үүнээс эмэгтэй
	ОХЭДТ-ийн үйл ажиллагааны мэдээлэл		
1	Бүртгүүлсэн оюутан суралцагчид	1465	835
2	Цагийн ажилд зуучлагдсан оюутан	391	233
	Үүнээс: Их дээд сургуулийн оюутан	391	233
	МСҮТ-ийн оюутан	0	0
3	Нийтийг хамарсан ажил болон түр ажлын байраар хангагдсан оюутан	8	5
4	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдсан оюутан	120	80
5	Аж ахуй нэгж байгууллагаас авсан ажлын байрны захиалга	1535	890

5.14. БУСАД

- ✓ “ШУТИС-ийн оюутнуудад кредит урамшуулал олгох журам” шинэчлэгдсэн батлагдсан.
- ✓ Хурлын танхимд хурал зөвлөгөөн, лекц семинар, уралгийн тоглолт, сургалт гэх мэт 346 удаагийн 1447 цагийн арга хэмжээ зохион байгуулагдсан.



Зураг 5.29. Арга хэмжээн харьцуулсан график

5.15. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛД

Амбулаторийн үзлэгийн мэдээ

Хүснэгт 5.12

Д/д	Сар	Үзлэгийн төрөл							Нийт
		Дотор	Шүд	Тариа	Нөхөн сэргээх	БуХС	МехТС	МХТС	
1	09 сар	472	3779	0	167	0	0	119	4537
2	10 сар	422	464	228	201	406	84	131	1936
3	11 сар	472	120	250	282	157	63	150	1494
4	12 сар	443	204	250	238	167	130	119	1551
5	1 сар	100	107	142	129	117	7	35	637
6	2 сар	120	354	145	131	123	40	83	996
7	3 сар	100	128	170	194	174	63	85	914
8	4 сар	132	449	227	324	181	41	167	1521
9	5 сар	113	374	256	269	157	32	96	1297
БҮГД НИЙТ		2374	5979	1668	1935	1482	460	985	14883

Хүчилтөрөгчийн коктейлын үйлчилгээ

Хүснэгт 5.13

Д/д	Сар өдөр	11 сар																	НИЙТ 11 сар
		7	8	9	10	13	14	15	16	17	21	22	23	24	27	28	29	30	
1	Хүний тоо	21	52	11	18	20	21	8	19	13	9	12	16	7	16	14	13	11	281
2	Аяганы тоо	31	60	21	25	32	43	9	33	18	16	22	24	11	19	19	19	16	418
Д/д	Сар өдөр	12 сар																	НИЙТ 12 сар
		1	4	5	6	7	8	11	12	13	14	15	18	19	20	21	22	25	
1	Хүний тоо	42	8	9	8	10	6	8	9	7	11	6	6	4	5	6	6	3	154
2	Аяганы тоо	59	13	18	13	16	13	17	16	11	20	11	10	8	9	12	14	3	263
Д/д	Сар өдөр	01 сар																	НИЙТ 12 сар
		2	3	4	5	8	9	10	11	12	15	16	17	18	19	23	22		
1	Хүний тоо	7	8	7	8	4	2	4	5	4	14	17	7	13	13	5	6		124
2	Аяганы тоо	12	13	11	21	6	4	7	10	8	20	30	13	25	18	13	14		225

2017-2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн багш ажилчид, оюутнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэх чиглэлд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Урьдчилан сэргийлэх болон байнгын үзлэг

- 08 сарын 14-наас 09 сарын 01-ны хооронд ШУТИС-д 2017-2018 оны хичээлийн жилд шинээр элсэгч оюутнуудын эрүүл мэндийн үзлэгт 3440 оюутан хамрагдсан. Эрүүл мэндийн өвчлөлийн судалгааг гаргаж тайланд орууллаа
- Эрүүл мэнд спортын төвийн оюутны дотуур байр хариуцсан эмч нар, харьяа эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 09 сарын 14-18-ны өдрүүдэд нийт 1, 3, 4, 5-р байрны 905 оюутанаас 676 оюутанг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж зөвлөгөө өгч ажилласан.
- MUST CUP 2017 тэмцээнд эмч шүүгчээр ажиллаж 15 тамирчдад анхны тусламж үзүүлж ажилласан.
- ШУТАС-ийн 44 сурагчдыг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж зөвлөгөө өгч ажилласан.
- КООСЕН ТДС-ийн 1,2-р курсын 28 оюутныг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулав.
- МехТС-ийн МСҮТ-ийн 1,2-р ангийн 165 сурагчдад “Шүд амны хөндийн эрүүл мэнд” сэдэвт сургалт, шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө өгсөн.
- ШУТИС-ийн харьяа “Эрдэм” цэцэрлэгийн Ахлах, бага бүлгийн нийт 36 хүүхдүүдийг “Шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө, сургалт явууллаа.



- Сүрьеэтэй тэмцэх өдрийг угтан Сүрьеэгийн нийгэмлэг, Харвордийн сургууль, Сайн дурын ажилтнуудтай хамтран Сүрьеэгийн өдөрлөг зохион байгууллаа. Үзлэгт 50 хүн хамрагдсан болно.



9. СБД-ийн ЭМН-ийн Сүрьеэ, БЗХӨ кабинетын эмч сувилагч нартай хамтран 04 сарын 16-нд Оюутны 1-р дотуур байрны 150 оюутанд Сүрьеэ, БЗХӨ-ний илрүүлэг үзлэг, шинжилгээ, Шүд амны хөндийн эрүүл ахуйн үзлэг, зөвлөгөө өгсөн.



10. МХТС-ийн 33 оюутан, багш ажилчдыг 05 сарын 04-нд шүд амны хөндийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө сургалтанд хамруулж, Үүнээс 6 хүнийг эрүүлжүүлэн ажилласан.
11. БУХС-ийн 66 оюутан, багш ажилчдыг 05 сарын 09-нд шүд амны хөндийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө сургалтанд хамруулж, Үүнээс 2 хүнийг эрүүлжүүлэн ажилласан.
12. Захиргаа хүний нөөцийн газрын 2018 оны 01 сарын 29-ны 51 тоот албан бичгийн хариу буюу ШУТИС-ийн хичээлийн жилийн хамтын гэрээнд тусгагдсаны дагуу багш ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдлыг нэгтгэн танилцуулж, үүний дүнд 4 сургууль багш, ажилчдын үзлэгээ хийлгэж, 5 сургууль 2018 ондоо багтааж үзлэгээ хийлгэхээр боллоо.
13. Механик тээвэр сургуульд Сүрьеэ өвчинтэй тэмцэх Солонгос Монголын хамарсан хөтөлбөрүүдийг өөрийн сургууль дээрээ үе шаттай зохион байгуулан ажиллаж нийт 1426 хүнийг хамруулан халдварт өвчин бүхий 5 хүнийг харьяа дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүдийн нарийн мэргэжилийн эмчийн хяналтанд орууллаа.

Нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн ажил

14. “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд 40-65 насны багш, ажилтдад В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулсан.
15. УТС-ийн 1-р байрны 87 оюутанд 09 сарын 22-нд “Ханиад томуу гэж юу вэ? хэрхэн урьдчилан сэргийлэх эмчлэх энгийн аргууд” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.
16. Оюутны эрүүл мэндийн даатгалд хамруулах өдөрлөг 09 сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгууллаа.
17. 10 сарын 14-нд АШУУИС, НЭМГ, ДЭМБ, ЭМЯ Их дээд сургуулийн эмч нар хамтран “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-



2017”, “Оюутны эрүүл мэнд” ажлын хүрээнд ШУТИС-ийн оюутны 1-р байранд “Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье, Эрүүл зөв хооллолт” сургалтанд 1-р курсын 45 оюутан, онлайн судалгаанд 50 гаран ахлах курсын оюутнууд хамрагдлаа.

18.10 сарын 31-нээс 11 сарын 10-ны хооронд АШУҮИС, МОНОС, ОСҮА, эрүүл мэндийн төв хамтран Витаминжуулалтын аян зохион байгууллаа.

19. Дэлхийн чихрийн шижинтэй тэмцэх өдрийг угтан нийт оюутан, багш ажилчдад ҮТС-ийн ШТСТ, ОСҮА-тай хамтран 4 өртөөт үйл ажиллагааг 11 сарын 08-нд зохион байгуулсан.



20.11 сарын 07-нд Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, ЭМТ, ОСҮА-тай хамтран “Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүний онцлог, суралцахад тулгарч буй бэрхшээлийг танилцуулах өдөрлөг зохион байгуулсан.

21.11 сарын 20, 21-ний өдрүүдэд “Цусаа бэлэглэж амьдрал хайрлая” аянд ШУТИС-ийн 190 оюутан багш ажилчид хамрагдаж цусаа бэлэглэсэн.



22.12 сарын 01-ны өдөр Оюутны холбоо, оюутны соёл үйлчилгээний албатай хамтран Дэлхийн ХДХВ/ДОХ-той тэмцэх өдөрлөгт 6 өрөөт үйл ажиллагаа зохион байгуулсан.

1-р өртөө сурталчилгааны материал тараах, БЗДХ-ыг таниулах, хамгаалах талаар мэдээлэл олгох/ сургалт -24 оюутанд, хамгаалах хэрэгсэл-30 хайрцаг, гарын авлага-1200 хүнд, ном 2төрөл -50хүнд/

2-р өртөө Эссе бичлэгийн уралдаанд 7 бүтээл ирснээс 26 хүн үнэлгээ өгч 1, 2, 3-р байр шалгаруулав

3-р өртөө Гар зургийн уралдаанд 5 бүтээл ирснээс 25 хүн үнэлгээ өгч 1, 2, 3-р байр шалгаруулав

4-р өртөө Мари стопс эмнэлэгтэй хамтран 67 оюутанг ХДХВ/ДОХ-ын түргэвчилсэн шинжилгээнд хамруулж зөвлөгөө өгсөн

5-р өртөө Хүчилтөрөгчийн коктейлоор 59 хүнд үйлчилгээ үзүүлсэн

6-р өртөө АХА тэмцээнд 100 гаруй оюутан оролцож 1, 2, 3-р байр шалгаруулав





23.01 сарын 09, 11, 19-ний өдрүүдэд ШУТИС-ийн 1, 2 номын сангийн үйлчлэгч нарт “Шүд, амны хөндийн эрүүл ахуй, эмийн зохистой хэрэглээ, ажлын байрны дасгал хөдөлгөөн” сургалт зохион байгууллаа.



24.02 сарын 06-нд СБД-ийн МХГ-т “Хоол хүнсний гаралтай хордлого, авах арга хэмжээ” сэдэвт сургалтанд сууж 328 тоот тушаалын дагуу ажил зохион байгуулж ажиллаа.

25.03 сарын 12, 13-ны өдрүүдэд Цусаа бэлэглэж амьдрал хайрлая аянд нийт ШУТИС-ийн 180 оюутан, багш, ажилчид хамрагдлаа.



26.03 сарын 21-23-нд БЗД-ийн ЭМН-ийн вакциначурууд Улаанбурханы вакцин 670 оюутан хамрагдсан.

27.03 сарын 29-нд Эмчилгээний биений тамирын 11 эмэгтэй оюутанд Шүд амны хөндийн эрүүл ахуйн сургалт явууллаа.

28.Эмчилгээний Биений тамирын 5 эрэгтэй оюутанд Шүд амны хөндийн эрүүл ахуйн сургалт явууллаа.

29.Спорт явган аялал 228, 370, 310 эрэгтэй оюутнуудад Хачигнаас урьдчилан сэргийлэх аргын талаар лекц уншлаа.

30.СБД-ийн ЭМН-ийн вакциначурууд ҮТС-ийн 58 дадлагын оюутныг Хачигт энцефалитын 1-р тунт вакцинд хамруулав.

31.Спорт явган аялал 250, 183 эмэгтэй оюутнуудад Хачигнаас урьдчилан сэргийлэх аргын талаар лекц уншлаа.

32.Төрийн өмчит сургуулиудын дотуур байрнуудын чуулга уулзалтанд оролцон саналаа хүргүүлээ.

33. Спорт явган аялал 851 эрэгтэй оюутнууд хамрагдсанаас ЭМТ 32 оюутанд анхны тусламж үйлчилгээ үзүүлж ажилласан.



34. Спорт явган аялал 353 эмэгтэй оюутнууд хамрагдсанаас 32 оюутанд анхны тусламж үйлчилгээ үзүүлж ажилласан.
35. Шинжлэх ухаан технологийн их сургууль нийгмийн ажлын хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилд 5 хичээлийн байрны 7 удаагийн Цусны донорын өдөрлөг, аянаар 562 оюутан, багш, ажилчдын 1600 гаруй хүний амь насыг аварсан тул “Цусны донор хамт олон”-оор шалгарч 1-р байр эзэлсэн байна.
36. БУХС-ийн эмчийн кабенитыг өргөтгөх ажил хийгдлээ.

Орчны эрүүл ахуй, аюулгүй байдал

37. Нийт оюутны байрны эрүүл ахуй, цэвэрлэгээнд ЭМТ-өөс дүгнэлт хийж, зөвлөгөө өгч ажиллаа.
38. ШУТИС-ийн нийт үйлчилгээний ажилтанд 11 сарын 02-нд “Сургууль, сургуулийн орчны цэвэрлэгээ, ариутгалын бодисын хэрэглээ” сэдэвт сургалт зохион байгуулсан.



39. 12 сарын 5, 7-ны өдрүүдэд Оюутны соёл үйлчилгээний алба, хөдөлмөрийн аюулгүй байдлын инженертэй хамтран Оюутны дотуур байрны эрүүл ахуйн шалгалтаар явж, санал хүсэлтийг авч, зохих хэсгийн шийдвэрлэлээ.
40. 01 сарын 11, 12-нд “Агь нарын овоо” ХХК, Байр ашиглалтын нэгдсэн алба, ЭМТ нар хамтран ШУТИС-ийн хичээлийн 1, 2, 3 номын санд шавьж мэрэгч устгал, халдваргүйтгэл хийгдсэн.
41. 05 сард ШУТИС-ийн цайны гадруудад БАНА, ЭМСТ хамтран ээлжит үзлэг шалгалтаа хийлээ. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг дээд удирдлагад уламжиллаа.
42. МХТС 5R-ийн зарчмыг хэрэгжүүлж, цэвэрлэгээ үйлчилгээндээ ашиглан ажиллаж байна.



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

6.1. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НОМЫН САН

ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн номын сан нь 2017/18 оны хичээлийн жилд цахим үйлчилгээ, олон улсын мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах, уншигчдын тав тухтай орчин бүрдүүлэх, профессор багш, судлаачдад хандсан шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, номын санч, үйлчилгээний ажилчдын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургуулийн удирдлага, бүрэлдэхүүн сургууль, төрийн болон хувийн хэвшлийн дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллалаа.

2017 оноос номын сан менежментийн хувьд бие даасантай холбогдуулан тус хичээлийн жилд төсөв батлуулах, санхүүгийн тайлан хэлэлцүүлэх, тайлан мэдээ, бичиг хэрэг хөтлөлт, номын сангийн тодорхой нэгжүүдийн үйл ажиллагааг шинэчлэх ажлуудыг амжилттай хийлээ. Байгууллагын магадлан итгэмжлэл болон олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс номын сангийн үйл ажиллагаа хангалттай үнэлгээ авч ажиллалаа.

2017/18 оны хичээлийн жилд номын сангийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч Lib4u програмын веб хувилбарыг нэвтрүүлснээр үйлчилгээний чанар, хурдыг сайжруулж, электрон катологоос хайлт хийх ажиллагааг хялбарчилж, цахим ном унших боломжийг бүрдүүлсэн уншигчид болон номын санчдын сэтгэлд нийцсэн ажил боллоо.


ОУ-ын –SPRINGER NATURE мэдээллийн сангийн татгалзал, профессор багш нараас авсан судалгааны үр дүнд тулгуулан EBSCO мэдээллийн сангийн 4 багцийг авч профессор, багш, судлаачдад сургалт явуулж, мэдээллийн сангийн ашиглалтын зөвлөмж болон хандалтын статистик мэдээг тухай бүр вебсайт, нийгмийн сүлжээний хэрэгслээр түгээж байна. Өнөөгийн байдлаар ШУТИС-ийн номын санд өөрийн санхүүжилтээр 1, БСШУЯ-ны санхүүжилтээр 2, Монголын номын сангуудын консорциумын гишүүнчлэлээр 10 гаруй олон улсын мэдээллийн сангаар үйлчилгээ үзүүлж байна. Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажлыг 100 хувь биелүүлэн магистр, докторын диссертацийн агуулгыг веб сайтад байршуулах, олон улсын мэдээллийн сан захиалах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна. Цаашид номын сангийн веб сайтаар диссертаци унших програмын төлбөрийн системийг шийдэх, ОХУ-ын “Электронно, библиотечная система” мэдээллийн санг захиалахаар судалгаа хийж байна

2017/18 оны хичээлийн жилд номын сангийн нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааг шинэчлэн профессор багш нарын ном сурах бичиг, бичиг хэрэг, хувилах, хэвлэх үйлчилгээнээс гадна хүрээлэнгүүдийн брэнд бүтээгдэхүүнийг гэрээний дагуу хэрэглэгчдэд хүргэлээ. Ном сэргээн засварлах танхимын үйл ажиллагааг эрчимжүүлэн профессор багш нарт шаардлагатай, зохиогчийн эрх нь шийдвэрлэгдсэн ном сурах бичгийг сэргээн засварлах үйлчилгээ явууллаа. Мастер төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уншигчийн суудлын тоог нэмэгдүүлэхэд анхаарч уншлагын танхим болон хурлын танхимын сандалыг шинэчлэхээр холбогдох удирдлагуудад хүсэлт тавьж шийдвэрлүүлсэнээр ирэх хичээлийн жилд суудлын тоог нэмэгдүүлэхээр боллоо.

Тус хичээлийн жилд соёлын хөтөлбөрт ажилд онцгой ач холбогдол өгч Соёлын ажилтны өдрөөр Монголын их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн номын санчдын дунд “Номын сангийн өнөөгийн байдал болон цаашдын

чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг санаачлан Монголын номын сангуудын консорциумтай хамтран амжилттай зохион байгууллаа. Дэлхийн номын өдрийн үйл ажиллагааг Их хурлын тамгын газартай хамтран Төрийн ордонд хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан нь өмнөх жилүүдээс онцлог байлаа. Зохиогч уншигчийн уулзалт, нээлттэй хаалганы өдрүүд, гадаад дотоодын хэвлэлийн газруудын хэвлэмэл болон цахим номын үзэсгэлэн, худалдаа, оюутан уншигчдад зориулсан олон талт соёлын хөтөлбөрүүдийг тус тус зохион явууллаа.

Хурлын танхим, оюутны уншлагын танхимуудаар сургуулийн захиргаа, бүрэлдэхүүн сургууль, төрийн болон хувийн хэвшлийн дотоодын болон гадаадын байгууллагууд, ШУТИС-д олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудын зохион байгуулсан 250 удаагийн 16,000 орчим хүнийг хамарсан (давхардсан байдлаар) эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн, сургалт семинар, албан уулзалтуудыг явуулахад тохилог, орчин үеийн хурлын үйл ажиллагааг хангахуйц техникийн болон үйлчилгээний тав тухтай орчин бүрдүүлэн, үйлчилгээ үзүүлж ажиллав.



Зураг 6.1. Хурлын танхимын ашиглалт /хурлын тоогоор/

Гадаад харилцааны хүрээнд ОХУ-ын АСВ, МЭИ, Горная книга, Русский мир, БНХАУ-ын “Боловсрол, номын экспорт импорт”, АНУ-ын “В books” “Springer-Nature”, “EBSCO”, хэвлэлийн газруудтай хамтран ажиллаж, профессор багш, судлаач, уншигчдаас мэргэжлийн номын захиалга авах, номын үзэсгэлэн худалдааг тогтмол явуулж байна. 2018 оны 05 сард ОХУ-ын “Техноресурс” цахим номын компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан захирал Ч.Гулнар Монгол улс дахь албан төлөөлөгчөөр ажиллахаар боллоо. Номын сангийн төлөөлөл БНХАУ-ын Тяньжин хотын “Бинхайн нүд” нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан ажиллалаа.

Номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулж, докторт 2 номын санч суралцан, 1 номын санч СУИС-ийн магистрийн зэргийг амжилттай хамгааллаа.

Номын сангийн уншлагын танхимуудыг цэцэгжүүлэн, номын санч бүр ногоон, тохилог орчинд уншигчдад соёлч, боловсон, нээлттэй мэдээллийн орчинд үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэн ажиллалаа.

6.2. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ФОНД БҮРДҮҮЛЭЛТ


2017/2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Төв болон бүрэлдэхүүн сургуулиудын /БуХС, МТХС, МехТС, ДаТС, ОрТС/ номын сангаас бүрдсэн 6 салбар номын сан 2183 уншигчийн суудалтайгаар давхардсан тоогоор 238,319 уншигчдад 281,605 ном, материалаар үйлчилгээ хүргэж ажиллалаа. Үйлчилгээний талаар уншигчдын дунд онлайн санал асуулга, судалгааг тогтмол явуулж, тэдний санал, хүсэлтийг үйлчилгээндээ тусган жилээс жилд өргөжин ажиллаж байна.

ШУТИС нь ном, хэвлэмэл материалаар үйлчилгээг хүргэхээс гадна цахим үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээ, шинэ номын мэдээ-мэдээлэл, лавлагаа номзүй, хувиан олшруулах, эрэлт хэрэгцээтэй цөөн хувьтай болон хуучин номыг е-хэлбэрт оруулах, сэргээн засварлах, олшруулах, техник, технологийн мэдээ, мэдээллийг вэб сайтад тавих, төрөлжсөн электрон мэдээллийн сан бүрдүүлэх ажлуудыг хүргэж байна.

2017/18 оны хичээлийн жилийн номын сангийн үйлчилгээний статистикузүүлэлт


Хүснэгт 6.1

Д/Д	Номын сан	Уншигчийн тоо	Олгосон номын тоо
1	Төв номын сангийн нэгжүүд		
	Уншлагын танхим °1	8,430	13,464
	Уншлагын танхим °2	9,160	17,968
	Уншлагын танхим °3	14,897	21,546
	Үндсэн фонд /Сурах бичиг/	85,075	76,682
	Эрдэм шинжилгээ-судалгааны номын фонд	33,236	29,007
	Эрдэм шинжилгээний уншлагын танхим	3,590	5,674
	Тогтмол хэвлэлийн уншлагын танхим	2,878	3,402
	ҮГДС-ийн уншлагын танхим	2,820	11,764
2	Төв номын сан	160,086	179,507
3	БуХС-ийн номын сан	25,460	32,008
4	МехТС-ийн номын сан	19,768	25,319
5	МХТС-ийн номын сан	9,796	12,873
6	ДаТС-ийн номын сан	16,690	24,531
7	ОрТС-ийн номын сан	6,519	7,367
	НИЙТ	238,319	281,605




Зураг 6.2. Номын сангийн үйлчилгээний статистик үзүүлэлт
(“Lib4u” програмаас)

Энэ хичээлийн жилд электрон каталоогоор 73,992 уншигч хандаж, номын хайлт хийсэн байна. Тогтмол хэвлэлийн уншлагын танхимаар 40 гаруй нэр төрлийн гадаад сэтгүүл, 20 орчим нэр төрлийн монгол хэвлэл захиалан уншигчдын хүртээл болгож байна. Ном сэргээн засварлах, хувилах үйлчилгээгээр эрэлт хэрэгцээ ихтэй 206 нэр төрлийн 1048 ном, сурах бичгийг сэргээн засварлаж үйлчилгээнд гаргаж, багш нарын захиалгын дагуу зохиогчийн эрх нь шийдвэрлэсэн ном, сурах бичгийг хувиалан олшруулах үйлчилгээ үзүүлжээ



Зураг 6.3. Мэргэжлийн сэтгүүлийн судалгаа




Зураг 6.4. Гадаад хэвлэл захиалгын үнийн дүнгийн судалгаа

Фонд бүрдүүлэлт: ШУТИС-ийн фонд бүрдүүлэлт нь “Номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг үндэслэн хийгддэг. Тус журмын 4.3-т ШУТИС-ийн суралцагчийн (бакалавр, магистр, доктор оюутан) төлбөрийн 1.5%-аас доошгүй хөрөнгийг номын сангийн фонд бүрдүүлэлтэнд зориулна гэж заасан байдаг. Фонд бүрдүүлэлтийн төсвийн 60%-д бүрэлдэхүүн сургуулиуд мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага, үлдсэн 40%-д номын сан профессор багш нарын захиалгыг үндэслэн олон улсын нэр хүнд бүхий хэвлэлийн газруудаас сургалт судалгааны ном, мэдээллийн сан авах журмын дагуу 2017-2018 оны хичээлд EBSCO мэдээллийн сангийн

- Energy & Power Source
- Applied Science & Technology Source Ultimate
- Engineering Source
- Computers & Applied Sciences Complete

дөрвөн багцийг 40,1 сая орчим төгрөгөөр авч, профессор багш, судлаачид, уншигчдыг судалгаа хийх, эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлээ хэвлүүлэх боломжийг бүрдүүлж ажиллалаа. ОХУ-ын томоохон хэвлэлийн газруудтай хамтран ажиллаж, профессор багш нарын захиалгын дагуу 2017, 2018 онд хэвлэгдсэн техник технологийн 7,2 сая гаруй төгрөгийн 100 гаруй нэр төрлийн ном, сурах бичгийг авч сургалт, судалгаанд ашиглаж байна.

2018-2019 оны хичээлийн жилд ОХУ-ын “Электронно, библиотечная система” мэдээллийн сангийн техник технологийн цахим ном, материалын багцийг ашиглахаар судалгаа хийж байна.




Зураг 6.5. Е-ном, Е-уншлагын танхимын үйлчилгээний статситик үзүүлэлт


**ШУТИС-ийн номын фонд бүрдүүлэлтийн тоон үзүүлэлт
/Сүүлийн 3 жилийн харьцуулсан судалгаа/**

Хүснэгт 6.2


Д/Д	Номын сан	2015 он			2016 он			2017 он			2018 оны эхний хагас жил		
		Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
1	ШУТИС-ийн номын сан	542	3,890	79,184,686	679	4,329	121,586,877	312	3,715	107,917,815	201	1,599	39,431,464
2	БУХС-ийн номын сан	143	1,500	27,418,161	166	1,460	26,263,509	137	1,652	32,628,210	32	411	8,289,460
3	МехТС-ийн номын сан	84	687	17,000,000	66	616	9,315,130	116	1,280	16,208,000	13	196	4,031,400
4	МХТС-ийн номын сан	285	798	25,475,085	28	248	6,095,217	62	367	10,146,751	13	115	4,189,900
5	ИаТС-ийн номын сан	149	1,480	5,884,340	24	248	2,467,500	13	106	2,290,000	38	78	1,224,300
6	ОрТС-ийн номын сан	112	4,090	39,680,176	45	1,331	18,864,998	118	464	10,723,000	24	689	10,141,600
НИЙТ		1,315	12,445	194,642,448	1,008	8,232	184,593,231	758	7,584	179,913,776	321	3,088	67,308,124



Зураг 6.6. Номын фонд бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа
(үнийн дүнгээр)



Зураг 6.7. Номын фонд бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа
(тоо ширхэгээр)



Зураг 6.8. Номын фонд бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа
(нэр төрлөөр)

6.3. САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

ШУТИС-ийн номын сан тус хичээлийн жилд цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад анхаарч ОУ-ын нээлттэй мэдээллийн сангийн эрх авах, төрлийг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг төрөлжүүлэн ажиллалаа.

Цахим сан хөмрөгийн баяжилт:

ШУТИС нь номоор үйлчлэх үйлчилгээг номын сангийн үйлчилгээний зөвхөн нэг хэсэг гэж үзэн үйлчилгээндээ цахим үйлчилгээ, шинэ номын мэдээ-мэдээлэл, лавлагаа номзүй, хувиан олшруулах, онлайнаар номын захиалга авч хүргэх, эрэлт хэрэгцээтэй цөөн хувьтай болон хуучин номыг е-хэлбэрт оруулах, сэргээн засварлах, олшруулах, техник, технологийн мэдээ, мэдээллийг вэб сайтад тавих, төрөлжсөн электрон мэдээллийн сан бүрдүүлэх ажлуудыг нэвтрүүлсээр байна. Профессор багш, оюутан судлаачдад ОУ-ийн мэдээллийн сангийн ашиглалт, электрон мэдээллийн хайлт, электрон ном, сонин сэтгүүл унших сургалтыг шат дараалалтай явуулж байна.


Номын сангийн e-Library програмын баазыг бүрэн эхээр нь Номын сангийн цогц програм хангамж LIB4U.net-рүү хөрвүүлж, туршин 2017-2018 оны хичээлийн жилд төв болон бүрэлдэхүүн сургуулийн номын сангийн үйлчилгээнд амжилттай ашиглалаа. LIB4U.net програм хангамж нь номын сангийн програмын цоо шинэ, дэвшилтэт хувилбар бөгөөд үүлэн технологит суурилсан, найдвартай, тасралтгүй ажиллагаа бүхий дата төвүүдэд байрласан тул мэдээллийн аюулгүй байдал бүрэн хангагдсан юм. Бүртгэгдсэн уншигчид зохиогчийн эрх шийдэгдсэн цахим номыг бүрэн текстээр нь дурын газраас унших, гэрээр авсан ном, материалын хугацааг онлайнаар холбогдон сунгуулах, мэдээлэл авах зэргээр цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн нь профессор багш, судлаач, уншигчдын талархлыг хүлээсэн үйлчилгээ байлаа.

е-Ном, эрдэм шинжилгээ, судалгааны материал, дүрэм журмыг багтаасан 1600 гаруй номын фондтой дотоод сүлжээгээр унших боломж бүхий “Цахим номын сан” веб сайтыг тогтмол баяжуулж веб сайтад байршуулан уншигчдын хүртээл болгосоор байна. Цахим номын сангийн фондонд зохиогчийн эрх шийдэгдсэн бүтээлүүдийг цаасан хэлбэрээс хөрвүүлэн ISSUU, Flipping Book Publisher 2.2 програмыг ашиглан тодорхой хамгаалалтайгаар бүрэн эхээр нь оруулж, баяжилт хийж уншигчдад хүргэж байна. <http://www.must-library.edu.mn/gnews/19>

ШУТИС-д магистр, докторын зэрэг хамгаалж буй эрдэмтэн, судлаачдын судалгаа, шинжилгээний (диссертаци, магистрын бүтээл) ажлын нэгдсэн мэдээллийн санг үүсгэж номын сангийн веб сайтын “Судалгааны сан” цонхонд (<http://www.must-library.edu.mn/page/show/id/395>) нээлттэй байрлуулсан. Тус санд 270 орчим судалгааны ажлын товч агуулгыг оруулсан бөгөөд тогтмол баяжуулан ажиллаж байна.

Мэдээллийн сангуудыг ашигласан байдал:

Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан нь эрдэм шинжилгээ сургалтын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн ном сэтгүүлийн цахим нөөцийг бүрдүүлэх зорилгоор техник, технологийн чиглэлийн 20 орчим олон улсын мэдээллийн сангийн эрхийг авч судлаачдын хүртээл болгож байна. Нээлттэй мэдээллийн сангийн ашиглалт, статистик, татгалзлын судалгааг тогтмол гарган үр дүнгээс хамаарч цаашид ямар төрлийн мэдээллийн сан эрэлт хэрэгцээтэй байгаад дүгнэлт хийж, тухайн салбарын мэдээллийн сангийн эрх авах, е-номын захиалгад тусган ажилладаг.



Зураг 6.9. EBSCO мэдээллийн сангийн хандалт

Өнөөгийн байдлаар ШУТИС-ийн номын санд өөрийн санхүүжилтээр 1, БСШУЯ-ны санхүүжилтээр 2, Монголын номын сангуудын консорциумын гишүүнчлэлээр 10 гаруй олон улсын мэдээллийн сангаар үйлчилгээ үзүүлж байна.

ОУ-ын –SPRINGER NATURE мэдээллийн сангийн татгалзал, профессор багш нараас авсан судалгааны үр дүнд тулгуулан EBSCO мэдээллийн сангийн Energy & Power Source, Applied Science & Technology Source Ultimate, Engineering Source, Computers & Applied Sciences Complete багцуудын эрхийг авч профессор, багш, судлаачдад сургалт явуулж, мэдээллийн сангийн ашиглалтын зөвлөмж болон хандалтын статистик мэдээг тухай бүр вебсайт, нийгмийн сүлжээний хэрэгслээр хүргэж байна.

“EBSCO” мэдээллийн сангийн хандалт

Хүснэгт 6.3

Platform	User Activity	Reporting Period Total	Oct-2017	Nov-2017	Dec-2017	Jan-2018	Feb-2018	Mar-2018	Apr-2018	May-2018
EBSCOhost	Regular Searches	2378	116	305	67	663	475	354	268	126
EBSCOhost	Result Clicks	3667	294	455	33	1038	737	565	407	138
EBSCOhost	Record Views	1820	121	174	22	485	409	310	243	56


БСШУСЯ-ны Шинжлэх ухаан технологийн газрын санхүүжилтээр олон улсын Springer Nature мэдээллийн сангийн (<https://link.springer.com/>) 1997 оноос хойших 2409 эрдэм шинжилгээний сэтгүүлийг профессор багш нар судалгаа шинжилгээний ажилдаа идэвхтэй ашиглаж байна.

“SPRINGER NATURE” мэдээллийн сангийн хандалт


Хүснэгт 6.4

Journal	Reporting Period HTML	Reporting Period PDF	Jan-2018	Feb-2018	Mar-2018	Apr-2018	May-2018
Total for all journals	632	976	224	343	418	443	181

22000 орчим мэргэжлийн сэтгүүлийг нэгтгэсэн SCOPUS мэдээллийн сангаас ШУТИС-ийн багш нарын бүтээлийн хэвлэгдсэн өгүүллийн тоо, тэдгээрийн эшлэгдсэн байдлыг тоймлон дараах байдлаар үзүүлж байна.



Зураг 6.10. SCOPUS-д хэвлэгдсэн өгүүллийн тоо



Зураг 6.11. ШУТИС-ийн профессор багш, судлаачдын Scopus мэдээллийн санд бүртгэгдсэн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо, эшлэгдсэн байдал

6.4. СОЁЛЫН ХӨТӨЛБӨРТ АЖЛУУД

Тус хичээлийн жилийн эхэнд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг уламжлал ёсоор зохион байгууллаа. Тус өдөрлөгийн хүрээнд гадаадын хэвлэлийн газруудын

болон профессор багш нарын техник технологийн шинэ номын үзэсгэлэн, худалдааг зохион явуулж, ерөнхий эрдмийн болон мэргэжлийн 920 орчим ном, сурах бичиг, гадаадаас захиалсан сургалт, судалгааны 222 Е-ном, сэтгүүлийн үзэсгэлэн гаргаж, элсэгч оюутнуудад зориулж номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээг танилцуулах сургалтыг ОСҮА-тай хамтран зохион байгууллаа.

Монголын соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан Монголын номын сангуудын консорциум, МУБИС-ийн номын сантай хамтран Их дээд сургууль, Ерөнхий боловсролын номын сангуудын номын санч мэдээллийн ажилтнуудад зориулсан “Номын сангийн хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2017 оны 9 сарын 15, 16-ны өдрүүдэд амжилттай зохион явууллаа. Тус арга хэмжээнд МУБИС, ХААИС, СЭЗИС, Отгонтэнгэр ИС зэрэг төрийн болон хувийн 14 их, дээд сургуулийн 90 гаруй номын санч- мэдээллийн ажилтнууд оролцсон.

ШУТИС-ийн төв номын сан, Монголын номын сангуудын консорциумтай газартай хамтран профессор, багш судлаачдад зориулсан “Олон улсын мэдээллийн сангуудын ашиглалтыг үр дүнтэй болгох нь” сэдэвт сургалтыг 2018 оны 1 сарын 23, 24-ний өдрүүдэд амжилттай зохион явууллаа. Тус сургалтанд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль хүрээлэн болон МИДС-ийн консорциумын гишүүн сургуулиудын 300-аад багш судлаачид идэвхтэй оролцлоо. Тус сургалтын зорилго нь профессор багш нарын эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлыг дэмжих зорилгоор ашиглалтын эрхийг авсан EBSCO, SPRINGER NATURE зэрэг олон улсын платформууд болон Research4life - хөгжиж буй орнуудад зориулсан мэдээллийн сангуудын багцийг таниулан сурталчлах, хандалтыг сайжруулах, хэрэглээг үр дүнтэй болгоход чиглэсэн.

2017/18-оны хичээлийн жил “Дэлхийн номын өдөр”-ийн арга хэмжээг УИХ-ын Тамгын газартай хамтран Төрийн ордонд болон ШУТИС-ийн төв, бүрэлдэхүүн сургуулийн номын санд амжилттай зохион явуулаа. “Дэлхийн номын өдөр-2018” арга хэмжээ нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, ШУТИС-ийн профессор багш нарын бүтээлийг таниулан сурталчлах, олон улсын мэдээллийн сангуудыг их дээд сургууль, судалгааны байгууллагууд хамтран ашиглах боломжийн талаар боломжуудыг эрэлхийлсэн нь өмнөх жилүүдээс онцлог байлаа. Тус арга хэмжээний хүрээнд БУХС-ийн захирал, профессор А.Энхбат “Эл хаадын соёл, бичиг үсгийн дурсгал” Академич, МУ-ын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, профессор Sc.D Д.Дашжамц “Шинжлэх ухааны судалгааны ажлын онол арга зүйн үндэс” номын хэлэлцүүлэг болон оюутан уншигчдад зориулсан уралдаан тэмцээнүүдийг хөтөлбөрийн дагуу зохион явууллаа.

Профессор багш, судлаачдын бүтээлийг уншигчдад таниулан сурталчлах ажлын хүрээнд доктор, математикч, яруу найрагч Пүрэвийн Лхагвасүрэнгийн “Сэтгэлийн томъёолол”, Монгол улсын гавьяат багш доктор (Ph.D), Б.Дамдинсүрэн “Манай эрдэмтэд” 66-р боть, доктор (Ph.D) профессор Б.Отгонбаяр “Манай эрдэмтэд” 65-р боть, С.Нямдоржийн “Барилгын бүтээц”, “Барилгын геотехник” толь бичгийн англи, хятад, орос, монгол хэлний цуврал бүтээл зэрэг шинэном, сурах бичгийн нээлт хэлэлцүүлгийг тус тус зохион байгууллаа.

6.5. ШУТИС-ИЙН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР, ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН БАЙДАЛ

ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтан ажилчид, оюутнуудад болон бусад хамтарч ажилладаг боловсролын салбарын 10 гаруй байгууллагад хэвлэх үйлчилгээг чанартай, хугацаанд нь гүйцэтгэдэг.

Мөн БСШСЯ, МИДС-ийн консорциумын гишүүн сургуулиудын захиалгыг байнга авч хамтран ажиллаж захиалагчийн санал хүсэлт, хэвлэлийн дизайн, эх бэлтгэлд анхаарч, сүүлийн үеийн тоног төхөөрөмж болох “Хайделберг” print master-52-2 маркийн офсет хэвлэл, “Коника минолта” Bizhub-C1070, IPF841, PRO-951 дижитал хэвлэл, оёо SX-460A-B, үдээ DQB404-02GB зэрэг машинуудаар үйлчилгээ үзүүлж байна.

2017-2018 хичээлийн жилд Хэвлэлийн газар нь ШУТИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургууль, институт, хүрээлэн болон аж ахуй нэгж, иргэнд чанарын өндөр төвшинд нийт 93 төрлийн 12037 ширхэг ном, сурах бичиг 114 төрлийн 18361 ширхэг гарын авлага, эрдэм шинжилгээний эмхтгэл, тайлан зэрэг хэвлэмэл бүтээгдэхүүн гаргасан байна.

Хэвлэлийн газрын хувьд бие даалтын коэффициент 0.99 буюу нийт хөрөнгийн 99% өөрийн хөрөнгөөр санхүүжиж байна.

Төлбөрийн чадварын хувьд богино хугацаат өр төлбөрийг эргэлтийн хөрөнгөөр барагдуулах боломжтой. Өр төлбөр буурсан тул урд түргэн хөрвөх чадвар 24,76%-аар өссөн байна. Нийт хөрөнгийн 20,4% эргэлтийн хөрөнгө эзэлж байна



Зураг 6.12. ШУТИС-ийн 60-ийн ойд зориулсан үндсэн сурах бичигүүд

Хэвлэх үйлдвэр нь аж ахуйн тооцоот зарчмаар ажилладаг ба цаг үеийн шаардлагын улмаас илүү цагаар ажилласан ажилтны цалинг олгохдоо журмын дагуу нэмэгдэл хөлсийг олгож ажиллаа.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШУТИС-ийн Хэвлэлийн газрын редакцийн зөвлөл нь сургуулийн хэвлэл нийтлэлийн бодлогыг тодорхойлох зорилгоор байгуулагдсан тэргүүлэх эрдэмтэдээс бүрдсэн орон тооны зөвлөл. 2017/18 оны хичээлийн жилд профессор багш нар, судлаачдын оюуны бүтээлийг хүлээн авч редакци хийн дүгнэлт гарган хэвлэх үйлдвэрт шилжүүлэн ажиллалаа.

Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Захирлын зөвлөлөөр үйл ажиллагааны холбогдох журмыг шинэчлэх асуудлыг хэлэлцүүлж “ШУТИС хэвлэлийн газрын үйл ажиллагааны түр журам”, “Редакцийн зөвлөлийн түр журам”-ыг хүчингүй болгож “ШУТИС-ийн хэвлэлийн газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг, 2018.02.02-ны өдрийн А/23 тоот тушаалаар ШУТИС-ийн ерөнхий редакци, Хэвлэлийн газрын редакцийн зөвлөлийн гишүүдийг тус тус батлуулан ажиллаж байна.

ШУТИС-ийн ерөнхий редакцийн зөвлөлд:

Зөвлөлийн дарга – Б.Очирбат,

Нарийн бичгийн дарга - Л.Удвал,
 Гишүүдэд - П.Очирбат, Ч.Авдай, Д.Дашжамц, С.Батмөнх, Г.Батхүрэл,
 Б.Дамдинсүрэн нар байна.

Хэвлэлийн редакцийн зөвлөлд:

Ерөнхий редактор - Х.Энхжаргал,
 Хариуцлагатай нарийн бичгийн дарга - Ч.Гулнар,
 Гишүүдэд - П.Отгонбаяр /БАС/, Ж.Цэен-Ойдов /ЭХС/, Ц.Энхбаатар
 /БУХС/, Б.Лайхансүрэн /ГУУС/, Д.Лханаг /МТС/, Б.Отгонбаяр /МХТС/,
 Д.Энхтуяа /УТС/, П.Мөнхбаатар /ХШУС/, Р.Наранцэцэг /ГХИ/

2018.04 сард ШУТИС-ийн ерөнхий редакцийн зөвлөл хуралдаж үндсэн сурах
 бичгийн бодлогыг тодорхойлон ШУТИС-ийн 60 жилийн ойд зориулан хэвлэх 60
 үндсэн сурах бичгийг хэвлэлийн газрын редакцийн зөвлөлд хариуцуулж, төвлөгөөг
 гарган ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу профессор багш нарын 13 үндсэн сурах бичгийн
 агуулгын болон техникийн редакторыг хийж хэвлэсэн байна. Техникийн
 редактороор ажилласан гишүүдэд батлагдсан журмын дагуу урамшуулал олгон
 ажиллаж байна. Цаашид техникийн редактораар гэрээт ажилтан авч ажилуулахаар
 судлаж байна.

2017-2018 оны тайлангын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлууд:

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн түүхэн замнал:

№	Номын нэр	Тоо /ш/
1	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн түүхэн замнал 1959-2016 / Тэргүүн боть /	500

ШУТИС-ийн 60-н үндсэн сурах бичиг

Хүснэгт 6.5

№	Номын нэр /Зохиогч/	Сургууль	Тоо /ш/
1	Геотехникийн үндэс / Д.Дашжамц /	БАС	200
2	Техникийн термодинамик /Ж.Цэен - Ойдов/	ЭХС	400
3	Шинжлэх ухаан техникийн орчуулга /Ц.Цэцэгмаа,Т.Энхцэцэг, Ц.Байгалмаа, Я.Оюунцэцэг /	ГХИ	300
4	Шингэн ба хийн механик /Батмөнх , Даваасамбуу , Ч.Мангалжалав/	ЭХС	300
5	Аянга хамгаалалт газардуулга /З.Цэрэндорж, Ц.Эрлэнэтөгс/	ЭХС	300
6	Хар ба уран зураг /Н.Нямжав/	БАС	300
7	Төмөр бетон бүтээц / Г.Базар, М.Сугар/	БАС	300
8	Цахилгаан системийн цахилгаан соронзон шилжилтийн процесс /Д.Содномдорж,Б.Пүрэвсүрэн /	ЭХС	300
9	Химийн ерөнхий технологи /И.Сүхбаатар /	ХШУС	100
10	Цахилгаан техникийн үндэс / Ч.Нацагдорж. С.Лямхцэцэг, Г.Чүлтэмдавга, С.Эрдэнэтуяа /		300

11	Цахилгаан техник ба электроникийн материал онол хэрэглээ /Ц.Эрдэнэцэцэг, Г.Бэхбат /	ЭХС	400
12	Ерөнхий физик / Г.Зоригт, Ц.Байгалмаа, О.Сүх, Н.Насанбат, Г.Мөнхсайхан, Ч.Алдармаа, Г.Цэрмаа, Б.Түмэндэмбэрэл, Ц.Эрхэмбаяр/	ЭХС	500
13	Жимс ногоо боловсруулах технологи / Я.Алтанцэцэг, Э.Энхцэцэг/	ҮТС	300
Нийт			4000

Тогтмол хийгдэж буй хэвлэлийн бүтээгдэхүүн:

№	Гүйцэтгэсэн ажлын нэрс	Тоо /ш/
1	Ном, Сурах бичиг	12,037
2	Гарын авлага, Тайлан, ЭШЭмхтгэл	18,361
3	Танилцууга, Урилга, Нэрийн хуудас	32,772
4	Хавтаслалт, Стенд, Бусад	66,142
Нийт		130,525

Хэрэглэгчдэд санал болгож ажиллаж буй үнийн санал:

ШУТИС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР ҮНИЙН САНАЛ

ДИГИТАЛ ХЭВЛЭЛ

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ
Нэрийн хуудас	1 тал	900Т
Нэрийн хуудас	2 тал	120-200Т

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ	Тайлбар
Танилцуулга А5	2 тал	400-500Т	
Танилцуулга А4	2 тал	800-200Т	
Танилцуулга А3	2 тал	1000-3600Т	

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ	Тайлбар
Урилга, Хөтөлбөр, Мөндчилгээ А3	2 тал	400-500Т	
Урилга, Хөтөлбөр, Мөндчилгээ А4	2 тал	800Т	
Урилга, Хөтөлбөр, Мөндчилгээ А5	2 тал	1000Т	

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ	Тайлбар
Албан бланк А4	1 тал	100Т	
Албан бланк А5	1 тал	70Т	

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ	Тайлбар
Тайлан, Диплом, Диссертацийн хавтас А5 (хатуу хавтас)	1 ш	6.000Т	
Тайлан, Диплом, Диссертацийн хавтас А4 (хатуу хавтас)	1 ш	15.000Т	
Диплом, Хөтөлбөрийн хавтас А4 (хатуу хавтас)	1 ш	1000-2500Т	

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ
Өргөмжлөл, Батламж, Сертификат А5	1 тал	
Өргөмжлөл, Батламж, Сертификат А4	1 тал	
Өргөмжлөл, Батламж, Сертификат А3	1 тал	

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ
Тайлан, Диплом, Диссертацийн-батламж А5	1 тал	40-500Т
Тайлан, Диплом, Диссертацийн-батламж А4	1 тал	100-500Т
Тайлан, Диплом, Диссертацийн-батламж А3	1 тал	200-200Т

Нэр / хэмжээ	Хуудас	Үнэ
Ном, Сурах бичиг, Гарын авлага, ЭШЭмхтгэл А5, А4, А3	1 тал	200-200Т

ОФСЕТ ХЭВЛЭЛ

Хэмжээ	500ш	800ш	1000ш
70ш (батламж)	230Т	215Т	300Т
80ш (батламж)	225Т	240Т	225Т
70ш (батламж)	220Т	235Т	220Т
80ш (батламж)	220Т	250Т	215Т
70ш (батламж)	360Т	340Т	320Т
80ш (батламж)	375Т	390Т	345Т
70ш (батламж)	370Т	395Т	340Т
80ш (батламж)	390Т	375Т	350Т
А3	500Т	450Т	400Т
А4	620Т	550Т	500Т

Хөтөлбөр	Хуудас	Үнэ
Хөтөлбөр А4	1 тал	1000Т
Хөтөлбөр А3	1 тал	1000Т
Хөтөлбөр А5	1 тал	1000Т

Хөтөлбөр	Хуудас	Үнэ
Хөтөлбөр А4	1 тал	1000Т
Хөтөлбөр А3	1 тал	1000Т
Хөтөлбөр А5	1 тал	1000Т

Хөтөлбөр	Хуудас	Үнэ
Хөтөлбөр А4	1 тал	1000Т
Хөтөлбөр А3	1 тал	1000Т
Хөтөлбөр А5	1 тал	1000Т

Хөтөлбөр	Хуудас	Үнэ
Хөтөлбөр А4	1 тал	1000Т
Хөтөлбөр А3	1 тал	1000Т
Хөтөлбөр А5	1 тал	1000Т

Хэвлэмэл бүтээгдэхүүний төрөл /борлуулалт/:

Бүтээгдэхүүний нэр, төрөл	2017/18 оны хичээлийн жил		
	Төрөл	Тоо ширхэг	Гүйцэтгэл /₮/
Ном, Сурах бичиг	93	12,037	101,868,000
Гарын авлага, Тайлан, ЭШЭмхтгэл	114	18,361	70,120,450
Танилцууга, Урилга, Нэрийн хуудас		66,142	49,538,820
Хавтаслалт, Стенд, Бусад		33,985	46,268,450
Дүн		130,525	268,850,800



ДОЛООДУГААР БҮЛЭГ

САНХҮҮ, БҮРТГЭЛ

ДОЛОО. САНХҮҮ, БҮРТГЭЛ

7.1. САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 2017-2018 оны хичээлийн жилд санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн сайжруулж санхүүгийн программд нэмэлт өөрчлөлтийг оруулж, санхүүгийн шинэ журмыг боловсруулж Захирлын зөвлөлийн хурлаар батлуулан, санхүүгийн ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаа. 2017 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүний 9 сургууль, 2 институт, Ахлах сургууль, КТКоллеж, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацийн газар, Ой мод сургалт судалгааны хүрээлэн, Хэвлэлийн газар, Шинжлэх ухаан технологийн номын сан, Эрдэмнэт сүлжээний төв зэрэг нийт 21 нэгжүүд үйл ажиллагаа явуулж тайлан баланс гаргасан. Монгол улсын Сангийн сайдын 388 тоот санхүүгийн тайлан, тодруулга, 55 тоот эдийн засгийн ангилал болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), үр дүнгийн тайлан (СТ-2А), мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12) зэргийг гарган өгч, ШУТИС-ийн удирдлагын нэгдсэн системийн дэд хэсэг болох УСНББОУС-д нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “И-Finance” санхүүгийн программаар санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. 2017 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар, “Хүлэгт хүннү” аудитын компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дагуу санхүүгийн тайланд залруулах бичилтүүдийг мөн хийж гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд 1752 орон тоотойгоос үндсэн орон тооны профессор, багш 951 ажилласан байна. Нийт оюутны тоо: Хавар, намрын улиралд идэвхтэй сурч буй сонголт хийсэн бакалавр 15331, магистр-1408, доктор-104, МСҮТ, ахлах сургуулийн суралцагч 604 байна. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, нэгжүүд тус бүрийн 2017 оны санхүүгийн тайланг захирлын зөвлөлийн, захиргааны зөвлөлийн, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн, удирдах зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлсэн.

ШУТИС-ийн 2017 оны санхүүгийн тайланг балансын бүтэц, орлогын үр дүн, зарлагын үр дүн, нэг оюутанд ноогдож буй зардал, оюутны байрны орлого, зардал, төвлөрсөн арга хэмжээний орлого, зардал, санхүүгийн харьцаа, санхүүгийн тайлангийн аудит, зөвлөмж гэсэн бүтэцтэйгээр танилцуулж байна.

7.2. БАЛАНСЫН БҮТЭЦ

Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 89,482.7 сая төгрөгт хүрч урьд оны мөн үетэй харьцуулахад 3.2% буюу 2.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Эргэлтийн хөрөнгө 48.1 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 51.9 хувийг эзлэж эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 0.3 хувиар нэмэгдсэн байна. Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 9.9 хувь, эзний өмч 90.1 хувийг тус тус эзлэж эзний өмчийн дүн нийт хөрөнгөд эзлэх хувь өнгөрсөн оноос 0.6 хувиар буурчээ.


Балансын бүтэц (сая төгрөгөөр)

Хүснэгт 7.1

Д/Д	Балансын зүйл	2016 он		2017 он		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	абсолют	хувь
1	Мөнгө ба түүнтэй адил хөрөнгө	30,244.0	34.9	33,969.3	38.0	3,725.3	12.3
2	Авлага	8,555.8	9.9	7,359.9	8.2	(1,195.9)	(14.0)
3	Бараа материал	2,644.4	3.1	1,634.7	1.8	(1,009.7)	(38.2)
4	Урьдчилж гарсан зардал			59.1	0.1	59.1	
	Эргэлтийн хөрөнгийн дүн	41,444.2	47.8	43,023.0	48.1	1,519.7	3.8
1	Бусад хөрөнгө	362.7	0.4	342.6	0.4	(20.1)	(5.5)
2	Үндсэн хөрөнгө	44,868.2	51.8	46,117.1	51.5	1,248.9	2.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	45,230.9	52.2	46,459.7	51.9	1,228.8	2.7
	Нийт хөрөнгийн дүн	86,675.1	100.0	89,482.7	100.0	2,748.5	3.2
1	Богино хугацаат өр төлбөр	8,013.8	9.2	8,748.7	9.8	734.9	9.2
2	Урт хугацаат өр төлбөр	87.6	0.1	72.1	0.1	(15.5)	(17.7)
	Өр төлбөрийн дүн	8,101.4	9.3	8,820.8	9.9	719.4	8.9
1	Засгийн газрын сан	23,542.8	27.2	23,542.8	26.3	(0.0)	(0.0)
2	Хуримтлагдсан үр дүн	33,952.6	39.2	37,054.1	41.4	3,101.5	9.1
3	Өмнөх үеийн үр дүн	31,370.2	36.2	34,096.6	38.1	2,726.4	8.7
4	Тайлант үеийн үр дүн	2,582.4	3.0	2,957.5	3.3	375.1	14.5
5	Хөрөнгө дахин үнэлгээний зөрүү	21,078.3	24.3	20,065.0	22.4	(1,013.3)	(4.8)
	Эзний өмчийн дүн	78,573.7	90.7	80,661.9	90.1	2,088.2	2.7
	Өр төлбөр ба эзний өмч	86,675.1	100.0	89,482.7	100.0	2,807.6	3.2

Эргэлтийн хөрөнгө мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материалаас бүрдэж байна. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 3.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, авлага 1.2 тэрбум төгрөгөөр, бараа материал 1.0 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй гарсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 12.3% буюу 3.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, авлага 14.0% буюу 1.2 тэрбум төгрөгөөр, бараа материал 38.2% буюу 1.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Цэвэр шилжих үлдэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.5 тэрбум төгрөг буюу 15.8%-иар нэмэгдсэн байна. Цэвэр шилжих үлдэгдлийн захиргааны нэгж дээр 54 дахин нэмэгдсэн нь захиргааны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд магистр, доктор оюутны сургалт, судалгааны төлбөрийг захиргааны дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна. Дарханы ТС-ийн хувьд 2017 онд санхүүгийн тэвчиж болох зардлуудыг бууруулж, хэмнэлтийн бодлого барьж ажилласны үр дүнд мөнгөн хөрөнгө нэмэгдсэн байна. МехТС, УТС, ХШУС, ГХИ, КТК, ОМССХ, ОУДБСТөвүүдээс бусад бүрэлдэхүүн сургууль нэгжүүд шилжих үлдэгдлийн хэмжээгээ нэмэгдүүлсэн.



Зураг 7.2. ШУТИС-ийн 2017 оны балансын бүтэц

Авлага урьд оны мөн мөн үетэй харьцуулахад 14.0 хувь буюу 1.2 тэрбум төгрөгөөр буурсан нь ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 19 тоот тогтоолоор 10 ба түүнээс дээш насжилттай 433 эзэн холбогдогч бүхий 230.2 сая төгрөг, 4-9 жилийн насжилттай шүүхийн шийдвэр гарсан, хаяг дээрээ байхгүй, сураггүй алга болсон, цагдаагийн байгууллагын дүгнэлт гарсан зэрэг шалтгаануудтай 1771 эзэн холбогдогч бүхий 705.5 сая төгрөг нийт 2204 эзэн холбогдогч бүхий 935.7 сая төгрөгийн авлагыг данснаас хассан. Тайлант оны жилийн эцсийн байдлаарх авлагыг төрлөөр харуулбал:

- Сургалтын төлбөрийн авлага хувиараа төлөх оюутны авлага 2,506.7 сая төгрөг
- Боловсролын зээлийн сангийн авлага 424.4 сая төгрөг
- Тогтмол зардлын санхүүжилтийн авлага 1,597.8 сая төгрөг (БСШУСЯам)
- Барилга байгууламжтай холбоотой авлага 1,841.9 сая төгрөг
- Дараа тайлангаар болон хувь хүмүүстэй холбоотой авлага 407.3 сая төгрөг
- Байгууллагатай холбоотой авлага 581.8 сая төгрөг байна.

Бараа материалын үлдэгдэл нь 2017 оны эхэнд 2,644.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацааны туршид 1,874.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 2,884.4 сая төгрөгөөр хорогдож, жилийн эцэст 1,634.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 38.2% буюу 1.0 тэрбум төгрөгөөр буурсан. Шалтгаан нь ШУТИС-ийн Захирлын 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/191 тоот тушаалаар сургалтын болон аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаад цаашид ашиглах боломжгүй 63,400 ширхэг 451.5 сая төгрөгийн хичээлийн хэрэгсэл, аж ахуйн материал сэлбэгийг данснаас хассан. Мөн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын зөвлөмжийн дагуу залруулгаар 187.9 сая төгрөгийн бараа материалыг зарлагдаж тайлант үеийн үр дүнд, 440.9 сая төгрөгийн бараа материалыг зарлагдаж хуримтлагдсан үр дүнд шилжүүлсэн бичилтийг хийсэн. Бараа материалын нэмэгдсэн эх үүсвэрээр авч үзвэл 1,834.3 сая төгрөгөөр бараа материал худалдан авсан, 19.7 сая төгрөг бүхий үнэ төлбөргүй бараа авсан, бусад хэлбэрээр 20.7 сая

төгрөгийн бараа материал байна. Бараа материалын бүтцийн хувьд тусгай зориулалттай материал 69.0 хувь, баглаа боодол, бусад хангамжийн материал 10.5 хувь, бичиг хэргийн материал 13.2 хувь, аж ахуйн материал 2.1 хувь, үлдсэн хувийг засварын материал, түлш шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн тус тус эзлэж байна.

Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн хэмжээ 100,927.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 4.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 2.0 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр, 5.0 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг улсын төсөв болон үнэт төлбөргүй, хандиваар бэлтгэж, 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж акталсан байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр баригдсан ДТС-ийн 2017 онд ашиглалтанд орсон хичээлийн байрны барилгын 3.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн урсгал засварын ажлууд:


- МХТС-ийн оюутны байрны засварт 138.0 сая төгрөг,
- МехТС-ийн оюутны байрны засварт 78.3 сая төгрөг,
- БУХС-ийн хичээлийн байрны сантехникийн засвар 218.5 сая төгрөг,
- ДарТС-ийн дулааны узелийн засварт 77.0 сая төгрөгийн ажлууд хийгдсэнийг капиталжуулж үндсэн хөрөнгөө нэмэгдсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ДарТС-д 10.2 сая төгрөгийн сурагчийн ширээ сандал, МехТС, МХТС-д тус бүр 1.3 сая төгрөгийн ширээний компьютер, ҮТС-д 90.0 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж худалдан авч өгснийг данс бүртгэлд тусгаж үндсэн хөрөнгө нэмэгджээ. Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд БАС-д 335.3 сая төгрөгийн барилын бичил чичирхийллийг бичих төхөөрөмж, МехТС-д 245.1 сая төгрөгийн спектрометрийн багаж, металл хайлуулах зуух, ГУУС 262.5 сая төгрөгийн цахилгаан хамгаалалтын программ хангамж, сургалтын тоног төхөөрөмж, ЭХС-д 194.9 сая төгрөгийн инженерийн лабораторийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 сарын 12-ны өдрийн 534 тоот тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А-5/3614 тоот албан бичгийн дагуу дараах нэр төрлийн 3.0 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсан. Үүнд:

- Барилга байгууламж 2.1 тэрбум төгрөг /БАС-ийн оюутны байр/
- Тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгсэл 602.9 сая төгрөг
- Тээврийн хэрэгсэл 63.9 сая төгрөг
- Тавилга, эд хогшил 81.4 сая төгрөг
- Ном, сурах бичиг 67.6.2 сая төгрөг
- Программ хангамж 24.9 сая төгрөг

Нийт үндсэн хөрөнгийн 46.3 тэрбум төгрөг нь цэвэр үндсэн хөрөнгө, 54.5 тэрбум төгрөг нь хуримтлагдсан элэгдэл байна. Үндсэн хөрөнгийн нэмэгдсэн хэмжээг эх үүсвэрээр нь харуулбал:



Зураг 7.3. ШУТИС-ийн 2017 оны шинээр нэмэгдсэн хөрөнгө, эх үүсвэрээр

Нийт өр төлбөр дүнгээрээ 8,820.8 сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулбал 8.9 хувь буюу 719.4 сая төгрөгөөр өсч, эзний өмчийн дүн урьд оноос 2.7 хувь буюу 2,088.2 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 2,957.5 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан бөгөөд урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 15 хувь буюу 375.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.


Өр төлбөрийн бүтэц (сая төгрөгөөр)

Хүснэгт 7.2

Д/д	Балансын зүйл	2016 он		2017 он		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	абсолют	хувь
1	Богино хугацаат өр төлбөр	8,013.8	9.2	8,748.7	9.8	734.9	9.2
2	Урт хугацаат өр төлбөр	87.6	0.1	72.1	0.1	(15.5)	(17.7)
	Өр төлбөрийн дүн	8,101.4	9.3	8,820.8	9.9	719.4	8.9
1	Засгийн газрын сан	23,542.8	27.2	23,542.8	26.3	(0.0)	(0.0)
2	Хуримтлагдсан үр дүн	33,952.6	39.2	37,054.1	41.4	3,101.5	9.1
3	Өмнөх үеийн үр дүн	31,370.2	36.2	34,096.6	38.1	2,726.4	8.7
4	Тайлант үеийн үр дүн	2,582.4	3.0	2,957.5	3.3	375.1	14.5
5	Хөрөнгийн дахин үнэлгээ зөрүү	21,078.3	24.3	20,065.0	22.4	(1,013.3)	(4.8)
	Эзний өмчийн дүн	78,573.7	90.7	80,661.9	90.1	2,088.2	2.7
	Өр төлбөр ба эзний өмчийн дүн	86,675.1	100.0	89,482.7	100.0	2,807.6	3.2

Нийт өр төлбөр, эзний өмч өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.2 хувь буюу 2,807.6 сая төгрөгөөр, нэмэгдэж, 89,482.7 сая төгрөгт хүрчээ. Удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 19 тоот тогтоолын дагуу сургуулиа төгссөн, сургуулиас гарсан, сураггүй алга болсон, бүртгэлийн зөрүүтэй гэх мэт шалтгаантай 6235 оюутны 23,852.3 мян төгрөгийн урьдчилж орсон орлогоос хассан. Өр төлбөр ба эзний өмчийн бүтцийг зургаар доор харуулсан бөгөөд мөнгөн дүнгийн доод хэсэгт урьд оноос өссөн, буурсан хувийг харууллаа. Нийт өр төлбөр 9.9 хувийг, эзний өмч 90.1 %-ийг тус тус эзлэж байна.

Нийт өр төлбөрт: Богино хугацаат өр төлбөрийн нийт хөрөнгөнд эзлэх хувь 9.7 хувь болж, урьд оны мөн үетэй харьцуулбал 0.5 хувиар өссөн байна. Богино хугацаат өр төлбөрт сургалтын төлбөрийн болон оюутны байрны урьдчилж орсон орлогын эзлэх хувь 96.4 хувь болж урьд оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөрт эзлэх хувь 2.5 хувиар нэмэгдсэн байна. Нийт урьдчилж орсон орлого 8,508.7 сая төгрөг болжээ. Сургалтын төлбөрийн болон оюутны байрны урьдчилж орсон орлогоос бусад өглөг нь: ТӨХ-ны 436 тоот тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн “Улаанбаатар Дулааны Сүлжээ”ХК-ий зээлийн хөрөнгөөр бэлтгэсэн халаалтын цогц төхөөрөмжүүдийн төлбөр болох урт хугацаат зээлийн үлдэгдэл (72.1 сая төгрөг), хувь хүн байгууллагат өгөх өглөг 239.1 сая төгрөг байна.



Зураг 7.4. ШУТИС-ийн 2017 оны өр төлбөр, эзний өмчийн бүтэц

Эзний өмчид: Засгийн газрын хувь оролцоо 26.3 хувь, хуримтлагдсан үр дүн 41.4 хувь, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 22.4 хувиар бүрдүүлж байгаа бөгөөд тайлант онд 2,957.5 сая төгрөгт хүрч өмнөх оноос 375.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан.

7.3. ОРЛОГО, ҮР ДҮН

Орлого нь үндсэн үйл ажиллагааны, эрдэм шинжилгээний, оюутны байрны, төсвөөс санхүүжигдэх, бусад орлого гэж ангилагддаг. Орлогын дүнг санхүүгийн тайлангийн Санхүүгийн үр дүнгийн (СТ-2А) тайлангаас авч, тайлант онд үүссэн сургалтын төлбөрийн авлага болон тогтмол зардлын санхүүжилтийн авлагыг хасч, тухайн тайлант хугацааны орлогыг тооцсон.

**Нийт орлого
(сүүлийн 3 жилийн байдлаар, сая төгрөгөөр)**

Хүснэгт 7.3

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх %	2017/2016	Сүүлийн 3 жилийн дундаж
			Төсөв	Гүйцэтгэл	Тоо	Хувь			
Шилжих үлдэгдэл			13,787.7	-					
I.Үндсэн ҮА-ны орлого	38,742.3	36,567.3	32,937.9	35,45 2.9	2,515.0	107.6	70.7	97.0	36,920.8
Сургалтын төлбөр	36,859.7	34,375.0	30,506.3	33,407.9	2,901.6	109.5	66.7	97.2	34,880.9
Түр сургалт	1,882.6	2,192.3	2,431.6	2,045.0	(386.5)	84.1	4.1	93.3	2,040.0
II.Эрдэм шинжилгээ	2,281.1	3,287.1	3,460.5	4,641.9	1,181.4	134.1	9.3	141.2	3,403.4
III.Туслах үйл ажиллагаа	5,620.0	5,507.5	1,880.3	5,151.4	3,271.1	274.0	10.3	93.5	5,426.3
Оюутны байрны орлого	689.2	784.1	812.1	649.1	(163.0)	79.9	1.3	82.8	707.5
Түрээсийн орлого	136.6	116.4	117.9	135.6	17.7	115.0	0.3	116.5	129.5
Бусад орлого	4,794.2	4,607.0	950.3	4,366.7	3,416.4	459.5	8.7	94.8	4,589.3
IV.Төсвөөс санхүүжих	6,009.8	1,635.7	2,140.3	4,875.9	2,735.5	227.8	9.7	298.1	4,173.8
Тайлант үеийн орлого	52,653.2	46,997.6	40,419.1	50,122.2	9,703.0	124.0	100.00	106.6	49,924.3
Нийт орлого			54,206.8				-		-


Тайлант онд нийт орлого 50,122.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, урьд оны мөн үеийн гүйцэтгэлээс 6.6 хувь буюу 3.1 тэрбум төгрөгөөр өсөж, төлөвлөснөөс 24 хувь буюу 9.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад:

- Сургалтын төлбөрийн орлого- 2.8 хувь буюу 967.1 сая төгрөгөөр
- Оюутны байрны орлого -17.2 хувь буюу 135.0 сая төгрөгөөр
- Бусад орлого 5.3 хувь буюу 240.0 сая төгрөгөөр буурч
- Түр сургалтын орлого- 6.7 хувь буюу 147.3 сая төгрөгөөр
- Эрдэм шинжилгээний орлого – 41.2 хувь буюу 1.3 тэрбум төгрөгөөр
- Түрээсийн орлого 16.5 хувь буюу 19.2 сая төгрөгөөр
- Төсвөөс санхүүжих орлого 2.8 дахин буюу 3.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.

Орлогын төсвийг гүйцэтгэлтэй нь харьцуулахад оюутны байрны орлого, түр сургалтын орлогоос бусад орлогын төрлүүдээр орлогын төлөвлөгөө биелэсэн үзүүлэлттэй гарчээ. Тухайлбал: Сургалтын төлбөрийн орлого төлөвлөснөөс 2.9 тэрбум төгрөгөөр давж биелэсэн нь сонголт хийсэн оюутны дундаж кредит нь 33

кредит, мөн шинээр элсэгч оюутны тоо төлөвлөснөөс дунджаар 200 гаруйгаар нэмэгдсэн нь нөлөөлжээ. Эрдэм шинжилгээний орлого төлөвлөснөөс 1.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд бүрэлдэхүүн сургуулиуд хөрөнгөөр болон мөнгөн хөрөнгөөр хийгдсэн ажлууд байгаатай холбоотой юм. Түрээсийн орлого төлөвлөснөөс 17.7 сая төгрөгөөр нэмэгдсэн төрийн өмчийн хорооны тогтоолоор түрээслэх талбайн тариф нэмэгдсэн, мөн шинээр түрээсийн гэрээ байгуулж ажилласантай холбоотой. Бусад орлого төлөвлөснөөс 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 1.9 тэрбум төгрөг нь банкны хүүгийн орлого, ҮТС-629.0 сая төгрөг нь цайны газрын орлого, Эрдэмнэт төв-405.0 сая төгрөгийн орлогууд байна.

Сургуулиудын төсвийн орлогыг гүйцэтгэлтэй нь харьцуулан харуулбал:



Зураг 7.5. ШУТИС-ийн 2017 оны бүрэлдэхүүн нэгжийн орлогын төсөв, гүйцэтгэл

Үүнээс гадна МехТС-64.4 сая төгрөг, МХТС-96.7 (хувь хүн болон байгууллагаас тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном) сая төгрөгийг ойн арга хэмжээгээр, ГУУС-25.0 сая төгрөг, БУХС- 45.6 сая төгрөгийн орлогыг хандиваар бий болгожээ. Мөн зуны сургалт болон оюутны карт хэвлэх, оюутны сонголтын төлбөр гэх мэт оюутны үйлчилгээнээс 270.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Төсвөөс санхүүжих орлого төлөвлөснөөс 2.6 тэрбум төгрөгөөр өсөж гарсан нь БСШУСЯамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ДТС-ийн 2016 онд ашиглалтанд орсон хичээлийн байрны 3.2 тэрбум төгрөг, мөн МехТС, МХТС-ийн оюутны байрны урсгал завсар, ДТС-ийн дулааны узелийн засварын санхүүжилт үндсэн хөрөнгөнд тусгасантай холбоотой. Түр сургалтын орлогын төлөвлөснөөс 386.5 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь Косэн Технологийн дээд сургууль, Ахлах сургуулиудад суралцагчдын тоо буурч сургалтын төлбөрийн орлого нь 50 хувийн гүйцэтгэлтэй гарч тайлант хугацаанд шинээр 132.6 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн нь орлогын төлөвлөгөө тасрах шалтгаан болсон байна.

Тайлант онд ГУУС, ДТС, МехТС, ҮТС-иуд орлогын төлөвлөгөөг биелүүлж, БАС, БУХС, МХТС, ЭХС-иудын орлогын биелэлт 83-98.7 хувьтай байна. Ахлах сургууль, КосенТКоллежийн орлогын биелэлт 50 хувиас доогуур байна. Үндсэн үйл

ажиллагааны орлого нь бакалавр, магистр, доктор, ахлах сургууль болон МСҮТ, Косэн ТДС-ийн сургалтын төлбөр, түр сургалтын орлогоос бүрдэж байна. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого 35,452.9 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 8.2 хувь буюу 2.9 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Сургалтын төлбөрийн орлого(сая төг)

Хүснэгт 7.4

Үзүүлэлт	2016 он	2017 он		Өөрчлөлт/Төсөв		Өөрчлөлт/2016	
		Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Дүн	Хувь	Дүн
1. Сургалтын төрийн сан	790.5	-	800.9		800.9	101.3	10.4
2. Төлбөртэй сургалтын орлого	33,584.5	30,506.3	32,607.0	106.9	2,100.7	97.1	(977.5)
Бакалаврын сургалтын төлбөр	30,388.9	27,844.9	29,594.4	106.3	1,749.5	97.4	(794.5)
Магистрын сургалтын төлбөр	2,829.7	2,361.9	2,670.6	113.1	308.7	94.4	(159.1)
Докторын сургалтын төлбөр	365.9	299.5	342.0	114.2	42.5	93.5	(23.9)
3.Түр сургалтын орлого	2,191.8	2,431.6	2,045.0	84.1	(386.5)	93.3	(146.8)
ОРЛОГЫН ДҮН	36,566.8	32,937.9	35,452.9	107.6	2,901.6	97.0	(1,113.9)

Тайлант онд бакалаврын сургалтын төлбөрийн орлогын төсөв, гүйцэтгэлийг харьцуулан нөлөөлсөн хүчин зүйлийг авч үзвэл: 2016-2017 оны хичээлийн жилийн хаврын улиралд бакалавр оюутан оюутан 262758 кредитийн хичээл, 2017-2018 оны намрын улиралд 241950 кредитийн цагийн хичээл сонгож тайлант жилд нийт 504708 кредит цагийн хичээл сонголт хийжээ. Бакалавр 16788 оюутныг 453276 кредит сонгоно гэж төсөвлөөд 15331 оюутан 504708 кредитийн хичээл сонголт хийж сонголтын зөрүүнээс 2.6 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн орлого нэмэгдсэн байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажил нь “ШУТИС-2021” мастер төлөвлөгөөн дэхь шалгуур үзүүлэлтийн томоохон хэсэг төдийгүй судалгааны их сургууль болоход нэлээд түлхэц үзүүлэх ач холбогдолтой юм. Тайлант онд эрдэм шинжилгээний орлого нь 4.6 тэр бум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.3 хувиар буюу 1.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсөвтэй харьцуулахад 34.1 хувь буюу 1.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд ШУТСангаас 453.0 сая төгрөгийн гэрээт ажил хийж гүйцэтгэсэн байна. ҮТС-182.9 сая төгрөг, ГУУС-117.6 сая төгрөг, ОУДБСТ-54.5 сая төгрөг, ЕНИ-44.6 сая төгрөг, ЭХС-15.3 сая төгрөг, МХТС-13.9 сая төгрөг, БУХС-10.9 сая төгрөг, ХШУС-5.4 сая төгрөгийн төслийн ажил гүйцэтгэсэн байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дээд боловсролын шинэчлэл төслөөс (БАС-340.9 сая төгрөг, ҮТС-151.7 сая төгрөг, ХШУС-17.6 сая төгрөг, МехТС-354.9 сая төгрөг, МХТС-133.3 сая төгрөг, ГУУС-280.9 сая төгрөг, ЭХС-206.9 сая төгрөг, ЭШИГ -364.8 сая төгрөг, ШУТНС-22.9 сая төгрөгийн нийт 1.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө,

үндсэн хөрөнгө, урсгал засварын ажил)-ыг хийж эрдэм шинжилгээний орлогыг нэмэгдүүлсэн байна.

Инженер технологийн дээд боловсрол шинэчлэл төслийн хүрээнд ХШУС-10.0 сая төгрөг, МехТС-2.0 сая төгрөг, МХТС-8.0 сая төгрөг, ЭШИГ-39.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Эрдэм шинжилгээний орлогын нийт орлогод эзлэх хувь өнгөрсөн оноос 2.2 пунктээр нэмэгдсэн байна. Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн ажлууд нь эрдэм шинжилгээний орлогын 40 гаруй хувийг бүрдүүлж байгаа болно.

**Эрдэм шинжилгээний орлого
(сая төгрөгөөр)**

Хүснэгт 7.5

Орлогын төрөл	2015 он	2016 он	2017 он		Өөрчлөлт/төсөв	
			Төсөв	Гүйцэтгэл	Тоогоор	Хувиар
Эрдэм шинжилгээний орлого	2,281.1	3,287.1	3,460.5	4,641.9	1,181.4	134.1
Нийт орлогод эрдэм шинжилгээний эзлэх %	4.2	7.1	6.5	9.3	2.8	143.1

Туслах үйл ажиллагааны орлогод түрээсийн, хүүгийн, оюутны үйлчилгээний, хандивын, үйлдвэрлэл үйлчилгээний болон бусад орлогыг оруулж тооцсон бөгөөд орлогын гүйцэтгэл 5,151.4 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 2.2 дахин давж биелжээ. Харин урьд оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 1 хувь буюу 50. сая төгрөгөөр өссөн байна.

**Туслах үйл ажиллагааны орлогын төсөв, гүйцэтгэл дэлгэрэнгүй
(сая төгрөгөөр)**

Хүснэгт 7.6

Үзүүлэлт	2016 он	2017 он		Өөрчлөлт төсвөөс		Өөрчлөлт өмнөх он	
		Төсөв	Гүйцэтгэл	Харьцангуй	Абсолют	Харьцангуй	Абсолют
Түрээсийн орлого	116.4	156.8	135.6	86.5	(21.2)	16.5	19.2
Оюутны байрны орлого	784.1	812.1	649.1	79.9	(163.0)	82.8	(135.0)
Хүүгийн орлого	1,680.4		1,911.8		1,911.8	13.8	231.4
Оюутны үйлчилгээ орлого	190.1		270.1		270.1	42.1	80.0
Хандивын орлого	714.8	125.0	353.0	282.4	228.0	49.4	(361.8)
Үйлдвэрлэл үйлчилгээ	1,246.4	435.5	1,574.9	361.6	1,139.4	26.4	328.5
Бусад орлого	368.6	739.8	257.0	34.7	(482.8)	39.7	(111.6)
Туслах үйл ажиллагааны орлого	5,100.8	2,269.2	5,151.4	227.0	2,882.3	101.0	50.6

Түрээсийн орлогод ШУТИС-д 20 гаруй аж ахуйн нэгж, хувь хүнд цайны газар, талбай, граж түрээслүүлдэг. Төрийн өмчийн хорооны тогтоолоор түрээсийн м.кв-ын үнэ 2016 онд өссөн. Энэхүү тарифаар бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд түрээсийн үнэ ханшийг мөрдлөг болгон төсөвлөсөн хэдий түрээслэгч газруудад ТӨБЗГ-аас хэрэгжүүлж буй дүрэм журмаар түрээслэгч газрууд төрийн санд 3 сарын түрээсийн төлбөртэй тэнцэхүйц мөнгийг байршуулах, түрээсийн тендерт ялахын тулд үндэслэлгүй үнийг санал тавьж тендерт ялж түрээсээ төлж чадахгүйд хүрсэн зэрэг шалтгааны улмаас энэнхүү орлого тасарчээ. Оюутны байрны орлогод МехТС, МХТС, ДТС-иудын оюутны байрны оюутны тоо дутуу, өрөөний дүүргэлт дутуугаас оюутны байрны орлого тасарсан. Хүүгийн орлогод ШУТИС-ийн арилжааны банканд байгаа харилцах дансны үлдэгдэлд олгосон хүү 1.9 тэрбум төгрөг. Хандивын орлогод БАС-7.0, БУХС-45.6 сая төгрөг, ГУУС-25.0 сая төгрөг, МехТС-64.0 сая төгрөг, МХТС-96.7 сая төгрөг, ҮТС-50.0 сая төгрөг, ХШУС-35.0 сая төгрөгийн хандивын орлогыг бүрдүүлж ажилласан байна. Үйлдвэрлэл үйлчилгээний орлогод ҮТС-иас цайны газрын орлого 629.6 сая төгрөг, Эрдэмнэт төвийн үйл ажиллагааны орлого 407.0 сая төгрөг, ХГазар-328.0 сая төгрөг, ЭХС-62.3 сая төгрөг, МХТС-32.2 сая төгрөг, МехТС-40.0 сая төгрөг гэх мэт. Бусад орлогод Бүрэлдэхүүн сургуулийн бусад орлогод хурлын заалны төлбөр, дромын төлбөр, багш нарын хичээл таслалт, горхийн полигоны айлуудаас орсон төлбөр, түрээсийн гэрээтэй газруудын цахилгааны төлбөр гэх мэт орлогууд багтсан.

Төсвөөс санхүүжсэн орлогын төсөв, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Хүснэгт 7.7

Үзүүлэлт	2016 он	2017 он		Өөрчлөлт төсвөөс		Өөрчлөлт өмнөх он	
		Төсөв	Гүйцэтгэл	Харьцангуй	Абсолют	Харьцангуй	Абсолют
Тогтмол зардал санхүү	624.7	1,559.5	419.1	26.9	(1,140.4)	67.1	(205.6)
Лицейн хувьсах зардлын санхүүжилт	204.7	150.6	176.5	117.2	25.9	86.2	(28.2)
МСҮТ-ийн санхүүжилт	303.2	249.2	279.7	112.2	30.5	92.2	(23.5)
Хөрөнгө оруулалт	372.5	-	3,856.5		3,856.5	1,035.3	3,484.0
Оюутны унаа хөнгөлөлт	133.6	153.3	144.0	94.0	(9.2)	107.8	10.4
Төсвөөс санхүүжсэн орлого	1,638.7	2,112.6	4,875.9	230.8	2,763.3	297.5	3,237.2

Тайлант онд төсвөөс санхүүжигдэх орлого нь төлөвлөснөөс 2.3 дахин нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн урсгал засварын ажлууд болон ДТС-ийн хичээлийн байрыг данс бүртгэлд тусгасантай холбоотой юм. Тайлант онд улсын төсвөөс тогтмол зардлын санхүүжилтэнд 966.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс тайлант хугацаанд шинээр үүсгэсэн тогтмол зардлын авлагыг хассанаар 419.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ. МСҮТөвийн суралцагчийн хувьсах зардал, АСургууль, Косэн Технологийн коллежийн суралцагчийн хувьсах зардалд 455.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

ШУТИС-ийн орлогын динамик
(сүүлийн 10 жилээр, сая төгрөгөөр)

Хүснэгт 7.8

Онууд	Орлогын гүйцэтгэл (сая.төг)	Харьцангуй өсөлт (%)	Абсолют цэвэр өсөлт (сая.төг)	Суурь өсөлтийн коэффициент 2006	Хэлхээ өсөлтийн коэффициент	Цэвэр өсөлт 1 %-д ногдох орлого
2007	11,765.8					
2008	15,296.1	30.0	3,530.3	1.3	1.30	117.7
2009	21,799.1	42.5	6,503.0	1.9	1.43	153.0
2010	27,208.3	24.8	5,409.2	2.3	1.25	218.0
2011	32,951.3	21.1	5,743.0	2.8	1.21	272.1
2012	38,415.5	16.6	5,464.2	3.3	1.17	329.5
2013	45,319.3	18.0	6,903.8	3.9	1.18	384.2
2014	50,121.1	10.6	4,801.8	4.3	1.11	453.2
2015	52,653.2	5.1	2,532.1	4.5	1.05	501.2
2016	46,613.7	-11.5	(6,039.5)	4.0	0.89	526.5
2017	50,122.0	7.5	3,508.3	4.3	1.08	466.1
Дундаж	35,660.5	16.5	3,835.6	3.2	1.2	342.1

ШУТИС 2007-2017 оны хооронд жилд дунджаар 35.7 тэр бум төгрөгийн орлого бүрдүүлж, жил тутам дунджаар 3.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Орлого өнгөрсөн оноос 7.5%-иар буюу 3.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан байна. Орлогын өсөлт 1 хувиар нэмэгдэхэд жилийн дундаж орлого 342.1 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

7.4. ЗАРЛАГА, ҮР ДҮН

Тайлант онд төсвийн зардлын гүйцэтгэл 44,043.7 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 7,805.4 сая төгрөгөөр дутуу, 84.9%-ийн гүйцэтгэлтэй гарч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 0.7 хувь буюу 0.3 сая төгрөгөөр буурчээ. Нийт зардлын 83.7 хувийг сургалтын үйл ажиллагааны зардалд, 7.0 хувийг төсөл, гэрээт ажлын зардалд, 1.2 хувийг оюутны байрны зардалд, 3.2 хувийг МСҮТөв, ахлах сургуульд, 1.3 хувийг түр сургалт, 3.5 хувийг үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд тус тус зарцуулсан байна.

2017 оны зардлын төсөв, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Хүснэгт 7.9


Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он		Урьд оноос		Төсвөөс	
			Төсөв	Гүйцэтгэл	Харьцангуй	Абсолют	Харьцангуй	Абсолют
I. Сургалттай холбоо шууд зардал	32,931.3	32,133.0	35,096.9	31,405.8	97.7	727.2	89.5	3,691.1
II. Шууд бус зардал	11,350.7	10,963.1	11,104.9	11,241.4	102.5	(278.3)	101.2	(136.4)

III. Оюутны үйлчилгээний зардал	744.0	457.6	572.4	480.7	105.0	(23.1)	84.0	91.7
IV. Инновацийн үйл ажиллагаа	7.5	19.0	55.0	3.1	16.4	15.9	5.7	51.9
V. Хөрөнгө оруулалт	1,082.6	782.6	5,019.6	912.8	116.6	(130.2)	18.2	4,106.8
Нийт зардал	46,116.1	44,355.3	51,848.8	44,043.7	99.3	311.6	84.9	7,805.1

Бүтцээр урьд оны гүйцэтгэлтэй харьцуулан авч үзвэл сургалттай холбоотой шууд зардал 727.2 сая төгрөгөөр, инновацийн үйл ажиллагааны зардал 15.9 сая төгрөгөөр буурч, шууд бус зардал 278.3 сая төгрөгөөр, оюутны үйлчилгээний зардал 23.1 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардал 130.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан байна. Батлагдсан төсөвтэй харьцуулбал сургалттай холбоотой шууд зардал 3,691.1 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарч үүний дотор:

- Цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 2.2 тэрбум төгрөг
- Хичээл практикийн зардал 549.0 сая төгрөг
- Ном хэвлэлийн зардал 191.3 сая төгрөг
- Эрдэм шинжилгээний зардал 395.0 сая төгрөг
- Багшийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх зардлууд 196.4 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сургууль тус бүрээр харуулбал:



Зураг 7.6. ШУТИС-ийн 2017 оны бүрэлдэхүүн нэгжийн зарлагын төсөв, гүйцэтгэл


Шууд бус зардал 136.4 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй гарсан байна. Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн шууд бус зардлын ихэнх зардлууд нь төсвөөс хэтрээгүй гүйцэтгэлтэй гарсан боловч МехТС-ийн МСУТөвийн суралцагчдын хоолны зардал 12.0 сая төгрөгөөр, УТС-ийн бусад зардал 569.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Бусад зардлын дүнд Эрдэмнэт төвийн 308.0 сая төгрөг орсон болно. Оюутны үйлчилгээний зардал 91.7 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан. Инновацийн зардал төсөвлөсөн хэмжээнээс 51.9 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан нь төлөвлөсөн ажил хийгдээгүйтэй холбоотой байна. Бүрэлдэхүүн сургуулиудын хувьд тэвчиж болох зардлуудыг хойшлуулж, зардлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлснээр зардлаа нийт дүнгээр нь хэтрүүлсэн сургууль, нэгж байхгүй болно. Сургалттай холбоотой зардлын гүйцэтгэл 31.4 тэрбум төгрөг гарч төлөвлөснөөс 3.6 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Үүний 2.2 тэрбум төгрөг нь сургалттай холбоотой шууд зардлын цалин, НДШ-ийн зардал, 549.3 сая төгрөг нь хичээл практикийн зардал, 395.8 сая төгрөг нь эрдэм шинжилгээний зардал байна. Сургалттай холбоотой шууд зардлын 74.3 хувийг багш, цагийн багш, сургалтын албаны ажилтан, хичээлийн туслах ажилтны үндсэн болон нэмэгдэл цалин, илүү цагийн хөлс эзлэж байна. Үүнд ШУТАС, КООСЭН багтсан үзүүлэлт юм.

**Сургалттай холбоотой шууд зардал
(сая төгрөгөөр)**

Хүснэгт 7.10

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он		Урьд оноос		Төсвөөс	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Харьцангуй	Абсолют	Харьцангуй	Абсолют
Цалин нэмэгдэл	24,131.7	24,020.3	25,596.7	23,391.7	97.4	628.6	91.4	2,205.0
Хичээл практик зардал	3,079.0	2,403.3	2,756.0	2,206.3	91.8	197.0	80.1	549.7
Ном хэвлэл	303.2	303.5	521.3	330.0	108.7	(26.5)	63.3	191.3
Томилолт	66.2	43.1	64.4	43.3	100.5	(0.2)	67.2	21.1
ЭШЗардал	3,532.1	3,207.2	3,942.3	3,546.5	110.6	(339.3)	90.0	395.8
Багшийг дэмжих зардал	365.3	557.4	465.7	326.2	58.5	231.2	70.1	139.4
Мэргэжил дээшлүүлэх	218.0	164.2	238.3	181.3	110.4	(17.1)	76.1	57.0
Тогтмол зардал	1,235.9	1,433.9	1,512.1	1,380.4	96.3	53.5	91.3	131.7
Сургалттай холбоотой шууд зардлын дүн	32,931.4	32,132.9	35,096.9	31,405.8	97.7	727.1	89.5	3,691.1



Зураг 7.7. ШУТИС-ийн 2017 оны сургалттай холбоотой шууд зардал

Сургалттай холбоотой цалин, нэмэгдэл, шимтгэлийн зардал 23.4 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 8.6 хувиар буюу 2.2 тэрбум төгрөгөөр дутуу, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 2.6 хувиар буюу 628.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Хичээл практикийн зардал 2.2 тэрбум төгрөгт хүрч, урьд оны гүйцэтгэлээс 8.2 хувь буюу 197.0 сая төгрөгөөр, төсвөөс 19.9 хувь буюу 549.7 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Хичээл практикийн зардал 187.7 сая төгрөг, сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардал 122.2 сая төгрөг, дадлагын зардал 92.9 сая төгрөг, сургалтын бичиг хэргийн зардал 40.4 сая төгрөг, интернетийн зардал 64.9 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Ном хэвлэлийн зардалд 330.0 сая төгрөг зарцуулсан нь төлөвлөснөөс 36.7 хувь буюу 191.3 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан байна. Эрдэм шинжилгээний зардал нь өнгөрсөн оны мөн үеэс 339.3 сая төгрөгөөр, төсвөөс 395.8 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Тайлант онд БАС-23, БУХС-9, ГУУС-57, ДТС-2, МехТС-13, МХТС-17, ХШУС-10, УТС-22, ЭХС-25, ЕНИ-3, ЭШИГ-10 гэрээт, төсөл, дээд боловсролын шинэчлэл төслүүдээр эрдэм шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Бүрэлдэхүүний сургуулиудын хийж гүйцэтгэсэн төсөл, гэрээт ажлын хэмжээгээр зардал нь зарцуулалт хийгддэг. Энэхүү зардлын дийлэнх хэсэг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулагддаг. Тайлант онд эрдэм шинжилгээний зардал 3,546.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ. Үүний 77.1 хувийг гэрээт ажил, төслийн ажлын зардалд, 11.6 хувийг сургалтын зориулалттай эрдэм шинжилгээний хурал, семинар, эрдэм шинжилгээний ном товхимол хэвлүүлэхэд, 8.6 хувийг түр сургалтын эрдэм шинжилгээний зардалд тус тус зарцуулсан байна.

Тайлант онд багш нарын мэргэжил дээшлүүлэх багшийн дэмжих зардалд 704.0 сая төгрөгийг төсөвлөж гүйцэтгэл 507.0 сая төгрөг гарчээ. Төлөвлөснөөс 28.4 хувь буюу 197.0 сая төгрөгөөр дутуу, урьд оноос 214.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ.

ШУТИС-ийн 2017 оны мэргэжил дээшлүүлэх, багшийг дэмжих зардал*Хүснэгт 7.11*

Зориулалт	Хамрагдсан хүний тоо	Зардлын дүн /сая.төг/
Дотоодод докторант, магистрын сургалтын төлбөр	18	15.9
Залуу эрдэмтдийн хурал, чуулган		18.5
- Захирлын 2017 оны 10-р сарын 03-ны өдрийн А/177 тоот тушаалаар байгуулагдсан комиссын гишүүнээр Газар, үл хөдлөх хөрөнгийн тооллогыг удирдамжын дагуу гүйцэтгэсэн. Газар, Үл хөдлөх хөрөнгийн тооллогын тайлан боловсруулсан ба УБ хот дотор, Налайх дүүрэг, Тэрэлж, Дархан уул аймаг, Хэнтий аймаг зэрэг ШУТИС-ийн эзэмшиж буй нийт 21 газар, 110 барилга байгууламж хамрагдлаа. Уг тооллого үзлэгийн дүнг Захирлын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн үүнтэй холбогдуулан 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 5/770 тоот албан даалгаврыг бүрэлдэхүүн сургуулиудад хүргүүлэн 2018 оны 01 дүгээр сард холбогдох ажлын явцыг, 2018 оны 05 дугаар сард ажлын тайланг бүрэлдэхүүн тус бүрээс албан бичгээр хүлээн авч тайланг нэгтгэсэн болно.
- Бүрэлдэхүүн сургуулиудын актлах үндсэн хөрөнгийг нэгтгэн, ТӨБЗГазрын хариуцсан албан тушаалтанд үндсэн хөрөнгийг актлах зөвшөөрөл хүсэн, ТӨБЗГазрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн №534 тогтоолоор аклах зөвшөөрөл авсан. Уг тогтоолыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулиудын үндсэн хөрөнгийг актлаж, данснаас хассан /биелэлт/ тухай албан бичгийг хүлээн авч материалуудыг архивлав. Тус тогтоолын биелэлтыг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан ТӨБЗГ-т хүргүүлсэн болно.

7.12. БАЙР АШИГЛАЛТ

ШУТИС-ийн байр ашиглалтын нэгдсэн алба нь 2017-2018 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн “ШУТИС-ийн захиргааны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн №12 тоот тогтоолын дагуу албаны дарга, инженер техникийн ажилтан, слесерь,

үйлчлэгч, мужаан, цахилгаанчин гэсэн 24 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Байр ашиглалтын нэгдсэн алба нь Дээд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулиуд, Улсын их хурал, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагын тогтоол, тушаал, стандарт, ШУТИС-ийн дүрэм, журмуудыг мөрдөн ажиллалаа.

Тус албаны хүрээнд барилга байгууламжийн ашиглалтанд хяналт тавих, их болон урсгал засварын ажлыг төлөвлөгөөний дагуу хийлгэх, хяналт тавих, орчны/гадаад, дотоод/ тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах, дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих, өмч хөрөнгийг үр ашигтай зарцуулах, цайны газруудын болон түрээслэгчдийн түрээсийн гэрээний биелэлтэнд хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

Тайлангийн хугацаанд сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах орчин, нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр дараах ажил үйлчилгээг үзүүлэв.

- БСШУС-ын сайдын 2017оны 08 дугаар сарын 01-ний “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/102 тоот тушаалын хэрэгжилтийг зуны засвар тохижилтын ажилтай уялдуулж ажилласнаар сургалтын үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн үргэлжиллээ.
- Монгол улсын засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 тоот албан даалгаврыг албаныхаа ажилтан, ажилтдад сурталчлаж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.
- ШУТИС-ийн захирлын 2017 оны 10 дугаар сарын 03-ны “Газар, үл хөдлөх хөрөнгийн тооллого явуулах тухай” А/177 тоот тушаалын биелэлтэнд онцгой анхаарч ШУТИС-ийн өөрийн эзэмшлийн барилга байгууламжийн хаяг, байршил, кадастрын зураг, газрын гэрээ, гэрчилгээнд хаягийн тодотгол хийх, газартай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг бүрдүүлэх, нягтлах, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн план зургуудыг хийлгэх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Мөн барилга байгууламж болон ашиглалтын байдалтай нэг бүрчлэн биечлэн танилцлаа.
- Зуны засвар тохижилтын ажлын тухай, ШУТИС-ийн оюутны III байранд байгуулах “60 хүүхдийн цэцэрлэг”-ийн төсөвт өртгийн тооцооны тухай, “Шинжлэх ухааны парк-Биотехнологи”-ийг балансаас балансад шилжүүлэх ажлын явцын тухай зэрэг асуудлуудыг захирлын зөвлөлд танилцуулж холбогдох заавар, зөвлөмж, шийдвэрүүдийг гаргуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаа.
- Хичээлийн шинэ жил, өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор зуны засвар тохижилтын ажлын календарчилсан төлөвлөгөө гарган мөрдөн ажиллаж байна. Хичээлийн болон оюутны байрнуудын сантехникийн найдвартай ажиллагааг хангах үүднээс халаалтын улирал дуусмагц инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж илэрсэн доголдлыг засварлах ажлыг зохион байгууллаа. Тайлант онд элэгдэлд орсон 239у/м шугам хоолойг хэсэгчлэн шинэчлэж, задвижен хаалт винтель 28 ширхгийг шинээр сольжээ. Мөн насос бш, бойлерь 2ш-ийг задалж цэвэрлэн, МехТС-ийн сантехникийн системийг иж бүрэн угаалгав. Хичээлийн I,II,III байр

орчмын гадна ариутгах татуургын 200 гаруй у/м шугамыг улирал тутам угааж, 15ш худгийг лайдаж цэвэрлэжээ. Хичээлийн I байрны I давхрын урд жигүүрийн ариун цэврийн өрөөний хуучирч элэгдэлд орсон сангийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэн сольлоо. БуХС-ийн хичээлийн байрны А блокын халаалтын системийг өөрчлөн шинэчлэв. Горхи дахь сургалтын полигоны ариун цэврийн байгууламжийг ашиглалтанд орууллаа. Угаалтуур, суултуур, босоо шугам, гадна худаг бөглөрсөн 184, холбох хэрэгслээс ус алдсан 110, халаалтын шугам, халаах хэрэгслээс ус алдсан 97, шугам хоолой цоорсон 4 дуудлагыг хүлээн авч цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж ажиллаа.

- ШУТТНС, хичээлийн II байрны нийт 5ш цахилгаан шатны аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хариуцан техникийн үзлэг, үйлчилгээг гэрээт байгууллагаар хийлгэж гэрээний биелэлтэнд хяналт тавин ажиллав.
- Хичээлийн I,II,III,IV байр, ШУТТНС-ийн хотын болон дотуур утас, станц, шугам аппаратын найдвартай ажиллагааг ханган, лавлагаа мэдээлэл, засвар үйлчилгээг хариуцан ажиллаа.Тайлант хугацаанд хэрэглэгчийн хүсэлтээр ОУДБС-ын төвийн гадуур, дотуур утас,ХОХГ-т шинээр хотын холбооны утас,чанарын хяналт, шинжилгээ үнэлгээний алба, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн алба,соёмбо клуб, хичээлийн I байрны харуул, ГУУС, ГХИ-д дотуур холбооны утсыг шинээр тавьж, 10 дугаарыг салаалж, шилжүүлэг хийв.
- Хичээлийн болон оюутны байрны цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хариуцан цахилгаан системийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Цахилгааны ерөнхий щитэнд техникийн үзлэгийг сар бүр тогтмол хийж осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. Үүний үр дүнд хичээлийн I байрны хойд жигүүрт 380В-ийн босоо шугам аваарын нөхцөлд байсныг илрүүлж шуурхай арга хэмжээ авч засвар үйлчилгээ хийснээр хэвийн ажиллагааны горимд оруулжээ. Тайлант онд разетка, унтраалга, гэрэл солих, цахилгаан хэрэгсэл суурьлуулах, тэжээл татах, сургуулийн гадна орчинд зохиогддог арга хэмжээний үеэр цахилгаан тэжээл татах зэрэг ажлуудыг ямар нэг гомдол чирэгдэлгүй гүйцэтгэж ажилласан байна. Мөн түрээсэлж байгаа талбайн цахилгаан хэрэгсэлд тусад нь тоолуур зүүж цахилгааны өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулжээ. Горхи дахь сургалтын полигоны ариун цэврийн байгууламжийн газардуулгын ажлыг хийлээ.
- “ШУТИС-ийн 2018 оны хамтын гэрээ”-ний ХАБЭА-н нөхцөл бүлэгт тусгагдсан зүйл заалтын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Эрүүл мэнд, спортын төвтэй хамтран үйлчлэгч нарт “Халдварт өвчин, ариутгал”, “Сургуулийн орчны цэвэрлэгээ, халдваргүйтэл” сэдвүүдээр сургалт явуулав. Хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнүүдийн биелэлтэнд хяналт тавьлаа.Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавьж, мэрэгч устгалын ажлыг гэрээний дагуу зохион байгуулав. Оюутны соёл үйлчилгээний алба, Эрүүл мэнд, спортын төвтэй хамтран Оюутны байрны орчинд нэгдсэн шалгалтыг хийж, авч хэрэгжүүлэх ажил үүргийг байр тус бүрээр гарган холбогдох бүрэлдэхүүн сургуулиудад зөвлөмж хүргүүлэн ажиллаа.
- “Соргог” ХХК, “Дорнод монгол эрдэс” ХХК-ийн Дорнод монгол секьюрити байгууллагуудтай харуул хамгаалалтын чиглэлээр гэрээтэй ажиллаж байна.

Харуулын албаны ахлагч нартай байнгын холбоотой ажиллаж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг анхааруулж холбогдох үүрэг даалгаврыг өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Мөн дээрх байгууллагуудын ажлын тайланг бичгээр авч үнэлгээ хийж байна.

- Хичээлийн I, II байр орчмын авто зогсоолд байрлах автомашины бүртгэл, судалгааг гаргаж, автомашин нэвтрүүлэх зөшөөрлийн картыг захиалан хийлгэж 678 ш-ийг автомашин эзэмшигчдэд олголоо.
- Нийтийн эзэмшлийн зам талбай, орчны их цэвэрлэгээг улирал тутам зохион байгууллаа.
- Тайлант онд хичээлийн VI байр, оюутны IV байрны гадна дулааны болон цэвэр усны шугамыг шинэчлэх, хичээлийн VI байрны Б корпусын дээвэр, хичээлийн V байрны дадлагын байрны дээвэр, хичээлийн II байрны блок-А хэсгийн хүзүүвчний дээвэр, спорт заал, горхи дахь дадлагын полигоны БАС, ШУТАС, захиргааны байрууд, ариун цэврийн байгууламж, хичээлийн I, II байрны узелийн өрөө, мэргэжилтний байрны №6,7 тоот өрөө, II байрны блок А-хэсгийн зоорийн давхрын болон хүзүүвчний коридор, блок Б-хэсгийн хагас зоорийн дотор коридор, урлаг заалны арын бэлтгэлийн өрөө болон захиргаа, бүрэлдэхүүн сургуулиудын нийт 56 анги, танхим, лабораторийн засварын ажлын даалгаврыг боловсруулж ХОХГ-т хүргүүлэн ажиллаа.



НАЙМДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

НАЙМ. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ШУТИС-ийн захирлын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн тушаалаар Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний албыг албаны дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний 3 орон тоотойгоор байгуулж, албаны үндсэн чиг үүргийг тодорхойлж 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан Хяналт, шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирлааар батлуулсан.

8.1. ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

8.1.1. Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлыг 2017/2018 оны хичээлийн жилд хийж гүйцэтгэлээ. Үүнд: Их сургуулийн үйл ажиллагаанд чанарын менежментийн ISO 9001:2015 тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд одоогийн нөхцөл байдлыг үнэлэн цаашид хийх сайжруулалтыг төлөвлөхөд шаардлагатай орцын мэдээллийг цуглуулах ажил хийгдсэн байна. Үүнд:

- А.** Олон улсын баталгаажуулалтын IRCLASS Systems and Solutions Pvt. Ltd байгууллагын төлөөлөгчдийг урьж, **“Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх нь”** сэдвээр танилцуулга, сургалтыг 2018 оны 4 дүгээр сарын 05-нд зохион байгуулсан. Уг сургалтанд ШУТИС-ийн 16 удирдах албан тушаалтан хамрагдсан.



Зураг 8.1. “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх нь” сэдэвт семинари

Сургалтаар ISO 9001:2015 стандартын ойлголт, үйл ажиллагаанд стандартын нэвтрүүлэх ач холбогдол, ЧМТ-ны хамрах хүрээг хэрхэн тодорхойлох тухай, чанарын удирдлагын энэхүү тогтолцоог хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлэх талаар санал солилцов.

- В.** Одоо мөрдөгдөж буй дүрэм, журамд үйл явцын аргад үндэслэн дүн шинжилгээ хийсэн.
- С.** Их сургуулийн 1119 ажилтнаас “Уур амьсгалын судалгаа”-ыг удирдлага ажиллагсад хоорондын харилцаа холбоо, ажиллагсад ажлын байран

дээрээ хөгжих боломж, мөн газар, алба, салбар, нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо үр дүнтэй явагддаг эсэх, шинэ санаа санаачлагыг удирдлагын зүгээс дэмждэг эсэх, ажиллагсад өөрсдийн ажилдаа сэтгэл ханамжтай байдаг зэрэг асуудлуудыг тодорхойлох зорилгоор цаасаар болон удирдлагын мэдээллийн систем ашиглан явуулсан.

- D.** Захиргааны газар албад, бүрэлдэхүүн сургуулиудын удирдлагуудтай ярилцах хэлбэрээр одоогийн удирдлагын тогтолцоог ISO 9001 стандартын шаардлага болоод мөрдөж байгаа чиг үүрэгтэй харьцуулан үнэлж, зөрүүний шинжилгээ хийсэн.

8.1.2. Удирдлагын мэдээллийн системээс Чанарын тоон үзүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээний мэдээ, тайлан гарах боломжийн судалгаа.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн удирдлагын мэдээллийн систем болох Cloud UNiMIS системийн 15 модуль хоорондын хамаарлын диаграмыг гаргаж дүн шинжилгээ хийсэн (зураг 10.2).

Судалсан мэдээлэлд үндэслэн бид систем хөгжүүлэлтийн нэмэлт шаардлагыг тодорхойлж байна.

8.1.3. Хяналтын камерийн үйл ажиллагааг судалсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болоод сургалтын орчны аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Хичээлийн I, II, III байр, Номын сангийн хяналтын камерын үйл ажиллагаа, түүний хүчин чадлын байдлыг судалж, цаашид авах арга хэмжээ сайжруулах саналыг гаргасан. Уг саналд үндэслэн шаардлагатай хэсэгт нэмэлт камерыг хэсэгчлэн тавихаар төлөвлөж байна.

8.1.4. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институт, хүрээлэнгийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, тайланг хэлэлцүүлсэн.

ШУТИС-ийн Хяналт шинжилгээ үнэлгээ эрхэлсэн дэд захирлын 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ЗХНГ-тай хамтран ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институт, хүрээлэнгийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс 4 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд хяналт шалгалт хийсэн байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, ШУТИС-ийн захирлын тушаал шийдвэрийн биелэлт хэрэгжилтэнд дүгнэлт өгөх зорилгоор ШУТИС-ийн төв архив, 9 бүрэлдэхүүн сургууль, 2 институт, 3 хүрээлэн, ШУТИС-ийн харьяа ЕБАС, Коосэн Технологийн коллежийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл үйл ажиллагааг шалгаж, сургуулийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд илэрсэн зарим алдаа дутагдлыг газар дээр нь засуулж, арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулж тайланг 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдөр ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн болно.

8.1.5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил явагдсан.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, захиргаа, санхүүгийн үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод нээлттэй явуулах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран 2018 оны “Авлигын

эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлэн ажилласан байна. 2018 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан багш оюутнуудад авлигын хууль тогтоомжийг сурталчилах, энэ талаарх мэдээллийг түгээх ажлын хүрээнд сургуулийн профессор багш, ажилтан, оюутан суралцагчдад авлигын эсрэг хууль, тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг сургуулийн дотоод сүлжээ, мэдээллийн самбар, нийт профессор багш ажилтан ажилчдын хурал, цуглаан, захирлын зөвлөлийн хурал зэргээр дамжуулан мэдээлэл өгч ажилласан.

Авлигатай тэмцэх газраас 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр 4 төрлийн сурталчилгааны зурагт хуудас /шударга нийгмийн төлөө хамтдаа, мэдүүлэг гаргагч таньд, ХАСХОМ, Албан тушаалтан/ авч бүрэлдэхүүн 12 сургууль, 2 институт, 4 хүрээлэнд тарааж, багш оюутнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчих энэ талаарх мэдээллийг түгээх ажлыг зохион байгууллаа.



Зураг 8.2. Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн мэдээллийн самбараас оюутнуудад мэдээлэл авч байгаа нь



Зураг 8.3. Дулаан техник үйлдвэр экологийн хүрээлэнгийн захирал Б.Жаргалсайхан ажилтан ажилчдад мэдээлэл өгч байгаа нь

Сургуулийн цахим хуудсанд Авлигатай тэмцэх газрын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмын холбогдох баннерыг байрлуулсан. Ийнхүү АТГ-ын цахим хуудас, Мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системийг холбосноор тус байгууллагын цахим хуудсанд хандсан хэрэглэгчид авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулан сурталчлах хялбар боломж бий болсон. 2017-2018 оны хичээлийн жилийн оюутны нэгдсэн хуанлид тусгагдсаны дагуу “Транспэрэнси интернэйшл Монгол” олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх Монгол залуусын оролцоо” төслийн хүрээнд ШУТИС-ийн Оюутны хөгжил, соёл үйлчилгээний албатай хамтран оюутан суралцагчдад 2 удаа тус бүр 60 минутын сургалтыг зохион байгуулж, ШУТИС-ийн 190 гаруй оюутан суралцагчийг хамруулсан.



Зураг 8.4. “Авлигатай тэтгэх Монгол залуусын оролцоо” сургалт

Энэхүү сургалтаар авлигал нийгэмд хэрхэн нөлөөлж байна Авлигалын төсөөллийн индексийн талаарх болон нийгмийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, залуусын оролцоо гэсэн сэдвээр мэдээлэл өгч сургалт зохион байгуулсан.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухайн бүр АТГ-т хүргүүлж, лавлагаа авч асуудлыг шийдвэрлэж ажилласан. ШУТИС-ийн хэмжээнд 2017 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг 2018 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр гарган Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан Спортын Яаманд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Тайлант жилийн 2 дугаар сарын 15-ны дотор /хуулийн хугацаанд/ сургуулийн мэдүүлэг гаргагч 67 албан тушаалтнуудын 2017 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргаж, мэдүүлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж, 100% хамруулсан.

Улмаар хуулийн хугацаанд багтааж 2017 оны мэдэгдэл, мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээ, тайланг гарган Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан Спортын Яаманд хүргүүлсэн. 2017 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргаагүй, хууль зөрчсөн асуудал гараагүй. Он гарснаар шинээр удирдах албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 8 нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСХУМ/, материалыг АТГ-аар хянуулах ажлыг зохион байгуулж, холбогдох дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж, томилогдсноос хойш хуулийн хугацаанд багтаан дээрх албан тушаалтнуудын 2017 оны ХАСХОМ-ыг гаргуулах ажлыг зохион байгуулсан.

2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хяналт шалгалт хийх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон ажилтан ажилчдаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх 35 мэдэгдлийг сургуулийн ЭБАТ-д хүлээн авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүртгэж байна. 2017 оны мэдүүлэг, мэдэгдэл цаасан сууриар болон мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүрэн бүртгэгдэн хууль, журмын дагуу хадгалагдаж байна. Мөн 2017 оны ЭБАТ-ын бүртгэлүүд цаасан болон цахим системийн бүртгэлүүд бүрэн хийгдсэн болно.

8.2. АЛБАНЫ АЖИЛЛАГСАД МЭРГЭЖИЛ МЭДЛЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛСЭН.

Тайлант хугацаанд мэргэжил арга зүйн сургалтанд хамрагдсан байна. Үүнд:

- БМИҮЗ-ээс 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан **"Чанарын соёл-Чанарын дотоод баталгаажуулалт"** Олон улсын хуралд албаны нийт бүрэлдэхүүнээр оролцож, бусад их дээд сургуулиудын туршлагатай танилцсан.

- АМУ Консалтинг ХХК олон улсын баталгаажуулалтын IRCLASS Systems and Solutions Pvt. Ltd байгууллагаас 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан **Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага ISO 9001:2008 –аас ISO 9001:2015 стандартад шилжих** төслийн танилцуулах арга хэмжээнд оролцсон. Арга хэмжээний үеэр ISO 9001:2008 өөрчлөгдөх болсон нөхцөл, орсон өөрчлөлтүүд, чанарын менежментийн тогтолцоо, эрсдэлд суурилсан сэтгэлгээг хөгжүүлэх, чанарын зорилтууд түүнд хүрэх төлөвлөлт ба хяналт, удирдлагын дүн шинжилгээний ойлголтуудыг танилцуулсан.



Зураг 8.5. Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага ISO 9001:2008 –аас ISO 9001:2015 стандартад шилжих төслийн танилцуулга

- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс 2018 оны 4 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд мэргэшсэн олон улсын эксперт, ЮНЕСКО-ийн Олон улсын боловсрол төлөвлөлтийн институтын хөтөлбөрийн мэргэжилтэн Микаела Мартинийг урьж, зохион байгуулсан **“Чанарын дотоод баталгаажуулалт”** сэдэвт суралтанд оролцсон. Сургалт нь “Чанарын дотоод баталгаажуулалтын агуулга тодорхойлолт, зарчим, хандлага, чанарын дотоод баталгаажуулалт их дээд сургуулийн чанарын менежментэд гүйцэтгэх үүрэг, чанарын дотоод баталгаажуулалтыг багшлахуй, суралцахуйд ашиглах нь” дэд сэдвээр явагдаж, сургалтанд оролцогчтой санал солилцов.

8.3. ДОТООД АУДИТ

Хүснэгт 8.1

№	Гүйцэтгэсэн ажил	Хүрсэн үр дүн	Хугацаа
I. Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг			
1	ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн тогтоолоор Дотоод хяналтын алба байгуулагдаж Дотоод хяналтын албаны дарга, дотоод аудиторын бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдсан.	Дотоод хяналтын албаны зорилго зорилтыг тодорхойлж ажлын цар хүрээг тодорхойлов.	2017оны 8-р сар
2	Дотоод хяналтын албаны чиг үүргийн загвар гаргаж хяналт шалгалтын ажлын горим боловсруулсан.		2017оны 9-р сар
3	Дотоод хяналтын албаны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан.		2017оны 9-р сар

4	Дотоод хяналтын албаны 2017-2018 оны ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулав.		2017оны 9-р сар
5	2013-2014 оны захиргаа мониторингийн ажлын баримтуудыг цэгцэлж үдэж архивт хүлээлгэн өгөв.	Архивын бичиг хэргийн хөтлөлтийг сайжруулах	2017 оны 10 сар
6	ГУУС-ийн 2016-2017 онуудад санхүүгийн хяналт шалгалт явуулах удирдамж бэлтгэн сургуулийн удирдлага, санхүүгийн ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулав.		2017 оны 10 сар
7	ГУУС-ийн 2015-2016 оны хавар 2016-2017 оны намар 2016-2017 оны хаврын улирлын 120 багшийн цагийн тооцоо, хичээлийн ачаалал, хичээл зохицуулалтыг шалгав.	Холбогдох ажил хариуцсан хүмүүстэй нь заавар зөвлөмж өгч ажиллав.	2017 оны 10 сар
8	2016 оны 2466, 2017 оны 2271 оюутны төлбөрийн тооцоог тулган баталгаажуулав.		2017 оны 11 сар
9	Нийт 12 төвийн 2016-2017 онуудад хэрэгжүүлж буй 2055,2 сая төгрөгийн төсөл гэрээт ажлуудын тулган баталгаажуулалт хийж төсөл гэрээт ажлын үр дүнг гаргав.	Төвүүдийн захирал, төслийн удирдагч нарт санхүүгийн зөвлөгөө өгөв.	2017 оны 11 сар
10	2016-2017 онуудын төсвийн орлого зардал зарцуулалт, үр ашигтай байдалд хяналт хийж, хасах үр дүнтэй ажилласан шалтгааныг тодруулж шинжилгээ хийв.		2017 оны 12 сар
11	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн газартай хамтран ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын ахлах нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулж нийтлэг гарч байгаа зөрчил дутагдлыг танилцуудж анхаарах асуудлыг хэлэлцэв.	Санхүүгийн үйл ажиллагааг УСНББОУС, бусад хууль дүрэм журмыг хангаж ажиллуулах	2017 оны 12 сар
12	ШУТИС-ийн хэмжээнд ажиллаж байгаа нийт ахмад гэрээт багш нарын цалингийн судалгаа хийв.		2017 оны 12 сар
13	БУХС-ийн 2014-2016, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн хяналт шалгалт явуулах удирдамж бэлтгэн сургуулийн удирдлага, санхүүгийн ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулав.		2017 оны 12 сар
14	ҮАГ-ын санхүүгийн аудитын шалгалтын явцад санхүүгийн тайлангийн аудитын журам зааврын хүрээнд ШУТИС-ийн дотоод хяналтын систем, санхүүгийн үйл ажиллагаанд асуулга, ярилцлага, тодруулгыг бэлтгэж хамтран ажилласан.		2018 оны 1 сар
15	БУХС, БАТС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль/2014-2017оны эхний хагас жил / Бизнесийн ахисан түвшиний сургууль /2014-2017оны эхний хагас жил / хугацаагаар явуулж төсвийн орлого зардал, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, өр авлага түүний барагдуулалт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж дүгнэлт зөвлөмж өгсөн.	Шалгалттай холбоотой зөвлөмж гаргасан.	2018 оны 1 сар
16	Дотоод хяналтын албаны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор дотоод аудитын албаны дарга, дотоод аудитор, бүртгэлийн		2018 оны 2 сар

	мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан		
17	Эрдэм шинжилгээ сургалтын 39 төв, 5 хүрээлэнгийн тайлангийн хэлэлцүүлэгт оролцож, санхүүгийн дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж дүгнэлт зөвлөмж өгсөн.	Зөвлөмж өгсөн.	2018 оны 3 сар
18	Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн төвүүдийн өр авлага барагдуулах явцын тайлангийн хуралд оролцож дүгнэлт зөвлөмж өгсөн.		2018 оны 4 сар
19	Бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн ажилтнуудад бүрэлдэхүүн сургуулиудад гарч байгаа нийтлэг алдаа зөрчил дутагдлын талаар мэдээлэл хийж цаашид анхаарах зөвлөмжийг өгөв. • ГУУС, БУХС-ийн дотоод аудитын тайлангийн мэдээллийг захиргааны зөвлөлд хэлэлцүүлэв. • ГУУС, БУХС-ийн дотоод аудитын тайлангийн мэдээллийг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж нэгдсэн дүгнэлт зөвлөмж гаргав.	Захиргааны зөвлөлөөр хэрэгжүүлсэн. Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	2018 оны 5 сар
20	Барилга, архитектурын сургууль • Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн 2016-2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд, хяналт шалгалтыг явуулж байна Хяналт шалгалтыг профессор багш нарын кредит цагийн тооцоо, төсвийн орлого зардал, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, өр авлага түүний барагдуулалт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж дүгнэлт зөвлөмж өгөх зарилгоор хийж байна.	Ажил хариуцсан хүмүүстэй нь уулзаж тодруулга авч зөвлөмж өгсөн.	2018 оны 5-6 сар
II. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар			
1	2017 оны эрдэм шинжилгээний ажлын тайлан хэлэлцэх комисс		2018 оны 3 сар
Мэргэжлийн мэдлэг чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдал			
2	Стандарт, хэмжилзүйн газар болон Монголын худалдааг дэмжих төслөөс зохион байгуулсан “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг төрийн байгууллага болон төрийн өмчид байгууллагуудад танилцуулах семинарт дотоод аудитор А.Өнөрзул оролцсон.	Үндсэн чиг үүргийн ажилдаа хэрэгжүүлж байна.	2018 оны 5-р сар



ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1

УЛСЫН ЗАХИАЛГАТ ТӨСЛҮҮДИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ /2017-2018/

Д.Д	Төслийн төрөл	БС	Төслийн нэр	Төслийн удирдагчийн нэр	Хэрэгжих хугацаа	Санхүүжилт /мин.төг/	2017 онд олгох	Олгосон нь
1	Хамтарсан төсөл	МХТ С	Хувьсах хурдтай утасгүй орчинд видео дохионд суурилсан авто замын хяналтын систем	Б.Дамдинсүрэн	2014-2017	54000\$	-	
2	ОХУ хамтарсан төсөл	ГУУС	Плюм-литосферийн харилцан үйлчлэлийн эхэн ба төгсгөлийн шатандах шүтлэг базальтын магмын эх үүсвэр, гарал үүсэл /Хойд Монголын Кайнозойн базальтын жишээнд	Д.Бат-Өлзий	2016-2017	6,000.0	2,970.0	2,970.0
3	ССТ	МХТ С	Ерөнхий боловсролын ахлах сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүн	Б.Зоригтбаатар	2017-2018	10,000.0	3,960.0	3,960.0
4	Докторын дараах инноваци	ҮТС	Бактерийн эсрэг үйлчлэлтэй, хүнсний хуванцар сав баглаа боодлын материалын судалгаа	Г.Солонго	2016-2017	10,000.0	4,950.0	4,950.0
5	Докторын дараах инноваци	БуХС	Улаанбаатар хотын иргэдийн зорчих эрэлтийг судалж, сүлжээ төлөвлөлтийг боловсронгуй болгох төсөл	Х.Булгаа	2016-2017	10,000.0	4,950.0	4,950.0
6	Докторын дараах инноваци	ХШУ С	Молибденитын гадаргууд нанолитографи хийх технологи	Г.Мөнхсайхан	2016-2017	10,000.0	4,950.0	4,950.0
7	Докторын дараах инноваци	ХШУ С	Цахилгаан станцын хаягдал үнснээс хөнгөн цагаан ба цахиурын оксид гарган авах судалгаа	Б.Тунгалагтамир	2017-2018	10,000.0	4,950.0	4,950.0
8	ОХУ хамтарсан төсөл	БуХС	Монгол Оросын жишээн дээр Байгалийн тусгай хамгаалалттай бүс дэх аялал жуулчлал болон экологийн баримжаат бизнесийг дэмжих арга механизмыг боловсруулах	Г.Баттүвшин	2016-2018	12,000.0	3,960.0	3,960.0
9	ССТ	ХШУ С	Зарим металлын нанобөөм болон тэдгээрт суурилсан нанокомпозит полимер материалын судалгаа	Г.Цэрмаа	2015-2017	19,000.0	5,940.0	5,940.0
10	ССТ	ЭХС	Монгол орны нөхцөлд нарны халаалтын системд ашиглах улирлын чанартай дулааны хуримтлуурын харьцуулсан судалгаа, оновчтой хувилбар сонгох судалгаа	Ч.Мангалжалав	2017-2018	27,000.0	6,930.0	6,930.0
11	ССТ	ГУУС	Хур тундас татруу байх үеийн уур амьсгалын онцлог, тооний экосистемд үзүүлэх эрсдэлийн судалгаа	Р.Мижиддорж	2015-2017	27,800.0	10,098.0	10,098.0

12	ССТ	БүХС	Компьютер тоглоомын хамааралд нөлөөлөх хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх арга зам	Д.Цогзолмаа	2015-2017	30,000.0	10,098.0	10,890.0
13	ССТ	ДТҮЭ Х	Монголын эрчим хүчний нэгдсэн системийн хөгжлийн загвар боловсруулах нь	С.Батмөнх	2017-2019	38,180.0	7,484.4	7,484.4
14	ШУТТ	ХҮСХ Х	Богино ширхэгтэй ноолуураар ээрмэл үйлдвэрлэх оновчтой шийдэл	Г.Надмид	2016-2018	42,100.0	13,909.5	-
15	Өмнөд солонгостой хамтарсан төсөл	ГУУС	Уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн хөтөлбөрийг боловсруулах	Б.Батболд	2017-2019	43,600.0	14,355.0	14,355.0
16	ШУТТ	ҮТС	Зохицуулах үйлчилгээ бүхий 63 бэлдмэлийн технологийн судалгаа хийх	Я.Алтанцэцэг	2016-2018	59,000.0	20,790.0	35,674.0
17	ШУТТ	ҮТС	Коллаген агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх өндөр технологийн судалгаа	Б.Энхтуяа	2017-2018	60,800.0	5,940.0	5,940.0
18	Инноваци	ҮТС	Монгол чацарганаас эрүүл мэндийг дэмжих үйлчилгээтэй хүнсний нэмэлт бүтээгдэхүүн гарган авах	Г.Төрмөнх	2016-2018	71,500.0	23,017.5	23,017.5
19	ШУТТ	ХҮСХ Х	Нэхмэлийн үйлдвэрийн хими технологийн боловсруулалтанд хэрэглэдэг зарим материалыг байгалийн гаралтай түүхий эдээр орлуулан хэрэглэх технологийн судалгаа	Г.Надмид	2016-2018	74,900.0	31,653.3	-
20	ШУТТ	ГУУС	Монгол орны газрын ховор элементийн ордын хүдрийг баяжуулах технологи боловсруулах	Д.Энхбат	2016-2018	83,500.0	33,165.0	49,995.0
21	Инноваци	ДТҮЭ Х	Амины орон сууц, бие даасан хэрэглэгчдийн халаалтанд ашиглах фазын шилжилтийн дулааны аккумулятор	Б.Одонхишиг	2016-2018	89,300.0	31,828.5	31,828.5
22	Инноваци	ОУД БСТ	Монголын үндэсний их дээд сургуулиудын эрэмбэ тогтоох аргачлал боловсруулах	Ц.Оюун	2016-2017	90,000.0	54,450.0	54,450.0
23	Инноваци	ҮТС	Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ, шим тэжээлийн менежментийг сайжруулах, тархины нөхөн төлжилт, эргэн сэргэлтийг хангах зохицуулах үйлчилгээтэй хоол, хүнсний үйлчилгээ бий болгох туршилтын загвар	Ж.Балжинням	2017-2019	90,000.0	26,235.0	26,235.0
24	ШУТТ	ДТҮЭ Х	Эргэлдэх буцлах давхаргатай зуухны горимыг судлан бүтээмжийг тодорхойлох	С.Батмөнх	2016-2018	90,000.0	36,369.6	51,253.6
25	ШУТТ	ҮТС	Монгол хонины бүдүүн ноосны ноолууран ширхэгтээр нэхмэл материал үйлдвэрлэх технологи	М.Баяр	2016-2018	97,300.0	37,620.0	37,620.0
26	ШУТТ	ҮТС	Уламжлалт болон өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний химийн найрлага, физик-химийн шинж чанар, хүнс-тэжээл, эрүүл ахуйн аюулгүй байдлын үнэлгээний олон улсын стандарт,	Ж.Туяацэцэг	2016-2019	115,200.0	44,550.0	44,550.0

			аргачлалыг нутагшуулах, мэдээллийн сан бүрдүүлэх					
27	ШУТГ	Е-НИ	Шинжлэх ухаан, технологийн салбарын мэдээлэл, удирдлагын системийг боловсруулах	Р.Төрбат	2016-2018	117,000.0	44,550.0	44,550.0
28	ШУТГ	ҮТС	Хүүхдийн гутал	Л.Удвал	2017-2019	118,000.0	9,900.0	9,900.0
29	Инноваци	ДТҮЭХ	Хот суурин агаарын бохирдлыг бууруулах арга технологи	С.Батмөнх	2017-2018	120,000.0	60,000.0	59,400.0
30	ШУТГ	ГУУС	Субдукцийн бүсийн геологи, магматизм, хүдэржилтийн судалгаа, хэтийн төлөв	Б.Мөнхцэнгэл	2016-2019	128,700.0	51,579.0	51,579.0
31	Тайвангтай хамтарсан төсөл	МХТС	Микро шингэн дэх бактерийг цахилгаан диалектикийн аргаар таних	И.Цэрэн-Онолт	2017-2019	54000\$	21,881.2	21,881.2
32	ШУТГ	ОМСХХ	Ойн цэвэрлэгээгээр гарах хоёрдогч түүхий эдийн технологийн үзүүлэлтүүдийн судалгаанд тулгуурлан төрөл бүрийн зориулалттай технологийн цавчдас үйлдвэрлэх	Н.Долгорхүү	2017-2019	48,500.0	7,500.00	23,000.00
33	ШУТГ	ЭХС	Алслагдсан төв суурин газрын дулаан хангамжийг байгаль орчинд ээлтэй аргаар шийдэх техникийн шийдэл, хэрэгжилт	Ч.Мангалжав	2017-2018	90,000.0	8,500.0	
34	ШУТГ	МХТС	Цахилгаан соронзон долгионы бохирдлын төлөв, байдал, бохирдол бууруулах судалгаа	Н.Эрдэнэхүү	2017-2019	40,000.0	10,000.0	
35	ШУТГ	ГУУС	Сэргээгдэх эрчим хүчний технологийн түүхий эдийн судалгаа	С.Жаргалан	2017-2019	80,000.0	6,000.0	
36	Өмнөд солонгостой хамтарсан төсөл	МХТС	Өндөр мэдрэмжтэй, алдаа багатай периметр хамгаалалтын системийн хөгжүүлэлт	А.Одгэрэл	2015-2017	35100	11,583.0	11,583.0
37	Өмнөд солонгостой хамтарсан төсөл	ҮТС	Биобэлдмэл, биологийн идэвхт нэмэлтээр баяжуулсан зохицуулах үйлчлэлтэй цагаан идээний технологи боловсруулалт	Ч.Цэнд-Аюуш	2015-2017	35100	11,583.0	11,583.0
38	Оростой хамтарсан төсөл	БүХС	Ашигт малтмалын уурхайн хаягдлыг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах инновацийн механизм /ОХУ, Монгол улсын уулын баяжуулах үйлдвэрийн жишээн дээр	Л.Оюунцэцэг	2015-2017	12000	3,960.0	3,960.0
39	Оростой хамтарсан төсөл	ГХИ	Монгол улсын орчин үеийн залуучуудын нийгмийн ухамсар	Т.Батбаяр	2015-2017	12000	3,960.0	3,960.0
40	Сэдэвт ажил	МХТС	Монгол хэлний үргэлжилсэн яриа таних систем зохион бүтээх	Б.Дамдинсүрэн	2015-2017	30000	-	-

41	Тайван ьтай хамтар сан төсөл	ХШУ С	Өгийнуур, Тэрхийн Цагаан нуур болон Хөвсгөл нуурын усны чанар, экологийн төлөв байдалд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлж буй нөлөөг Тайваны усан сангуудтай харьцуулан судлах нь	Т.Улаанбаатар	2015- 2018		18000\$	18000\$
42	Сэдэвт ажил	ҮТС	Ээрэх үйлдвэрлэлийн эмульсжүүлэлтийн диффузлэлт болон тархалтын орон зайн бүтцийг кератин ширхэгтийн эд мембраны комплексийн чөлөөт эзэлхүүнд тогтворжуулах судалгаа	Д.Энхтуяа	2015- 2017	27300	9,009.0	9,009.0
43	Сэдэвт ажил	ХҮСХ Х	Арьс боловсруулалтын явц дахь РН -ын хэлбэлзэл ба колагены хөөлтийн зэргийг бууруулах судалгаа	С.Дашбал	2015- 2017	44100	16,879.5	16,879.5

ХАВСРАЛТ 2

Эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээлийн дэлгэрэнгүй мэдээлэл

1. Шинэ бүтээлийн патент			
№	Бүтээлийн нэр	Бүтээлийн зохиогч	Сургууль
1	Шатаагаагүй цайрын баяжмалаас цайрын оксид гарган авах арга	С.Мягмарсүрэн А.Цэцэгмаа	ХШУС
2. Ашигтай загварын гэрчилгээ			
№	Бүтээлийн нэр	Бүтээлийн зохиогч	Сургууль
1.	"Жимс жимсгэнэ угааж, ариутгах төхөөрөмж"	Г.Чимэд-Очир	Механик тээврийн сургууль
2.	"Эсрэг ачаа бүхий сур элдэх хүндийн хүчний төхөөрөмж"	Я.Ренчинванжил	
3.	"Сагстай өргөгчийн даац хязгаарлагч"	Д.Батсүх	
4.	"Агаарын орчны мэдээ цуглуулагч автомат төхөөрөмж"	Б.Дондогжамц, Б.Эрдэнэбат	
5.	"Даралтын зөрүүгээр салгах аппарат"	Б.Дондогжамц, Б.Эрдэнэбат	
6.	"Хүчит тэжээлийн жижигрэлтийн модуль тодорхойлох төхөөрөмж"	Б.Батмөнх, Т.Хэрүүга нар	
7.	"Хүрдэн төрлийн хэрчих аппаратын параметр судлах төхөөрөмж"	Б.Батмөнх, Д.Бямбацогт нар	
8.	"Цант төрлийн хэрчих аппаратын параметр судлах төхөөрөмж"	Б.Батмөнх, Г.Батбаяр нар	
9.	"Тэжээл солих процесс судлах шинэ төхөөрөмж"	Б.Батмөнх, Г.Батбаяр нар	
10.	Хөдөлгүүр генераторын системийн цахилгаан үүсгүүрээс эрчим хүч үүсгэх арга	Я.Бат-Очир	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль
11.	Бүхэл үрийн гурилын боорцог	Ц.Минжмаа Д.Цэцгээ	Үйлдвэрлэлийн технологийн сургууль
12.	Шар сүүний ундаа үйлдвэрлэх арга	Ц.Сэлэнгэ Х.Мөнхзаяа С.Дэлгэрмаа Д.Долгөөн А.Оюун-Эрдэнэ Б.Одонтуяа	
13.	Шимийн архи /цагаа/ нэрэх суурин төхөөрөмж	Ч.Сайнбуян Ж.Балжинням	
14.	Лабораторийн зориулалттай хатаах төхөөрөмж	Б.Найгалмаа, Б.Золжаргал	
15.	"Хайрсан далавчит хөнөөлт шавьжинд өвчин үүсгэгч бактерийн нутгийн омог ВТА-М17"	С.Дэлгэрмаа /тус бүр нэг/ Б.Нандин-Эрдэнэ, Д.Пүрэвдорж	
16.	"Бактерийн эсрэг үйлчлэлтэй полимер хальс"	Г. Солонго С.Амаржаргал	
3. Зохиогчийн эрхийн гэрчилгээ			
№	Бүтээлийн нэр	Бүтээлийн зохиогч	Сургууль
1.	"Өсвөр насныхны дундах дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нийгмийн ажил" гарын авлага	С.Туяа Н.Ариунтуяа Т.Оюунбилэг Ж.Нямаа А.Нарангэрэл С.Ариунцэцэг Д.Юмжирмаа	Бизнесийн удирдлага,

2.	“Өсвөр насныхны дундах дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нийгмийн ажлын хөтөлбөр”	С.Туяа Н.Ариунтуяа Т.Оюунбилэг Ж.Нямаа А.Нарангэрэл С.Ариунцэцэг Д.Юмжирмаа	хүмүүнлэгийн сургууль
3.	"Насжилт ахмад настны нийгмийн хамгаалал"	С.Туяа	
4.	“Олон нийттэй харилцах ажил”	Б.Долгор, Я.Төгөлдөр, Д.Одмаа, Д.Мягмарсүрэн, М.Жаргалсайхан, Ж.Буянхшиг	
5.	“Улс төр судлал сурах бичиг”	Б.Долгор, Я.Төгөлдөр, Д.Одмаа	
6.	Стратегийн менежмент	Х.Пүрэвдавга Л.Цэрэнчимэд Д.Ганбаатар Л.Цэрэнчимэд Д.Оюунчимэг	
7.	“Шаврын нунтаглалтын хэмжээ өрмийн уусмалын шинж чанарт нөлөөлөх нөлөөлөл”	Д.Ундармаа	Геологи уул уурхайн сургууль
8.	“Өрөмдлөгийн бентонит шаврын солилцлын ионы судалгаа	Д.Ундармаа	
9.	“Өрөмдлөгийн импортын бентонит шаврын шинж чанарын судалгаа”	Д.Ундармаа	
10.	“Хийн аж ахуйн шугам хоолой”	Б.Наранцэцэг	
11.	“Analysis of clay minerals and clay fabric and its effects on the petrophysical properties of the seafloor sediments”	Б.Наранцэцэг	
12.	“Fracture orientation and induced anisotropy of gas hydrate-bearing sediments in seismic chimney-like-structures of the ulleung basin, East Sea”	Б.Наранцэцэг Gil Young Kim	
13.	“Fracture and breakouts analysis from borehole image logs: preliminary results for interpretation of stress history and in Situ stress state”	Б.Наранцэцэг Gil Young Kim	
14.	“Physical property variations related to seismic units in the offshore sediments of the heuksan mud belt, southeastern yellow sea, Korea”	Б.Наранцэцэг Gil Young Kim Jin-Wook Kim	
15.	“Physical properties and micro-and macro-structures of gassy sediments in the inner shelf of se Korea”	Б.Наранцэцэг Gil Young Kim Jin-Wook Kim	
16.	“Physical and geotechnical properties of drill core sediments in the Heuksan mud belt off SW Korea”	Б.Наранцэцэг Gil Young Kim	
17.	“Газарзүйн мэдээллийн системийн практик хичээл”	С.Жаргалмаа Д.Оюунцэцэг Б.Жавзандулам	
18.	“Ул хөрсний тооцоолол”	Б.Батбаясгалан Я.Болормаа	
19.	“Метал ашигт малтмал”	Б.Энхжаргал С.Жаргалан Д.Алтанхуяг	
20.	“Инженерийн лавлах” 13	Б.Энхжаргал Г.Сэрмаа Б.Мөнхцэнгэл Б.Батхшиг О.Жавхлан С.Хишигсүрэн Ж.Лхамсүрэн Ж.Ундарьяа С.Оюунгэрэл Г.Ухнаа П.Нарантуяа Б.Алтанзул О.Гэрэл С.Жаргалан Д.Лхагвадорж Д.Чулуун Д.Бат-Өлзий О.Мөнхцэцэг Д.Алтанхуяг Ө.Бүрэнжаргал	

21.	Play D&B	Б.Сод-Од Л.Мөнхдэмбэрэл М.Галиндэв	Мэдээлэл холбооны технологийн сургууль
22.	Play Dispatch	Б.Сод-Од Л.Мөнхдэмбэрэл М.Галиндэв	
23.	Play Mine	Б.Сод-Од Л.Мөнхдэмбэрэл М.Галиндэв	
24.	Ухаалаг ангийн MonSC-75	Г.Мөнхбат Б.Сүхбат Х.Тамир А.Алтангэрэл Б.Зоригтбаатар	
25.	Газар ашиглалт бүртгэлийн систем LURS	Б.Батзолбоо Б.Мөнхбуян	
26.	Ажлын зураг хөтлөх хэрэгсэл /Templatemap Tool/	Б.Батзолбоо Б.Мөнхбуян	
27.	UML 2: Объект хандлагат шинжилгээ ба түүний хэрэглээ	Б.Батзолбоо	
28.	WWW.goo-s.mn мэдээлэл худалдааны вэб сайт	Д.Энжаргал Б.Батзолбоо	
29.	RF_SW_17	Д.Эрдэнэчимэг Н.Чулуунбаатар	
30.	TinyOS-NesC-1.0	Д.Эрдэнэчимэг Н.Чулуунбаатар Т.Амартүвшин Б.Энхбат О.Мөнхтамир Б.Энхдаваа	
31.	LED_MMS	Д.Эрдэнэчимэг Н.Чулуунбаатар Ц.Сүгир	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
32.	Хэрэглээний математик I	Д.Батнасан, Б.Ууганбаяр, Ц.Мөнх-Эрдэнэ, Д.Ганзориг, Д.Цэдэнбаяр, Я.Лутбат	
33.	Хэрэглээний математик II	Я.Базарсад, Б.Тайгынтуяа, Б.Батгэрэл, Ц.Балжинням, В.Өлзийбаяр, В.Батзориг, Ө.Пэрэн, Т.Баиртөгс	
34.	Төмөртийн овооны цайрын баяжмалыг боловсруулах судалгаа" нэг сэдэвт бүтээл	С.Мягмарсүрэн	
35.	"Тамсагбулагийн нефтийг дулааны аргаар боловсруулах технологийн судалгаа" нэг сэдэвт бүтээл	Д.Хандмаа	
36.	"Молибдений баяжмалыг боловсруулан түүний зарим нэгдлүүдийг гарган авах судалгаа" нэг сэдэвт бүтээл	А.Сарнай	
37.	"Study on doped mesoporous carbons as non-Pt catalyst for oxygen reduction reaction in the PEMFC" нэг сэдэвт бүтээл	Б.Өлийдэлгэр	
38.	"Хатуу түлшний боловсруулалтын технологи" сурах бичиг	Э.Энхцэцэг, Б.Бямбагар, Н.Баттулга	

39.	“Ерөнхий хими” сурах бичиг	П.Мөнхбаатар, Б.Бямбагар, Ж.Бүдсүрэн, И.Сүхбаатар А.Сарнай, Г.Саран, Т.Баттөмөр	
40.	“Органик хими” сурах бичиг	Б. Бямбагар, М.Наранцэцэг, Д.Хандмаа, Э.Энхцэцэг, Н.Баттулга	
41.	“Органик хими дасгал, бодлогын хураамж” гарын авлага	Б.Тунгалагтамир Э.Бат-Эрдэнэ, Х.Серикжан, Х.Золтуяа	
42.	“Ерөнхий химийн бодлого дасгалын хураамж” гарын авлага	Ю.Ганчимэг, О.Отгонтуул, Ч.Гүнчин, Р.Долгоржав, С.Мягмарсүрэн	
43.	“Химийн үйлдвэрийн процесс ба аппаратын тооцоо” гарын авлага	Ю.Ганчимэг А.Доржготов, Д.Хандмаа	
44.	“Органик бус химийн бодлого, дасгалын хураамж” гарын авлага	А.Сарнай, Б.Бямбагар	
45.	Физик 1 хичээлийн семинарын гарын авлага	Г.Мөнхсайхан, О.Сүх, Н.Насанбат, Д.Наранчимэг, Б.Одонтуяа	
46.	Физик 2 хичээлийн семинарын гарын авлага	Г.Мөнхсайхан, О.Сүх, Н.Насанбат, Д.Наранчимэг, Б.Одонтуяа	
47.	“Физикийн хялбаршуулсан тулгуур лавлах”	Б.Доржсүрэн	
48.	“Хэрэглээний физик” хичээлийн гарын авлага	Б.Доржсүрэн	
49.	“Хугацаанаас хамаарсан Шредингерийн тэгшитгэлийг Дискрет хувьсагчийн аргаар тооцоолох программ”	Г.Зоригт, Л.Хэнмэдэх, Ч.Алдармаа	
50.	“Хугацаанаас хамаарсан Шредингерийн тэгшитгэлийг Псевдоспектриал аргаар тооцоолох программ”	Г.Зоригт, Л.Хэнмэдэх, Ч.Алдармаа	
51.	Хүнсний сав баглаа боодлын материал ба дизайн	Ч.Сайнбуян Ж.Балжинням Ж.Туяацэцэг Ч.Авдай Д.Хөхөө П.Алтанцэцэг Д.Ургамал П.Болд	Үйлдвэрлэлийн технологийн сургууль
52.	Хүнс үйлдвэрлэлийн процесс аппарат	Ч.Сайнбуян Ж.Балжинням Ж.Туяацэцэг Б.Найгалмаа Д.Хөхөө Ж.Сүрэн Н.Чимэдрэгзэн Ч.Норов	
53.	“Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмж” виртуаль лаборатори	Ч.Сайнбуян Ж.Балжинням Н.Чимэдрэгзэн	
54.	Монгол улсын хүнсний сав баглаа боодлын систем	Ч.Сайнбуян Д.Хөхөө П.Бадрал Н.Эрдэнэцогт Д.Бадамдорж Б.Гэрэл	
55.	“Remote detection method for illegal electricity usage based on extended smart meters and inspection robot” Зохиогчийн эрхийн гэрчилгээ	Бя.Бат-Эрдэнэ	Эрчим хүчний сургууль

56.	"iRobot Greate" хөдөлгөөнт роботын систем" Зохиогчийн эрхийн гэрчилгээ	Бя.Бат-Эрдэнэ	Е-Нээлттэй институт
57.	"Алгоритм ба програмчлалын үндэс"	Г.Ганчимэг	
58.	"Ул хөрсний тооцоолол"	Ж.Алимаа ба бусад	
59.	"Уурхайн зургийн автоматжуулалт" электрон хичээл.	Ж.Алимаа	
60.	"AutoCAD алхам алхмаар"	Ж.Алимаа ба бусад	
61.	"Онлайн сургалтын агуулга хөгжүүлэх арга зүйн судалгаа"	Ж.Алимаа	
4.Бүтээгдэхүүний загварын патент			
᠑	Бүтээлийн нэр	Бүтээлийн зохиогч	Сургууль
1	"Цахилгаан товчтой өндгөвч, түрий"	В.Алимаа	Геологи уул уурхайн сургууль
2	Зохион бүтээх утсралтын иж бүрдэл ширээ "Туяа" бүтээгдэхүүний загварын патент	Ц.Эрдэнэтуяа	Эрчим хүчний сургууль
3	"Эрүүл мэндийн зориулалттай ноолууран дотуур хувцас"	А.Батсайхан Г.Надмид М.Эрдэнэтуяа	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн

ХАВСРАЛТ 3

ШУТИС-ИЙН ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ҮНЭЛГЭЭ /2015-2017/

БС	№	Төвийн нэр	Төвийн захирал	Үнэлгээний дундаж оноо
БАС (9)	1	Геотехникийн судалгааны төв	С.Нямдорж	85.13
	2	Зураг төсөл, оношилгооны Реконстракшн төв	Я.Дүйнхэржав	85.80
	3	Авто замын сургалт судалгааны төв	Р.Болормаа	34.20
	4	Барилгын дэвшилтэт материал, бүтээцийн судалгааны төв	Д.Сүнжидмаа	72.70
	5	Барилгын эрчим хүч хэмнэлтийн сургалт судалгааны төв	Б.Мөнхбаяр	65.00
	6	Зураг төсөл судалгааны төв	Э.Пүрэв-Эрдэнэ	64.80
	7	Барилга, замын технологи, эдийн засаг, төсвийн нормчлолын судалгааны төв	С.Ганболд	68.30
	8	Autodesk-ийн эрх бүхий сургалтын төв	Н.Саранчимэг	66.40
	9	Усны судалгааны төв	Д.Басандорж	26.25
БуХС (1)	10	Жижиг дунд үйлдвэрлэлийн сургалт, судалгааны төв	Л.Оюунцэцэг	75.90
ГУУС (13)	11	Стратиграфи, палентологийн судалгааны төв	Г.Сэрсмаа	72.70
	12	Уул уурхайн төсөл судалгааны төв	С.Цэдэндорж	70.40
	13	Экологи тогтвортой хөгжлийн төв	Р.Мижиддорж	62.50
	14	Уурхайн инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтын төв	Ц.Нанзад	74.38
	15	Геофизикийн сургалт, үйлдвэрлэл, судалгааны төв	П.Дугараа	50.42
	16	Уурхайн төлөвлөлт, үнэлгээ, судалгааны төв	Я.Дашдондог	46.80
	17	Уурхайн судалгаа, хөгжлийн төв	Б.Батболд	71.00
	18	Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл, сургалтын төв	Г.Ухнаа	69.60
	19	Геологийн шинжлэх ухааны төв	О.Гэрэл	79.75
	20	Газрын тосны сургалт-судалгаа-мэдээллийн төв	Ж.Цэвээнжав	61.88
	21	Антрактид судлалын төв	Л.Дүгэржав	52.67
	22	Тээлгээ, технологийн төв	Ц.Ариунжаргал	54.83
	23	Нагояа хээрийн судалгааны төв	Н.Манчук	41.67
ДаТС (3)	24	Барилгын материалын судалгааны төв	Х.Жанчивдорж	81.00
МехТС (3)	25	Металлын сорилт, туршилт, эрдэм шинжилгээний төв	Д.Цолмонбаатар	81.07
	26	Техник технологийн туршилт судалгааны төв	Г.Чимэд-Очир	67.50
МХТС (1)	27	Мэдээлэл, холбооны технологийн сургалтын төв	Энхтөгс	60.25
ҮТС (4)	28	Шим тэжээл судлалын төв	Ц.Зууннаст	74.13
	29	Хувцас судлалын төв	Д.Ариунболор	88.20
	30	Shima seiki training center	Д.Энхтуяа	74.80
	31	Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв	Г.Төрмөнх	78.13

ХШУС (3)	32	Материал судлалын төв	Г.Саран	89.75
	33	Үл эвдэх сорилын төв	Б.Түмэндэмбэрэл	68.63
	34	Системийн судалгааны төв	Б.Очирбат	52.8
ЭХС (6)	35	Зуухны туршилт, судалгааны төв	Ж.Цэен-Ойдов	84.40
	36	Үйлдвэрлэлийн процессийн автоматжуулалт, туршилт судалгааны төв	Ч.Нацагдорж	68.92
	37	Эрчим хүчний хэмнэлтийн судалгааны төв	Д.Содномдорж	90.10
	38	Хөргүүрийн технологийн судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн төв	Ч.Мангалжалав	82.50
	39	Дулааны хэрэглээний дэвшилтэт техник, технологийн судалгааны төв	Б.Намхайням	70.00
	40	Эрчим хүчний эх үүсвэр, хүрээлэн буй орчны судалгааны төв	Х.Энхжаргал	66.67
ХҮСХХ (1)	41	Сорилтын төв	Р.Баднаанямбуу	75.00

